

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
БОЛОВСРОЛ II
ТӨСӨЛ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ БА
ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН МОДУЛЬ

ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ

Улаанбаатар хот
2023

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ БА ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН МОДУЛЬ

СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ

**Үндэсний сургагч багш, ЕБС-ийн багш, 11-14 насны
үе тэнгийн сургагч хүүхдүүдэд зориулав.**

Улаанбаатар хот
2023

ННА 74.2
ДАА 373
Т-441

ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



Энэхүү сургалтын модулийг Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн түшиц байгууллага-Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, төслийн хэрэгжүүлэгч байгууллага-Байгаль орчны мэдээлэл, сургалтын төвтэй хамтран хэвлүүлэв.

Зөвлөх баг: С.Санжаабадам, Х.Энхжаргал, О.Мөнхжин, А.Мөнхмагнай

Боловсруулсан баг: Х.Булганзаяа, А.Цолмон, Б.Дуламсүрэн

Редакторын баг: А.Энхтогтох, Э.Шинэцэцэг, Б.Оюунцэцэг

Цахим хөгжүүлэлтийн баг: Б.Баярсайхан, А.Мөнхмагнай

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Энхтунгалаг
Хавтасны дизайнер: Ч.Эрдэнэбат
Цаасны хэмжээ: 70х100/16
Хэвлэлийн хуудас: 10.33 хх
Хэвлэлийн “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-9004-0-3

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

ТАНИЛЦУУЛГА

Тогтвортой Хөгжлийн Боловсрол (ТХБ) болон Дэлхий Иргэний Боловсрол (ДИБ) нь “ТХ-ийн зорилго 4”-ийн нэгэн хэсэг бөгөөд ялангуяа ТХ-ийн Зорилго 4.7-д тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, энх тайван, үл хүчирхийллийг дэмжих, дэлхийн иргэншил болон соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндлэх талаар тусгасан байдаг. Энэхүү сургалтын модуль нь дээрх зорилтуудыг өдөр тутмын амьдралын үйл ажиллагаатай уялдуулан ойлгох, ур чадвар эзэмшихэд танд туслах юм.

ТХБ ба ДИБ-ыг дараах утгаар тайлбарлаж болно.

- *Тогтвортой Хөгжлийн Боловсрол (ТХБ)* нь хүн бүр соёлын олон янз байдлыг хүндэтгэхийн зэрэгцээ одоо болон ирээдүй үеийн төлөө хүрээлэн буй орчноо хэвээр үлдээж, хүчирхэг эдийн засаг, шударга нийгмийг цогцлоохын төлөө мэдлэгт суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.
- *Дэлхийн Иргэний Боловсрол (ДИБ)* нь бүх насны суралцагч орон нутагтаа болон дэлхийн хэмжээнд илүү энх тайван, хүлээцтэй, тэгш хүртээмжтэй, аюулгүй нийгмийг бүрдүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ. ДИБ нь нийт хүн төрөлхтөний илүү өргөн олон нийтэд харьяалагдах, тэдний нэг гэсэн мэдрэмжийг төрүүлэхийг зорьдог бөгөөд дэлхий нийт, улс орон болоод орон нутгийн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын харилцан хамаарал, уялдаатай байдлыг анхаарч үздэг.

Монгол Улсын Засгийн газраас Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2019-2023 онд хэрэгжүүлж буй ТХБ-II төслийн хүрээнд ТХБ, ДИБ-ийн 8 сэдвийг сонгож, сургагч багшийн болон багшийн, 11-14 насны үе тэнгийн сургагч хүүхдүүдэд зориулсан 3 түвшний сургалтын модулийг боловсруулан толилуулж байна. Эдгээр сургалтын модулийг дараах бүтэц, онцлогтой боловсруулсан болно.



СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ



СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ



СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ



БАГШИД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ



СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ



ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧИЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ

- | | | |
|---|--|---|
| <ul style="list-style-type: none"> • Санал болгож буй сэдвийн агуулга, арга зүй • Нэмэлтээр уншиж судлах материал, ашиглах эх сурвалж | <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа • Багшид зориулсан зөвлөмж • Нөөц хэрэглэгдэхүүн • Холбогдох линк | <ul style="list-style-type: none"> • Даалгаврын заавар • Даалгавар • Өөрийн үнэлгээ, сорил • Унших материал |
|---|--|---|

Уг сургалтын модуль нь тогтвортой хөгжлийн үзэл санааг гэр бүл, сургууль, анги танхим, нийгмийн бусад орчин гэх мэт бүх түвшинд хэрэгжүүлэх, ирээдүйн сайн сайхан амьдралын төлөө экологийн ул мөрөө багасгаж, хамтаараа урагшлахад хөтлөх зорилготой боловсруулсан болно.

Модуль тус бүрийн сэдэв, агуулгыг ТХ-ийн 17 зорилготой уялдуулан олон нийт, багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эх олон нийт, сурагчдад хүргэх санааг сургагч багшийн модульд дурдсан тул цаашид энэхүү сургалтын модулийг хөгжүүлэн хэрэглэх боломж нээлттэй байх болно.

Иймд уг сургалтын модулийг хувь хүн өөрийн хөгжлөө дэмжих мөн сургалт явуулах эрх бүхий сургагч багш, байгууллага хэрэглэх боломжтой байх үүднээс хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй байршуулсан болно.

Сургалтын модулийн цахим хувилбарыг esd.mn цахим сайтаас татаж авч үзнэ үү.

"Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн удирдах нэгж



СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ



СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН БҮТЭЦ



ЗОРИЛГО



ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД



МОДУЛИЙН АГУУЛГА, АРГА ЗҮЙ



САНАЛ БОЛГОЖ БУЙ СЭДЭВ, АГУУЛГА



СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ



УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛ, НЭМЭЛТ ЭХ
СУРВАЛЖ



ЗОРИЛГО:

Энх тайван, үл хүчирхийллийг дэмжсэн орчин бүрдүүлэхийн ач холбогдлыг таниулах, гэр бүл, сургууль, нийгмийн орчинд үүссэн зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх арга хандлагыг төлөвшүүлэхэд оршино.



ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

- **Энх тайван, хамрах хүрээ:** Дайн мөргөлдөөнөөс гадна хүчирхийллийн бүхий л хэлбэр, аюул занал, нийгмийн доройтол, ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, ядуурал, шударга бус байдал зэргээс ангид байх нь энх тайван юм. Энх тайван нь хувь хүний дотоод амар амгалангаас гадна хүмүүс хоорондын, нийгэм, олон нийт, олон улс, цаашлаад даян дэлхийн энх тайвныг хамрах өргөн хүрээний ойлголт юм.
- **Энх тайван:** Хүчирхийлэл, дарамтаас ангид байхаас гадна хүн аз жаргалтай, эрүүл аж төрөх, өөрийгөө илэрхийлэх, бүтээн туурвих эрх чөлөө, боломж хангагдсан нөхцөлд эерэг энх тайван цогцолно. Энх тайвны үед хүмүүсийн дундах буруу тогтсон хандлагыг өөрчилж, ялгавар гадуурхалт, хүний эрхийн зөрчил, эдийн засгийн доройтол, шударга бус байдлыг арилгахын тулд хүмүүс идэвхтэй хүчин чармайлт гаргаж хамтран ажилладаг.
- **Хуурмаг энх тайван:** Хоорондоо сөргөлддөг хоёр тал хоорондоо шууд дайн, мөргөлдөөн байхгүй ч зөрчил тэмцэл нь далд байсаар байхыг хуурмаг энх тайван гэнэ.¹ Дарамт хүчирхийлэлгүй л болохоос хүний сайхан амьдрах бусад нөхцөл боломж бүрдээгүй байвал хуурмаг энх тайван юм.
- **Үл хүчирхийлэл:** Хувь хүн ба бүлэг хүмүүс нийгэм дэх зөрчлийг шийдвэрлэх, шударга бус явдлын эсрэг тэмцэхдээ бусад хүмүүс, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүйгээр шийдвэрлэхийн тулд хүчирхийлэл хэрэглэхгүйгээр тууштай хүчин чармайлт гаргах үйл явц юм.
- **Шууд хүчирхийлэл:** Бие махбодын хувьд зодож гэмтээх, зодолдох, хүчирхийлэх, өвтгөх, тамлан зовоох, амь насанд заналхийлэх, хэл амаар доромжлох зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг агуулдаг.
- **Бүтцийн хүчирхийлэл:** Хууль тогтоомж, дүрэм журам, ёс заншил зэргээр дамжин тухайн нийгэмд бүрэлдэн тогтсон байдаг ба нийгмийн тодорхой хэсгийг бусдаас нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байдаг. Тухайлбал,

¹ Жон Галтунг

хөдөлмөрийн ба бэлгийн мөлжлөгийг хориглоогүй, арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан, шашин, соёлын цөөнхийг гадуурхсан зэрэг хэв маягтай байдаг.

- **Соёлын хүчирхийлэл:** Хүний бие махбодоос илүү оюун санаанд нөлөөлж байдаг үл үзэгдэх хүчирхийллийн хэлбэр юм. Шууд болон бүтцийн хүчирхийллийг зөвтгөх үндэслэл болж байдаг. Эдгээр нь хүмүүсийн үзэл бодол, үнэт зүйл, итгэл үнэмшил, таамаглал, төсөөлөл, үлгэр домогт суурилсан байдаг.
- **Зөрчил:** Росс Стингер (1967)-ийн тодорхойлсноор зөрчил нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн үзэл бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм. Хүмүүс хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг.
- **Зөрчлийн шалтгаан:** Зөрчил нь нөөц боломжийн хомдслоос гадна, зөрчилдөж буй талуудын хэрэгцээ хангагдаагүй байх, эсвэл талуудын ялгаатай байдлаас үүсэн бий болдог гэж үздэг.
- **Зөрчлийн гүнзгийрэл:** Хүмүүс хооронд үүссэн аливаа зөрчлийг шийдвэрлэхгүй бол улам гүнзгийрдэг. Хүмүүст зөрчлийг эхэн үед нь шийдвэрлэх ур чадвар дутагдснаас зөрчил нь улам бүр гүнзгийрч хүндэрдэг. Харин зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэснээр өөртөө итгэх итгэл нэмэгдэж, харилцаа холбоо сайжирч, өсөлт хөгжил бий болдог. Зөрчлийн үед үүсдэг мэдрэмж хүнийг тавгүй байдалд оруулдаг. Үүнтэй холбоотой зарим хүн зөрчилдөхөөс зайлсхийх улмаар аль болох зөрчилдөхгүйг хичээх хандлагатай болдог. Зөрчил гүнзгийрэх нь айдас түгшүүр, эргэлзээ тээнэгэлзэл, гомдол, үзэн ядалт зэрэг сөрөг сэтгэл хөдлөлд хөтөлдөг. Гэхдээ хүн зөрчилтэй нөхцөлд тухайн үүссэн асуудалд сэтгэл хөдлөлөөр хандахаас илүү саруул ухаанаар хандаж бэрхшээл гэхээсээ түүнийг сорилт гэж харан эерэг талаас харж сурах хэрэгтэй. Зөрчилтэй тулгарах үед хүмүүсийн гаргадаг түгээмэл хандлага бол аль болох нөгөө талаа ялан дийлэхийг хичээх явдал байдаг. Ингэснээр нөгөө талын хүн ч гэсэн ялан дийлэхийг хичээсэн арга барилыг хэрэглэдэг.
- **Зөрчлийн үед** хүмүүсийн гаргадаг хариу үйлдлийг зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэргээр сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайвны арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сөргөлдөгч талууд бие биенийхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох арга замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.

- **Зөрчлийн үеийн арга барил:** Хүмүүс зөрчлийн үед тодорхой арга барилыг хэрэглэж хэвшсэн байдаг. Нэгэнт хэвшин тогтсон учир өөрсдийгөө тухайн арга барилыг хэрэглэдэг гэдгээ тэр бүр мэддэггүйгээс болж өөрийгөө зөвтгөх, бусдыг буруутгах хандлагатай байдаг байна. Иймд зөрчлийг шийдвэрлэхэд нэг чухал алхам нь хүмүүс өөрсдийн байнга хэрэглэдэг арга барилаа танин мэдэж, зөрчлийн үед тухайн арга барилыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэх талаар тунгаан бодох явдал юм. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг түгээмэл арга барилуудыг өрсөлдөх, зайлсхийх, зохицох, зөвшилцөх, хамтрах гэсэн ангилалд хувааж тодорхой таван амьтнаар төлөөлүүлэн тайлбарласан байдаг. Мөн зөрчлийн үеийн арга барилыг хүч хэрэглэх, зайлсхийх ба энх тайвнаар шийдвэрлэх гэж ангилдаг.
- **Зөрчлийг шийдвэрлэх боломжит шийдэл:** Зөрчлийг шийдвэрлэх боломжит дөрвөн шийдэл байдаг. Зөрчилдөж буй хоёр талыг А ба Б тал гэж нэрлэвэл тэдний дунд үүссэн зөрчил нь дараах дөрвөн хувилбарын аль нэгээр шийдэгдэж болно.

	А	Б
1.	Хожил	Хожигдол
2.	Хожигдол	Хожил
3.	Хожигдол	Хожигдол
4.	Хожил	Хожил



МОДУЛИЙН АГУУЛГА, АРГА ЗҮЙ


Энх тайванч хандлага, үнэт зүйл, ур чадварыг эзэмшүүлэх үүднээс энх тайван, үл хүчирхийллийн санааг сургалтдаа нэвтрүүлж буй зарим улс орны сургалтын үр дүнд:

- Багш-суралцагч, суралцагч-суралцагч, багш-багшийн хоорондын харилцаа сайжрах;
- Суралцагч болон багшийн хандлагад эерэг өөрчлөлт гарах;
- Суралцагчдын сэтгэл зүйн хөгжилд эерэгээр нөлөөлж, сэтгэл хөдлөл, мэдрэмжээ эрүүл, эерэгээр илэрхийлэхэд суралцах;
- Сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэж суралцагчдын нийгмийн идэвх, оролцоог дэмжих замаар суралцагчдын нийгэмшлийг дэмжих;
- Суралцагчдын сахилга бат, биеэ авч явах байдал, ёс зүй сайжрах;
- Багш, суралцагчийн бүтээлч сэтгэлгээ хөгжих давуу талууд ажиглагджээ.

Энэхүү сургалтын модуль нь гэр бүл, сургууль, нийгмийн хүрээнд энх тайвныг эрхэмлэсэн орчин, уур амьсгалыг бүрдүүлэх эцэг эх, багш, олон нийтэд энх тайвны боловсрол эзэмшүүлэхийн тулд сургалтыг дараах агуулга, арга зүйгээр удирдан чиглүүлэхэд хөтөч болно.

Хамрах сэдэв	Агуулга	Арга зүй, арга, хэрэгсэл
Энх тайван ба үл хүчирхийллийг эрхэмлэх	- Энх тайван - Хуурмаг энх тайван - Хүчирхийлэл, үл хүчирхийлэл	Туршлагаас суралцах Хэрэглэх арга: - Хэлэлцүүлэг хийх - Шинжилгээ хийх - Дүгнэлт гаргах - Турших, нэвтрүүлэх
Зөрчлийг энх тайвнаар шийдвэрлэх	- Зөрчлийн шалтгаан - Зөрчлийн гүнзгийрэл - Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг арга барил	

Туршлагаас суралцахуй: Энэ нь болж буй үйл явцын талаар эргэцүүлэх, тайлбарлах, ерөнхийд нь дүгнэх ба шинэ нөхцөлд хэрэглэх тухай хэлэлцэх, хамтран суралцах үйл явц юм.



1. Та нар сая юу хийсэн бэ? (Хичээлийн үйл ажиллагааг сэргээн сануулна)
2. Үйл явц хэрхэн өрнөсөн бэ? (Үйл ажиллагааны дарааллыг сэргээн сануулна.)
3. Чамд/та бүхэнд ямар санагдсан бэ?
 Юу олж мэдсэн бэ? (Хэлэлцүүлэг өрнүүлэх замаар эргэцүүлэл,
 Юуны тухай бодсон бэ? дүгнэлтэд хөтөлнө.)
4. Ямар нөхцөлд хэрэглэж болох вэ?

Туршлагаас суралцахын тулд тухайн тохиолдол буюу туршлагыг сайтар шинжлэн судалж, эргэцүүлэн дүгнэх учиртай. Жишээ нь Яагаад ийм зүйл болов? Эндээс юу ойлгож болох вэ? гэж асуух замаар явагдана.

Туршлагаас суралцахуйн загвараар хичээлийг төлөвлөхдөө зурагт заасан алхмаар үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. Оролцогчид үйл ажиллагаанд ганцаараа эсвэл хосоороо, бүлгээрээ оролцож болно. Үйл ажиллагааны үр дүн, дүгнэлт нь оролцогчид хариултыг өөрсдөө хайж/бодож олохоор байх учиртай. Үйл ажиллагааны төгсгөлд багш асуултаар тэднийг эргэцүүлэн бодох, дүгнэлт гаргахад хөтөлнө.

Хэлэлцүүлгийн явцад оролцогчдын ойлголт нэмэгдэж, нэгдсэн дүгнэлтэд хүрнэ. Мөн өдөр тутмын амьдралд тохиолдох нөхцөл байдалд үр дүнгээ хэрэглэх талаар тунгаан боддог болно.



СЭДЭВ 1: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЭРХЭМЛЭХ НЬ

Эцэг эх, олон нийт, багшид зориулсан сургалтын агуулга, арга зүй

АЛХАМ 1. ТУРШИХ ДАСГАЛ АЖИЛЛАХ: Чөлөөт хэлэлцүүлэг хийх: (цахимд зөвхөн асуултыг оруулна).

“Энх тайван ба үл хүчирхийлэл” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх асуултууд ба боломжит хариултууд:

- Энх тайван ба үл хүчирхийлэл гэж юу гэсэн үг вэ?
 - Бусадтай эв найртай байх
 - Улс дотроо эв найртай байх
 - Улс хоорондоо эв найртай байх
- Энх тайван тогтоох ба хүчирхийллийг үл тэвчихийн тулд юу хийх ёстой вэ?
 - Хүчирхийллийн бүхий л хэлбэр, аюул занал, нийгмийн доройтол, ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, ядуурал, шударга бус байдал зэргээс ангид байхыг эрхэмлэх
 - Бусдыг хүндэтгэх
 - Бусдыг хайрлах
 - Бусдын соёлыг хүндэтгэх
- Энх тайвныг тогтооход юу саад болдог вэ?
 - Хүчирхийлэл
 - Үл ойлголцол
 - Хүч хэрэглэх

- Бие биетэйгээ сөргөлдөх
- Атаа жөтөө гаргах
- Энх тайвныг тогтоохын ач холбогдол, сайн тал нь юу вэ?
 - Хувь хүний хувьд: баяр хөөртэй, аз жаргалтай, амар тайван амьдрал, амьдралын баяр баясгалан
 - Гэр бүлийн хувьд: сайхан амьдрал, ойлголцол, хүндэтгэл
 - Олон нийтийн хувьд: хамтрах, нийтээрээ аз жаргалтай байх, нийтээрээ бие биенээ хүндэтгэх
- Хүчирхийлэл ямар хор уршигтай вэ?
 - Ядуурал, өлсгөлөн, өвчлөл, гэмт хэрэг, хүчирхийлэл
- Хүүхдүүд сургууль дээр бие биенээ дооглох дээрэлхэх нь хүчирхийллийн хэлбэр мөн үү? Хэрхэн зогсоох вэ? Ямар арга зам байна вэ? Хүчирхийллийг багасгахын тулд бид өдөр тутам юу хийх ёстой вэ?
 - Шударга бус зүйлийн эсрэг зогсдог байх
 - Нийтийн тогтоосон дэг жаягийг баримтлах
 - Бусдад хүлээцтэй хандах
- Энх тайвны бэлэг тэмдэг нь юугаар илэрхийлэгддэг вэ?
 - Энх тайвны цагаан тагтаа
 - Гараа барилцсан зураг гэх мэт

АЛХАМ 2. ЭРГЭЦҮҮЛЭХ

Хичээлийн энэ хэсэгт оролцогчдыг 6 үндсэн бүлэгт хувааж бүлэг бүрт энх тайван ба үл хүчирхийллийг дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгаж, заах тухай бүлгээрээ хэлэлцэх даалгавар өгнө. Бүлгийн ажил 10-15 минут үргэлжилнэ.

Бүлэг 1	• Энх тайван ба үл хүчирхийллийн тухай сургалтын агуулгад хэрхэн тусгаж болох вэ? Ямар хичээлийн агуулгад тусгаж болох вэ?
Бүлэг 2	• Энх тайван ба үл хүчирхийллийн сургалтын арга зүй ямар байх вэ?
Бүлэг 3	• Энх тайван ба үл хүчирхийллийн тухай зааж буй багшийн харилцаа, хандлага чухал нөлөөтэй юу? Харилцаа, хандлагадаа юу анхаарах шаардлагатай вэ?
Бүлэг 4	• Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан энх тайван, үл хүчирхийллийн тухай суралцагчдад хэрхэн заах вэ?
Бүлэг 5	• Анги, хамт олны менежмент ба энх тайван, үл хүчирхийллийн тухай заахуй
Бүлэг 6	• Сургуулийн бодлого, үзэл баримтлал зарчим ба энх тайван, үл хүчирхийллийн тухай заахуй

Багш бүлгүүдийг хэлэлцүүлгийн үр дүнгээ бусад бүлэгтээ танилцуулахыг хүснэ.

АЛХАМ 3. ТАЙЛБАРЛАХ БА ДҮГНЭХ

Бүлэг бүрийн танилцуулгын дараа багш дараах мэдээллийг нэмж өгнө.

Багшийн зүгээс өгөх нэмэлт мэдээлэл, дүгнэлт	
Сургалтын агуулга	Монгол хэл, математик, биеийн тамир гэх мэт судлагдахууны агуулгад энх тайвны үзэл санааг тусгахын тулд судлагдахууны багш нар энх тайван ба үл хүчирхийллийн тухай сургалтанд хамрагдах
Сургалтын арга зүй	Боловсролд хэрхэн заах нь юу зааж буйтай адил чухал ач холбогдолтой байдаг. Энх тайван, үл хүчирхийллийн сургалт нь суралцагч төвтэй, туршлагад суурилсан арга зүйд тулгуурладаг. Мөн багшаас өөрийн зан байдал, үйл хөдлөл, хандлагаараа үлгэрлэн дагуулах, нөлөөлөх ур чадвар шаарддаг.
Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа бол энх тайвны боловсрол олгох чухал хэсэг юм. Сурагчдын дунд энх тайван, үл хүчирхийллийн бүлэг байгуулж болохоос гадна урлаг, спортын арга хэмжээ, дугуйлан секц зэргийг энх тайван, үл хүчирхийллийн агуулгатай холбоотой зохион байгуулж болно.
Сургуулийн багш, ажилтан, эцэг эхийн хөгжлийн хөтөлбөр	Сургууль, гэр бүлд энх тайвны орчин бүрдүүлэхийн тулд юуны өмнө багш, ажилтнууд энэ талаар ойлголттой, ач холбогдлыг ухамсарладаг байх хэрэгтэй юм. Тэгэхээр энх тайван, үл хүчирхийллийн тухай багш, ажилтан, эцэг эхэд зориулсан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж болно.
Анги, хамт олны менежмент	Ангийн дотоод дүрэм журам боловсруулах, ангийн дотоод тохижилтыг хангах, сурагчдын дунд үүссэн зөрчлийг шийдвэрлэх, зөвлөгөө өгөх гэх мэт үйл ажиллагаа хамаарна.
Сургуулийн бодлого, менежмент	Энх тайвны хичээл зааж буй багшийг сургууль бүхэлдээ дэмжих учиртай. Багш хэчнээн энх тайвны талаар заагаад, үлгэрлэж байвч сургуулийн бусад багш, ажилтнууд энэхүү үзэл санааг үл хайхарч байвал суралцагчдад суулгасан энх тайвны үр соёолохгүй юм. Тиймээс сургуулийн удирдлагын зүгээс бүтэц, зохион байгуулалтаар хангах, бодлого хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа энэ талаар анхаарч үзэхийг хэлнэ.

АЛХАМ 4. ХЭРЭГЛЭХ

Багш дараах хуудсыг оролцогчдод тараан өгч энх тайван ба үл хүчирхийллийг ЕБС-ийн сургалтад нэвтрүүлэх талаар олон улсад хэрэгждэг үйл ажиллагааг манай улсын нөхцөлд, тэр дундаа өөрийн сургууль дээр хэрэгжүүлэх боломжийн талаар эргэцүүлж арын хоёр баганын тохирох багананд бичих даалгавар өгнө.

	Хэрэгжүүлэх бүрэн боломжтой	Хэрэг жүүлэхэд хэцүү
Анги танхим, сургуулийн орчинд сурагч, багш, ажилтны биеэ зөв авч явах энгийн дүрэм, заавар боловсруулж мөрдөх. Дүрмийг албаны үг хэллэгээр бичихээс илүүтэй зураг дүрслэлээр үзүүлж, энгийн үг хэллэгээр тайлбарлаж хүүхэд, багш нарт ойлгомжтой байлгахад анхаарах). Жишээг нэмэлт эх сурвалж, материал 1-ээс харна уу.		
Энх тайвныг эрхэмлэх хандлага, зан байдал, чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн тусгай үйл ажиллагаа, арга хэмжээ, дасгалыг хэрэгжүүлж хэвших. Сургууль, анги танхимаараа Дэлхийн энх тайвны өдрийг тэмдэглэн өнгөрөөх, Үл хүчирхийллийн аян өрнүүлэх, сайн үйлсийн аян өрнүүлэх гэх мэт.		
Мянган цаасан шувуу хийх аянд нэгдэх – сурагчдад Садако Сасаки охины түүхийг ярьж өгсний дараа цаасан шувуу хийх аргыг зааж өгөн сургуулиараа 1000 цаасан шувуу хийх аян өрнүүлж болно. Хүүхдүүд өөрсдийн хүссэн тоо хэмжээгээр цаасан шувуу хийж түүгээр сургуулиа чимэглэх эсвэл Хирошима хотын Энх тайвны цэцэрлэгт хүрээлэн рүү илгээж болно. Эсвэл хамгийн том эсвэл хамгийн жижиг цаасан шувуу хийх уралдаан зарлах зэргээр хүүхдүүдийн сонирхлыг идэвхжүүлж болно.		
Ханын сонин бэлтгэх, үзүүлэх: Суралцагчид энх тайванч үзэл санаа, үл хүчирхийллийн арга барилыг танилцуулсан ханын сонинг өөрсдийн гараар урлан бүтээж сургуулийн коридор, ангийн хана зэрэг газарт байрлуулах эсхүл ахлах ангийн суралцагчид бага, дунд ангийнханд зааж сургах гэх мэт.		
Анги, сургууль даяараа богино хугацааны бясалгалыг хийж хэвших. Сургууль даяараа бясалгал хийж эерэг үр дүнд хүрсэн АНУ-ын нэгэн сургуулийн тухай жишээг нэмэлт эх сурвалж, материал 4-өөс харна уу.		

Сурагчдын өөрийн удирдлагын бүлэг, байгууллагын хүүхдүүдийг энх тайван, үл хүчирхийллийн талаар үе тэнгийнхэндээ нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах “Үе тэнгийн сургагч” бэлтгэж, тэднээр дамжуулан сургуулийн нийт суралцагчдад үе тэнгийн сургалт, семинар зохион байгуулах		
Энх тайван, үл хүчирхийллийн үзэл санааг дэмжсэн лого, зураг, дүрслэл байрлуулах, хамтдаа бүтээх, флаш моб хийх		
Энх тайван ба үл хүчирхийллийн тэмдэглэлт өдрийг тэмдэглэх жишээг нэмэлт эх сурвалж, материал 2-оос харна уу.		
Анги танхим эсвэл нийгмийн ажилтны өрөөнд Энхийн ширээ, Энхийн булан байгуулах. Энхийн ширээ, булангийн зарим жишээг нэмэлт эх сурвалж, материал 3-аас харна уу.		
Тухайн өдрийн энх тайвны илгээмжийг танилцуулах: Жишээ нь “Өнөөдөр сонсох өдөр”, “Өнөөдөр бусдын оронд өөрийгөө тавьж үзэх өдөр” гэх мэт		
Анги хамт олон, сургуулиараа тодорхой цаг хугацаанд хамтдаа бясалгал хийж хэвших жишээг нэмэлт эх сурвалж, материал 4,5-аас харна уу.		
Энх тайвны цаасан сэнс хийж, задгай талбайд үзэсгэлэн гаргах жишээг нэмэлт эх сурвалж, материал 6-аас харна уу.		

Оролцогчдыг дээрх дасгалыг ажиллаж дууссаны дараа арга хэмжээ тус бүрийг нэг нэгээр нь асууж хэдэн оролцогч хэрэгжүүлэх боломжтой, хэдэн оролцогч хэрэгжүүлэхэд хэцүү гэж хариулсныг асууж тодруулан, зарим оролцогчоос санаа бодлыг нь тодруулах замаар хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгийн явцад багшийн зүгээс тухайн арга хэмжээтэй холбоотой нэмэлт мэдээллийг оролцогчдод нэмж өгнө.



СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Энэ хичээл нь үндэсний сургагч багш нарт зориулсан сургалт тул сургалтад оролцогчын дунд энх тайван ба үл хүчирхийллийн талаар нэгдсэн ойлголт бий болгохын тулд аль болох бүх хүнийг хамруулсан хэлэлцүүлэг хийж, бусад улс орны туршлагыг судлан, хамтдаа хэлэлцэхэд нь оролцогчдыг дэмжих хэрэгтэй.

- Оролцогчдын зүгээс энх тайван, үл хүчирхийллийг ойлгуулсантай холбоотой шинэ санаа, туршлага гарч болох ба энэ үед тухайн санаа, туршлагад төвлөрөн ярилцаж, бодит байдал дээр хэрэгжүүлэх урам зориг өгөхийг хичээгээрэй.
- Энх тайван ба үл хүчирхийллийн тухай сургалт зохион байгуулахад мэдлэг, чадвараас гадна багшийн харьцаа, хандлага чухал тул оролцогчдын дунд энх тайван, үл хүчирхийллийг дэмжсэн уур амьсгал, харьцаа, хандлага төлөвшүүлэхэд багшийн зүгээс анхаарах нь зүйтэй.



УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛ

ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ

Хүмүүс бидний сайн сайхан амьдралын үндэс суурь нь энх тайван байдал юм. Энх тайвны талаар хүмүүсийн ойлголт бага зэрэг ялгаатай байдаг. Улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, нийгмийн ухааны хувьд энх тайвныг өөр өөрсдийн салбарын онцлогтой холбоотойгоор авч үзэн тайлбарладаг.

Эдийн засгийн хувьд	Ядуурлаас ангид байх буюу эдийн засгийн сайн сайхан байдалд аж төрөх
Улс төрийн хувьд	Ардчилал, сайн засаглалын үр дүнд энх тайван оршин тогтноно.
Дайны эсрэг үзлээр	Дайн мөргөлдөөнийг зогсоосон цагт энх тайван тогтоно.
Хууль, эрх зүйн хувьд	Хуулийг сахин биелүүлж, дэг журамтай байх нь энх тайвныг бүрдүүлнэ.
Нийгмийн хувьд	Ялгаатай бүлгүүдийн дундах зөрчлийг шийдвэрлэж, шударга ёсыг сахих замаар хүмүүс хоорондоо зохицож амьдрах нь энх тайван юм.

Бодит байдал дээр энх тайвныг зөвхөн дайн байлдааныг зогсоосноор, эсвэл хууль дэг журмыг хангаснаар, эсвэл ядуурлыг бууруулснаар бий болгож чадахгүй. Тэгэхээр энх тайван гэдэг нь бүх салбарыг хамарсан цогц (холистик) ойлголт юм.

Энхтайван ба хуурмаг энх тайван

Энх тайван хэмээх ойлголтыг 1960-аад оноос шинжлэх ухааны талаас идэвхийлэн судалж эхэлсэн. Жон Галтунг хэмээх Норвегийн судлаач энх тайван судлалыг анх санаачлан эхлүүлсэн ба, 1959 онд Осло хотноо Энхтайвны судалгааны институтыг байгуулж 1964 оноос Энх тайван судлал сэтгүүлийг үүсгэсэн байна. Түүний санаачилга НҮБ-ын зүгээс дэлхий дахины энх тайвны

талаар бодлого, үзэл баримтлал хөгжихөд хувь нэмрээ оруулсан байдаг. Жон Галтунг нь Махатма Ганди ба Буддизм гэсэн хоёр эх сурвалжид үндэслэн үзэл сургаалаа боловсруулсан.

Хүмүүс энх тайван гэдгийг “дайн дажингүй байх” гэж ойлгодог. Галтунг энэ байдлыг хоёр тал хоорондоо дайтахгүй ч зөрчил тэмцэл нь байсаар байдаг учир хуурмаг энх тайван гэж нэрлэсэн байна. Гэхдээ дайн мөргөлдөөнтэй байснаас сөрөг ч хамаагүй энх тайван байх нь хамаагүй чухал учир нь хуурмаг энх тайван нь энх тайвны урьтал гэж үзсэн.

Хүмүүст шууд ба шууд бусаар нөлөөлөх дарангуйллын дэглэм, хүчирхийлэл, дарамт байхгүй үед тайван байдал оршин байж болох ч хүмүүсийн эрх, эрх чөлөө хязгаарлагдмал байвал энэ нь хуурмаг энх тайван юм. Тодруулбал дарамт хүчирхийлэлгүй л болохоос хүний сайхан амьдрах бусад нөхцөл боломж бүрдээгүй байдлыг хэлнэ. Жишээ нь сөргөлдөгч талууд бие биенийхээ эсрэг гал нээхгүйгээр тохиролцох, тоглоомын талбай эсвэл ангид зодолдохыг хориглох гэх мэт нь хүчирхийллийг хориглож буй хэдий ч далд зөрчил нь байсаар байхыг хэлнэ. Харин хүчирхийлэл, дарамтаас ангид байхаас гадна хүн аз жаргалтай, эрүүл аж төрөх, өөрийгөө илэрхийлэх, бүтээн туурвих эрх чөлөө, боломж хангагдсан нөхцөлд жинхэнэ буюу эерэг энх тайван цогцолно гэж үздэг. Эерэг энх тайвны үед хүмүүсийн дундах буруу тогтсон хандлагыг өөрчилж, ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн зөрчил, эдийн засгийн доройтол, шударга бус байдлыг арилгахын тулд хүмүүс идэвхитэй хүчин чармайлт гаргаж хамтран ажилладаг.

Хүчирхийлэл

Хүчирхийллийг хэлбэрийн хувьд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн ба үл хайхрах гэж ангилахаас гадна шууд, бүтцийн, соёлын хүчирхийлэл гэж ангилж авч үздэг.


- Шууд хүчирхийлэл нь бие махбодын хувьд зодож гэмтээх, зодолдох, хүчирхийлэх, өвтгөх, тамлан зовоох, амь насанд заналхийлэх, хэл амаар доромжлох зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг агуулдаг.
- Бүтцийн хүчирхийлэл нь хууль тогтоомж, дүрэм журам, ёс заншил зэргээр дамжин тухайн нийгэмд бүрэлдэн тогтсон байдаг ба нийгмийн тодорхой хэсгийг бусдаас нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байдаг. Жишээ нь хөдөлмөрийн ба бэлгийн мөлжлөгийг хориглоогүй, арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан, шашин, соёлын цөөнхийг гадуурхсан зэрэг хэв маягтай байдаг.
- Соёлын хүчирхийлэл нь хүний бие махбодоос илүү оюун санаанд нөлөөлж байдаг үл үзэгдэх хүчирхийллийн хэлбэр юм. Шууд болон бүтцийн хүчирхийллийг зөвтгөх үндэслэл болж байдаг. Эдгээр нь хүмүүсийн үзэл санаа, үнэт зүйл, итгэл үнэмшил, таамаглал, төсөөлөл, үлгэр домогт суурилсан байдаг. Аман ба бичгийн хэл, урлаг, хошин шог, статистик тоо баримт, тогтсон хандлага, дайны баатар, үлгэр домог тууль, далбаа, дуулал, цэргийн жагсаал, ханын сонин зэрэг соёлын янз бүрийн хэлбэрээр илэрч байдаг. Нийгмийн анги, давхарга, соёл, үндэс угсаа,

ажил мэргэжил, нас, хүйс, биеийн гадаад байдал зэрэг шинж тэмдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхсан гадуурхлын бүхий л хэлбэр нь соёлын хүчирхийллийн жишээ юм.

Бодит амьдрал дээр хүчирхийллийн эдгээр гурван хэлбэр нь өөр хоорондоо холбоотой байдаг бөгөөд эдгээрийн холбоог гурвалжин дүрсээр төлөөлүүлсэн байдаг. Шууд хүчирхийлэл нь соёлын ба бүтцийн хүчирхийллийг өдөөж идэвхжүүлж байдаг бол соёлын ба бүтцийн хүчирхийлэл нь шууд хүчирхийллийг төрүүлж байдаг.



Энхийг сахиулах нь шууд хүчирхийллийн үед нэн тэргүүнд зайлшгүй авах ёстой арга хэмжээ юм. Энх тайвныг тогтоох гэдэг нь бүтцийн хүчирхийллийн үед олон жил дайсагнасан талуудыг дахин нэгтгэхийн тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ. Харин энх тайвныг бүтээх нь энх тайвныг эрхэмлэсэн соёлыг бүтээн байгуулах тухай юм.




Шигтгээ

Энх тайван гэдэг нь зөвхөн дайн дажингүй байх явдал биш бөгөөд харин шударга ёс оршин байх нөхцөл юм.

Мартин Лютер Кинг

Энх тайван нь хувь хүний дотоод амар амгалангаас гадна хүмүүс хоорондын, нийгэм, олон нийтийн, олон улсын, цаашлаад даян дэлхийн энх тайвныг хамрах өргөн хүрээний ойлголт юм.

- Дотоод энх тайванд хувь хүний өөрийнхөөрөө байх, дотоод зөрчилгүй, баяр хөөртэй, эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн сэтгэл зүйн амар амгалан байдлыг ойлгоно.
- Хүмүүс хоорондын энх тайванд хүмүүсийн харилцан ойлголцол, хүндэтгэлд суурилсан, бие биеийнхээ ялгаатай байдал, онцлогийг хүлээн зөвшөөрсөн, харилцаа, хамтын ажиллагааны хэлбэрийг ойлгоно.
- Нийгмийн энх тайванд улс орны ардчилал, хүний эрх, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн, хууль ёсыг чанд сахисан нийгмийн амар амгалан байдлыг ойлгоно.
- Олон улсын энх тайванд улс орнууд бусад улс орны хил хязгаар, эрх ашигт хүндэтгэлтэй хандаж, шударга ёсыг сахин бүс нутаг, олон улсын хэмжээнд эв найрамдалтай, дипломат ёсны хэм хэмжээг сахин харилцаж хамтран ажиллахыг ойлгоно.
- Даян дэлхийн энх тайванд хүн төрөлхтний хүрээлэн буй орчин, ан амьтан, ургамал, байгаль дэлхийтэйгээ зохицон тогтвортой амьдарч, аж төрөх арга хэлбэрийг багтаан ойлгоно.



Үл хүчирхийлэл

Үл хүчирхийлэл нь хоёр үгнээс тогтсон холбоо үг бөгөөд үл гэдэг нь үйл үгийн өмнө тохиолдож тухайн үйл үгээр илрэх утгыг үгүйсгэх (эх сурвалж: Монгол хэлний тайлбар толь) тул үл хүчирхийлэл гэдэг нь хүчирхийлэхгүй гэсэн утгыг агуулна. Үл хүчирхийлэл ийнхүү хүчирхийлэхгүй гэсэн санаа агуулагдаж байгаа ч холбогдох ном зохиолд бичсэн тайлбараас харахад хүчирхийлэхгүй гэдэг нь дарлал мөлжлөгийн үед түүнтэй эвлэрэн хүч хэрэглэхгүй зүгээр суух гэсэн идэвхгүй утгатай биш харин ч дарлал мөлжлөгийн эсрэг тууштай тэмцэхдээ хүчирхийллийг хэрэглэхгүйгээр тэмцэх гэсэн идэвхтэй үйл хөдлөлийг

илэрхийлнэ гэж бичсэн байна. Үл хүчирхийллийн тухай тайлбарласан ном, материал, эх сурвалжийн агуулгад дүн шинжилгээ хийхэд дараах хоёр маягаар тодорхойлсон байна. Үүнд:

- **Үл хүчирхийлэл нь дарлалт, шударга бус байдлын эсрэг тэмцэх, эсэргүүцлээ илэрхийлэх арга хэлбэр болох нь.** Энэ утгаар үл хүчирхийлэл гэдэг нь хувь хүн ба бүлэг хүмүүс нийгэм дэх зөрчлийг шийдвэрлэх, шударга бус явдлын эсрэг тэмцэхдээ бусад хүмүүс, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүйгээр шийдвэрлэхийн тулд хүчирхийлэл хэрэглэхгүйгээр тууштай хүчин чармайлт гаргах үйл явц юм. Үл хүчирхийллийн зорилго нь хүний эрх, шударга ёсыг шаардан, хүчирхийллийн бус арга замаар шахалт үзүүлэх байдлаар хүмүүсийг зүй бус дарлал, мөлжлөгийн тоглолцоо, сөрөг хандлагаас хамгаалахад чиглэдэг. Үл хүчирхийллийн тухай үзэл санааны томоохон төлөөлөгч нь Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний удирдагч Махатма Ганди юм. Эндээс (Нөөц хэрэглэгдэхүүн 5) Махамта Гандийн энх тайвны бослогын талаар дэлгэрүүлэн уншаарай.

Үл хүчирхийллийг хүчирхийлэл хэрэглэхгүйгээр энх тайвны төлөө яриа хэлэлцээр хийх арга гэж үздэг. Хүмүүсийн бие махбод, сэтгэл зүйд гэм хор учруулахгүйгээр эсэргүүцлээ илэрхийлэх нэг арга зам нь үл хүчирхийлэл гэсэн үг юм. Нийгэм дэх хүчирхийлэл, дарлал, мөлжлөгийн эсрэг хүчирхийлэл хэрэглэх нь олон сөрөг үр дагавар дагуулдаг учир үүний эсрэг тэмцэх хамгийн үр дүнтэй, оновчтой, идэвхтэй арга зам нь үл хүчирхийлэл гэж дэлхий дахинаа үзэж байна.

Дарлал, мөлжлөг, шударга бус байдлын эсрэг тэмцэх үл хүчирхийллийн хэд хэдэн арга зам байдгаас заримыг нь дурдвал:

Эсэргүүцлээ илэрхийлэх	<i>Жагсах</i> – хүмүүс олон нийтийн газар цугларч, тодорхой зүйл дээр ижил санаа бодолтой байгаа илэрхийлэх <i>Гарын үсэг зурах</i> – ямарваа бодлого, шийдвэрийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлж, шаардлагыг баталгаажуулж гарын үсгээ зурж нэгдэх
Хамтран ажиллахгүй байх	<i>Бойкот</i> – Үйлчилгээ, бүтээгдэхүүнд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахаас татгалзах <i>Ажил хаялт</i> – Ажлаа хийхээс татгалзах замаар эсэргүүцлээ илэрхийлж буй хэлбэр юм. Дэлхий дахинаа коммунист дэглэмийг нуран унах явцыг эхлүүлсэн Польш улс дах ажил хаялт нь үл хүчирхийллийн хөдөлгөөний эхлэл болсон түүхтэй. <i>Хамтрахаас татгалзах</i> – Дэлхийн 2-р дайны үед Норвегийн багш нар Нацистуудын боловсролын хөтөлбөрийн дагуу хичээл заахаас татгалзсан бөгөөд тэднийг үүнийх нь төлөө хорих ангид цагдан хорьсон ч багш нар өөрсдийн байр сууриндаа тууштай байсан учраас тэднийг буцаад сургуульд нь буцааж байжээ.

Интервенци хэрэгжүүлэх

Суулт хийх – Гудамж, зам талбай зэрэг олон нийтийн газар хүмүүс нэгдэн нийлж суулт хийх замаар эсэргүүцлээ илэрхийлэх хэлбэр

Урьдчилан сэргийлэх оролцоо – Зөрчил, мөргөлдөөнтэй бүс нутагт байгаа жирийн иргэд, эмзэг хүмүүсийг хамгаалах зорилгоор сайн санааны элч төлөөлөгч тухайн газар нутагт байршиж ажиллахыг хэлнэ. Эдгээрийг голдуу гуравдагч тал, энхийг сахиулагч гэж нэрлэдэг ба эдгээр нь зөрчилдөгч талуудын аль нэгэнтэй холбоо хамааралгүй байдаг.

Үл хүчирхийлэл нь өдөр тутмын амьдралын нэг хэсэг буюу амьдралын хэв маяг болох нь. Дэлхий дахинаа олон хүмүүсийн хувьд үл хүчирхийлэл нь улс төрийн тавцанд өрнөдөг үйл явц бус харин тэдний өдөр тутмын амьдралын нэг хэсэг буюу амьдралын хэв маяг болсон байдаг. Үл хүчирхийлэл нь онцгой тохиолдолд болдог түр зуурын үйл явдал бус харин өдөр тутмын амьдралд баримтлах зарчим, хэм хэмжээ гэж тэдгээр хүмүүс үздэг байна. Жишээ нь

- Франц улсад хүүхдэд шийтгэл учруулахыг эсэргүүцдэг нийгмийн идэвхтнүүд энэ үзлийнхээ төлөө тууштай ажилладаг. Тэд хүүхдийг шийтгэлгүйгээр өсгөж хүмүүжүүлэх ёстой гэж үздэг ба хүүхдийг зодож шийтгэх нь иргэншсэн нийгэмд байж болохгүй зүйл гэж үздэг.
- Феминист үзэлтнүүдийн үзлээр эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй эрчүүдийн хүчирхийллийг дангаар буруутгах нь хангалтгүй бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын эрх тэгш байдлыг бий болгохын төлөө ажиллах ёстой гэж үздэг. Тэдний үзэж байгаагаар хүмүүсийг аль нэг хүйсэд хамаатуулж, улмаар түүний чадавхыг тухайн хүйсийн нийгмийн үүргийн хүрээнд хязгаарлан авч үзэж хандах нь хүчирхийллийн нэг хэлбэр юм.
- Үл хүчирхийллийн үзэл санааны олон удирдагчдын үзэж байгаагаар лаборатори, хүнсний үйлдвэрлэлд амьтдад туршилт хийж, хүнд бэрх нөхцөлд байлгаж, үй олноор нь нядалж хүний хэрэгцээнд нийлүүлж байгааг зүй бус гэж үзэн тэднийг амьтдад хүнлэг хандахыг уриалдаг. Үүнтэй холбоотойгоор Махатма Ганди, Хэнри Дэвид Торрү, Лэв Толстой зэрэг удирдагчид хүн төрөлхтний хувьд хамгийн энх тайванч гэж хэлж болох хооллолтын веган дэглэмийг тууштай баримталсан байдаг байна.
- Дэлхийд уур амьсгалын өөрчлөлт тохиож, хүн төрөлхтний төдийгүй дэлхий дээрх бүх амьтдын хувь заяанд ноцтой хямрал нүүрлэж буй энэ цаг үед үл хүчирхийллийн хэв маягийг эрхэмлэдэг хүмүүс “Эх дэлхийгээ энх тайван байлгаг” гэсэн уриалгад нэгдэж байна.

НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ, МАТЕРИАЛ

1. Энх тайван ба үл хүчирхийллийг дэмжсэн ангийн дүрмийн зарим жишээ

АНГИД БИЕЭ АВЧ ЯВАХ ДҮРЭМ

1. Хүүхдүүд бие бие биетэйгээ эелдэг харилцана.
2. Хүүхдүүд бид хичээлээ хийхдээ чимээгүй байж бусдад саад болохгүй байна.
3. Хүүхдүүд бид бусад хүүхдүүдийн яриаг анхаарал тавин сонсоно.
4. Бид үнэн шударга занг эрхэмлэнэ.
5. Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж биелүүлнэ.
6. Бид сургуулийнхаа багш, ажилтнуудтай хүндэтгэлтэй харьцана.
7. Би хичээлдээ цагтаа ирнэ.
8. Бид бие биетэйгээ эвтэй байж хамтарч ажиллана.
9. Бид аливааг сайн хийхийг хичээх болно.



2. Энх тайван, үл хүчирхийллийг тэмдэглэн өнгөрүүлэх өдрүүд

9 сарын 21	Олон улсын Энх тайвны өдөр
10 сарын 2	Олон улсын хүчирхийлэлгүй өдөр
10 сарын 12-18	Дэлхийн дахины Энх тайвны төлөөх залбирлын 7 хоног
10 сарын 24	Нэг ертөнц долоо хоног
11 сарын 11	Дэлхийн жорлонгийн/ариун цэврийн байгууламжийн өдөр
12 сарын 10	Хүний эрхийн өдөр
1 сарын 3 дах долоо хоног	Энх тайвны ням гариг
3 сарын 8	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр
6 сарын 4	Дайны хохирогч хүүхдүүдийн дурсгалыг хүндэтгэх олон улсын өдөр
8 сарын 6 ба 9	Японы Хирошима, Нагасаки хотыг бөмбөгдсөнийг дурсах өдөр

3. Анги танхимд байгуулах энхийн булан, энхийн ширээний зарим жишээ

Хоёр ба хэд хэдэн хүүхдүүдийн дунд зөрчил үүсэх үед тэднийг энхийн ширээ сандалд суухыг хүснэ. Тэднийг энхийн ширээнд суух үед янз бүрийн байдлаар харилцан яриаг зохион байгуулж болно. Жишээ нь тэднийг нэг нэгээрээ ээлжлэн ярихыг хүсэх бөгөөд нэгнийгээ ярих үед нөгөө нь яриаг нь таслахгүйгээр сонсох дүрмээр хоёр тал хоёулаа ярьж болно. Хүүхдүүд бие биенийхээ яриаг сонссоны дараа эвлэрч болох ба эвлэрсний дохио болгож хоёулаа гар барих болон бие биенээ тэвэрч болно. Хэрэв хүүхдүүд хоорондоо эвлэрч чадахгүй байгаа тохиолдолд багш эсвэл ангийн өөр нэг хүүхэд эвлэрүүлэгчийн үүрэг гүйцэтгэж болно.


Ширээний эргэн тойронд хүүхдүүдэд зориулсан энх тайван, үл хүчирхийллийн агуулга бүхий хэлц үг, уриа, эшлэл, зураг, мөн тоглоом, цаас будгийн харандаа зэргийг байрлуулсан байж болно.

Энх тайвны ширээ байгуулахад хэрэгтэй эд зүйлсийн жагсаалт


- Тэгш гадаргуу бүхий ширээ
- 2 сандал
- Өнгөлөг, суухад таатай ширээний бүтээлэг
- Энх тайвны илтгэсэн дүрс, тэмдэг
- Элсэн цаг /3 минутын хугацаатай байвал тохирно./
- Тохиромжтой байрлалд байрласан
- Хүүхдүүд энх тайвны ширээ ямар учиртайг мэддэг байх
- Би өгүүлбэрийн жишээ
- Энхийн ширээний дүрмийг бичсэн байх, Үүнд:
 - Би түүний үгийг дуустал анхааралтай сайн сонсоно.
 - Би ээлжээ болохоор ярина.
 - Би түүн рүү дайрахгүй, муухай үг хэлэхгүй



Бага ангийн энхийн булан



Нийгмийн ажилтны өрөөнд байх энхийн ширээ



Дунд, ахлах ангийнхны энхийн ширээ

4. “Анги дахь баясал” буюу ангиараа хийх бясалгалын арга


Дотоод амар амгаланг олох, төсөөллийн ертөнцөөр аялах зэрэг боломжийг олгохоос гадна бясалгал нь тухайн хүний дотоод ертөнцийн үүд хаалгыг нээдэг

Бясалгалаар дадуулж болох зарим зан үйл	Бие махбодын сахилга бат	Хэл ярианы сахилга бат
• Сэтгэл хөдлөлөө хянах • Нам гүм, чимээгүй байдалд баясах • Тэвчих • Өөрийгөө удирдах	• Биеийн зөв байрлал (зөв суух) • Даруу төлөв байдал • Хэт хөдөлгөөнт, хөөрүү байдлыг бууруулах • Эмх замбараагүй хөдөлгөөнийг багасгах	• Хов жив гэх мэт ач холбогдолгүй яриа, үг хэллэгээс татгалзах • Идэвхитэй сонсох • Эелдэг/найрсаг үг хэллэг • Зөөлөн аядуу яриа

АНУ-ын багш Стефан Херцог анги танхимд бясалгал хийх арга зүйг нэвтрүүлсэн өөрийн туршлагадаа үндэслэн “Анги дахь баясал” нэртэй ном хэвлүүлсэн байдаг. Тэрээр номондоо бясалгалын нөлөөгөөр хүүхдүүдийн төсөөлөн бодох, сонсох, бусдыг ойлгох чадвар, анги хамт олны дотоод уур амьсгал эерэг тал руу маш их өөрчлөгдснийг онцлон тэмдэглэсэн. Тэрээр бясалгал нь биднийг дотоод сэтгэл рүүгээ өнгийх, өөртэйгээ холбогдоход тусалдаг. Өөрийнх нь дотор хайр, хүч чадал, сайхан сэтгэлийн эх ундарга байгаа гэдгийг олж нээгээгүй хүүхдүүд олон байдаг. Анги дотор бясалгал хийсний дараа хүүхдүүдийн сахилга бат, өөрийгөө хянах, удирдан жолоодох чадвар илт сайжирч байгаа нь мэдрэгддэг. Энэ бүх эерэг өөрчлөлт ухамсартай гэхээсээ илүү аяндаа бий болдог. Түүний хэрэгжүүлсэн бясалгалын арга нь таван үе шатнаас бүрддэг.

1. Өөрийн дотоод хүнтэй холбогдох, амрах
2. Гүнзгий амьсгалах ба сэтгэл хөдлөлөө хянах
3. Ухамсарт төвлөрөл
4. Төсөөлөн бодох
5. Бүтээлч үйл ажиллагааг ухамсартайгаар хэрэгжүүлэх

Хүүхдүүдийг нээлттэй орон зай бүхий газар жишээ нь гадаа эсвэл нам гүм газар аваачна. Тэднийг эргэн тойрны дуу чимээг сонсон чимээгүй суухыг хүснэ. Энэ нь тэднийг эргэн тойрноо мэдрэхэд тусалдаг. Тэднийг чимээгүй суун дотроо “Би тайван амгалан байна” гэж давтан хэлэхийг хүснэ. Моддыг чимээгүй төвлөрөн ажигла. Чимээгүй сууж амьсгалаа авч гаргаж буйд төвлөрөөрэй гэж хэлнэ. Цэцэгс, навчыг ажиглан, тэдгээрийн хэлбэр, өнгө, хөдөлгөөнийг ухамсартайгаар төвлөрөн ажиглах нь сайн нөлөөтэй. Ийнхүү байгалийн өнгө үзэмж, гоо сайхныг харан баясахын хамт ой мод, цэцэрлэгийг дотроо төсөөлөн төсөөллийн аялал хийж болно. Чимээ анир гаргалгүй суух явцдаа хүний сайн сайхан чанарын талаар жишээ нь сайхан сэтгэл, хүнлэг энэрэнгүй зан, өгөөмөр зан сэтгэл гэх мэтийг эргэцүүлэн тунгаагаарай гэж хэлнэ.



5. Олон улсын сайн туршлага: Чимээгүй цаг арга хэмжээний хүрээнд сургуулиараа бясалгал хийж үр дүнд хүрсэн нь²

Чимээгүй цаг арга хэмжээний хүрээнд хичээлийн өдөр бүрийн өглөө ба орой 2 удаа тус бүр 15 минутын хугацаанд чимээгүй цагийг зохион байгуулсан. Чимээгүй цагийн үед хичээл, сургалттай холбоотой бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээг зогсоож сурагчдыг тайван байдалд байж, 15 минутын хугацаанд чимээгүй суулгадаг байна.



- Өглөө бүр багш нарыг хичээлээ эхлэхийн өмнө сургууль даяар нийт багш, сурагчдад хандан “Багш, сурагчдаа чимээгүй цагт бэлдэцгээнэ үү” гэж зарладаг.
- Энэхүү зарын дараа багш нар сурагчдад хандан ширээн дээрхээ эмхэлж цэгцлэн, нуруугаа цэх байлган суудалдаа суухыг хүсч, хонхыг дуугаргана.
- Хонх дуугарснаар сурагчид 15 минутын турш нүдээ анин тус тусын суудалдаа чимээ гаргалгүй сууцгаана.

Чимээгүй цагийн үед сургууль даяар чимээгүй болж, маш нам гүм байдалтай болдог. Энэ үед сурагч багш бүгдээрээ дуу шуугианаас ангид, чимээ аниргүй, тайван амгалан байдлыг мэдэрдэг. Чимээгүй цагийн арга хэмжээ дууссаны дараа багш хичээлээ зааж эхлэхэд сурагчдын анхаарал төвлөрөл сайн болсон байдаг. Чимээгүй цаг арга хэмжээг эхлэхийн өмнө сургуулийн бүх багш, ажилтнуудад Бясалгал хийх тухай сургалт явуулсан байна. Чимээгүй цагийн үеэр сурагчид бясалгал хийж болохоос гдана зүгээр л чимээгүй сууж, амарч болдог байна. Энэ үед харин багш нар сурагчдыг ажиглан, тэдний аюулгүй байдлыг хангахад анхаардаг бөгөөд хичээлийн дараа, хичээлийн өмнө, завсарлагааны үеэр бясалгал хийх боломжийг багш нарт олгодог.

² АНУ-ын Сан Франциско хотын Визитасион дунд сургуулийн захирлаар 12 жил ажилласан Жэймс С.Дьеркегийн блогоос товчлон орчууллаа. <http://blog.sfusd.edu/2012/09/a-quiet-transformation.html>

Үр дүн: Тухайн сургууль чимээгүй цагийн арга хэмжээг зургаа, долдугаар ангийн сурагчдын дунд хэрэгжүүлж наймдугаар ангийн сурагчдын хяналтын бүлэг болгосон байна. Тус чимээгүй цаг арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш дөрвөн сарын дараанаас мэдэгдэхүйц үр нөлөө ажиглагдаж ирсэн бөгөөд хамгийн эхний үр нөлөө нь зургаа, долдугаар ангийн сурагчдын дунд ямар нэг асуудлаар өөр байгууллага руу холбон зуучлагдах явдал багассан байна. Түүнчлэн зургаа, долдугаар ангийн сурагчдын дунд хичээл таслалт багасахын хамт хоорондоо зодолдох явдал 60 хувиар буурсан байхад наймдугаар ангийнхны дунд хичээл таслалт ба зодолдох явдал хэвэндээ байсан байна. Чимээгүй цаг арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн хичээлийн жилийн төгсгөлд бас нэг анзаарагдсан зүйл нь багш нарын ажлаас чөлөө авах явдал багассан явдал юм. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад багш нарын дунд өвчний улмаас ажлаас чөлөө авах явдал 30 хувиар буурсан үр дүн гарсан.

Хичээлийн жилийн төгсгөд хийсэн судалгаагаар Чимээгүй цаг нь сургуулийн хувьд хамгийн чухал, ач холбогдолтой арга хэмжээ болсныг багш, сурагчид онцлон тэмдэглэсэн бөгөөд сургуулийн уур амьсгал, багшийн эрүүл мэнд, сурагчдын идэвх оролцоонд сайнаар нөлөөлсөн гэсэн. Түүнчлэн сурагчдын 85 хувь нь чимээгүй цаг нь хүүхдүүдийн стрессийг бууруулж, тэдний анхаарал төвлөрлийг сайжруулж, эрүүл мэндийг хамгаалахаас гадна хүчирхийлэл дарамтыг бууруулсан гэж үзсэн. Чимээгүй цаг арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхтэй зэрэгцэн явуулж ирсэн сэтгэл зүйн стандарт тестийн үр дүнгээр сурагчдын стрессийн түвшин буурч, өөртөө итгэх итгэл нэмэгдэж байгаа нь тогтоогдсон.

Эх сурвалж: <http://blog.sfusd.edu/2012/09/a-quiet-transformation.html>

6. Энх тайвны сэнс

Энх тайвны сэнс хийх аяныг 2005 онд АНУ-ын Флорида мужийн ахлах сургуулийн хоёр багш Энн Эерс ба Эллен Макмилан нар эхлүүлснээс хойш дэлхий даяар олон сургуулиудад хэрэгжиж байна. Энэ үйл ажиллагааг ихэвчлэн энх тайвны өдөр болох 9 сарын 21-ныг тохиолдуулан зохион байгуулдаг уламжлал тогтсон байдаг. Энэ арга хэмжээ нь сурагчдад дэлхий дахинд болж буй зөрчил мөргөлдөөн, дайн тулааны эсрэг өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж, энх тайвныг уриалах зорилготой.

Салхин сэнсийг бүтээхэд багахан хэмжээтэй цаас эвсэл биетэй материал, түүн дээр зураг зурж бичих өнгийн харандаа, бүтээлч сэтгэлгээ байхад хангалттай. Хүүхдүүд өөрсдийн салхин сэнсэн дээрээ энх тайвныг уриалсан үг өгүүлбэр бичиж, дүрс зургийг зурж бүтээснээр энх тайвны төлөөх өөрсдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж, салхин сэнсээ ямарваа нэг газарт байрлуулснаар өөрсдийн илгээлтээ салхиар дамжуулан нийт хүмүүст илгээж байна гэсэн утга санааг агуулдаг.




СЭДЭВ 2. ЗӨРЧЛИЙГ ЭНХ ТАЙВНААР ШИЙДВЭРЛЭХ НЬ

АЛХАМ 1. АНГИ ТАНХИМ, СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХ ЗӨРЧЛИЙГ СУДЛАХ НЬ

Багш дараах 2 хувилбарын нэгээр анги танхим, сургуулийн орчинд тохиолддог зөрчлүүдийн жагсаалтыг гаргана.

Хувилбар 1. Зөрчлийн жагсаалт гаргах: Багш нар бүлгээрээ ажиллаж сургуулийн орчинд түгээмэл тохиолддог зөрчлүүдийг нэрлэж, тэдгээр нь хаана? хэзээ? хэр их тохиолддог, түүнийг хэрхэн шийдвэрлэдэг талаар өөрсдийн санал бодлоо хуваалцана.

Хувилбар 2. Зөрчлийн цагаан толгой: Цагаан толгойн үсгийн үсэг бүрээр эхэлсэн зөрчлүүдийг наадаг жижиг цаасан дээр нэрлэж бичих даалгавар оролцогчдод өгнө. Самбарт дараах диаграммыг байрлуулж, оролцогчид өөрсдийн зөрчил бичсэн наалддаг цаасаа диаграммын тохирох нүдэнд байрлуулахыг хүснэ. Бүх оролцогч байрлуулж дууссаны дараа бүлгээрээ хэлэлцэнэ.



АЛХАМ 2. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМЫГ ХЭЛЭЛЦЭХ

Оролцогчдоос зөрчлийг хүмүүс хэрхэн шийддэг талаар, үр дүнтэй шийдвэрлэх ямар арга барил байдаг талаар асууж, өөрсдийн санаа бодлоо хуваалцахыг хүснэ.

Оролцогчдын зүгээс гарсан санаануудыг тухайн аргыг хэрэглэх давтамж ба үр дагаврын хувьд дараах диаграммын аль хэсэгт байрлуулахыг асууж тодруулах байдлаар зөрчлийг шийдвэрлэх арга замуудын талаар хэлэлцэнэ.

Үр дүн	Ойрын үр дагавар	Урт хугацааны үр дагавар
Хожигдол- Хожигдол	Асуудал шийдвэрлэгдэхгүй үлдэнэ. Бие биетэйгээ ярихаа болино. Уур бухимдал хуримтлагдана. Бие биенээ буруутгасаар байна.	Гомдол бухимдал хуримтлагдана. Өөрийгөө өмөөрөх, хамгаалах байр сууринд шилжинэ. Эсрэг тэсрэг байр суурьтай болно. Уур бухимдлаа барьж дийлэхгүй тэсэрнэ. Өшөө хорсол, өшөө авалт, хүчирхийлэл, тулаанд хүрнэ.

Хожил – хожигдол	Хожсон тал хүч чадлаа мэдэрч, үеийнхэнтэйгээ баяр хөөрөө хуваалцана. Хожигдсон тал суларч, доройтож, өөртөө итгэлгүй болж үеийнхэндээ гадуурхагдана. Өрсөлдөөнт уур амьсгал бүрэлдэнэ.	Цаашид өөрийн хувийн сонирхлоо хангахад эрх мэдлийг ашигладаг болно. Дарамт шахалт, шударга бус байдал улам нэмэгдэнэ. Харилцан дайсагнал нь хүчирхийллийг өдөөж, үймээн самуун бий болно.
Хожил-хожил	Аль аль талын үндсэн хэрэгцээ хангагдана. Хоёр талын нөөц бололцоогоо хуваалцана.	Харилцан ойлголцол, хамтын ажиллагаа нэмэгдэнэ. Бие биенээ хүндэтгэсэн уур амьсгал бүрэлдэн тогтоно. Илүү сайн сайхан санаа, шийдэл гарна. Шударга ёсыг эрхэмлэсэн, энх тайванч уур амьсгал бүрэлдэн тогтоно.

АЛХАМ 3. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ


Багш анги танхим, сургуулийн орчинд тохиолддог зөрчлийн хамгийн түгээмэл нэгэн жишээг аван тухайн зөрчлийг шийдвэрлэхийн тулд сонгины хальс аргаар ажиллах тухай хэлнэ. Үүний тулд багшийн зүгээс сонгины хальс аргыг тайлбарлана.

Оролцогчдыг 3-4 хүнтэй бүлэгт хувааж сонгож авсан зөрчлийн жишээн дээр сонгины хальс аргаар анализ хийх даалгавар өгнө.

Сонгины хальс арга (Зөрчлийг шийдвэрлэх)

Зөрчлийг шийдвэрлэх үйл явцыг сонгины хальсыг хуулахтай адил гэж үздэг. Сонгиноор зүйрлэвэл хүний хэрэгцээ нь олон давхар хальсаар хүрээлэгдэн сонгины голд орших ба хэрэгцээ хангагдаагүйгээс үүдсэн дотоод бодол нь хүнд ямар нэг мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үүсгэж, улмаар зөрчлийн үед ямар нэг үйл хөдлөл хийх, зан үйл гаргахад хүргэдэг гэж үздэг. Жишээ нь

Би түүний дэвтрийг ширээн дээрээс унагааснаар бид маргалдаж эхэлсэн (үйлдэл/зан үйл), “би түүнийг дотроо хохь нь гэж бодсон” (дотоод бодол), учир нь тэр миний хэлсэн үгийг шоолон даажигнахад надад эвгүй санагдаж, гомдсон (мэдрэмж, сэтгэл хөдлөл), тэр зүгээр л намайг сонсох байсан юм (хэрэгцээ).



Анги танхим, сургуулийн орчинд тохиолддог зөрчлийн жишээг бичнэ үү

(Хүүхдүүд бие биедээ нэр хоч өгснөөс бол зөрчилдөх

Хүүхдүүд бие биенээ өмссөн зүүснээр нь ялгаварлан гадуурхах

Сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, сурах бичгийн хангамж дутагдах

Багш, эцэг эхийн зүгээс аль нэг талыг барих, өрөөсгөл хандсанаас болж хүүхдүүд зөрчилдөх

Хүүхэд өөрийн оролцохыг хүссэн арга хэмжээнээс хасагдах

Хүүхэд сургуулиас шаардсан зүйлийг худалдан авах боломжгүй байх

Өсвөр насны хүүхдүүд сэтгэл зүйн тогтворгүй байдлаасаа болж болчимгүй үг үйлдэл гаргах)

Жишээ	Үйлдэл/зан үйл	Бодол санаа	Сэтгэл хөдлөл/ мэдрэмж	Хэрэгцээ

АЛХАМ 4. ДАСГАЛЫН ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН ДАРААХ АСУУЛТЫН ДАГУУ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ, НЭГТГЭН ДҮГНЭНЭ.

- Анги танхим, сургуулийн орчинд тохиолддог зөрчлүүдийн жагсаалт гаргах нь ямар ач холбогдолтой вэ?
- Анги танхим, сургуулийн орчинд тохиолддог зөрчлүүдийн үед багш, сурагчдын зүгээс ямар арга барил, хандлага баримталж байна вэ? Энх тайвныг эрхэмлэх хандлагыг хэр хэрэглэж байна вэ?
- Анги танхим, сургуулийн орчинд тохиолддог зөрчлийг шийдвэрлэхэд сонгины хальс арга хэр үр дүнтэй байна вэ? Тус аргыг практикт хэрэглэх боломжтой юу? Зөрчлийг шийдвэрлэх ямар чухал санаа, ач холбогдолтой байна вэ?

АЛХАМ 5. ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ӨӨРИЙН БАЙР СУУРЬ, ХАНДЛАГЫГ ОЙЛГОХ НЬ

- Багш оролцогчдод дараах асуулгын хуудсыг тараан өгч, зөрчлийн талаар өөрийн үзэл бодол, хандлага, байр сууриа үнэлэхийг хүснэ.
- Оролцогчдыг бөглөж дууссаны дараа дараах хүснэгтэд өгөгдсөн тайлбарыг танилцуулах ба хүмүүст өөрийгөө үнэлэн дүгнэхийг хүснэ.
- Тухайн асуулгад өгсөн хариулт нь хувь хүний үзэл бодол, хандлагыг илрүүлдэг учраас хэн нэг оролцогчийн хариултыг нийт оролцогчдын өмнө хэлэлцүүлэх шаардлагагүй. Харин оролцогчдыг өөрсдийн үр дүндээ үндэслэн зөрчлийн талаар өөрийн үзэл бодол, байр сууриа танин мэдэхэд чиглүүлж, ач холбогдлыг тайлбарлана.

Зөрчилд хандах хувь хүний хандлага, үзэл бодол	Дараах дугаар бүхий өгүүлэмжид бүрэн санал нийлнэ, санал нийлнэ гэсэн хариулт өгсөн бол
Зөрчлийг эсэргүүцэх, зөрчлийн үед түрэмгийлэх хандлага	1, 2, 8, 9, 11, 13
Зөрчлийн үед зайлсхийх хандлага	3, 12, 15,
Зөрчлийн үед эв зүйгээр шийдвэрлэхийг хичээх хандлага	4, 6, 7, 10, 14, 16, 17, 18

Нөөц хэрэглэгдэхүүн 2.1. Зөрчлийн талаарх өгүүлэмж

		Бүрэн санал нийлнэ.	Санал нийлнэ	Хэлж мэдэхгүй байна.	Санал нийлэхгүй.	Огт санал нийлэхгүй
1	Зөрчил угаасаа байж болохгүй зүйл.	5	4	3	2	1
2	Надад зөрчил тохиолддоггүй.	5	4	3	2	1
3	Би зөрчилдөхөөс айдаг. Халширдаг.	5	4	3	2	1
4	Хүмүүс зөрчилдөх нь сонирхолтой.	5	4	3	2	1
5	Хүсэх юм бол бүх зөрчлийг шийдвэрлэж болно.	5	4	3	2	1
6	Зөрчил заримдаа сайн үр дүнд хүргэдэг.	5	4	3	2	1
7	Зөрчлийн үед хүч хэрэглэх нь буруу.	5	4	3	2	1
8	Заримдаа хүч хэрэглэхээс аргагүй үе байдаг.	5	4	3	2	1
9	Зөрчлийг заримдаа хүчээр шийдэх нь амар байдаг.	5	4	3	2	1
10	Зөрчлийг шийдвэрлэх арга замд суралцаж болно.	5	4	3	2	1
11	Өөрийгөө хамгаалахын тулд хүч хэрэглэж болно.	5	4	3	2	1

12	Би бусдыг хохироохоосоо өмнө өөрөө хохироод үлдэхийг илүүд үзнэ.	5	4	3	2	1
13	Заримдаа сайн сайхан зүйлийн төлөө хүч хэрэглэхээс аргагүй үе байдаг.	5	4	3	2	1
14	Зөрчлийг заавал шийдвэрлэх ёстой.	5	4	3	2	1
15	Зөрчлийг хайхрахгүй орхивол аяндаа шийдэгдэнэ.	5	4	3	2	1
16	Зөрчлөөс урьдчилан сэргийлж болно.	5	4	3	2	1
17	Бусад хүн зовж зүдэрч байхад түүнийг чимээгүйхэн хараад суух нь амиа хичээсэн үйлдэл юм.	5	4	3	2	1
18	Хүчирхийлэл голдуу айдсаас урган гардаг.	5	4	3	2	1



СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Зөрчлийн мөн чанарын тухай хүмүүсийн үзэл бодол, ойлголт, хандлага ялгаатай байдаг. Тус хичээл нь зарим оролцогчийн зөрчлийн тухай ойлголт, хандлага, үзэл бодолтой тэрсэлдэж болно. Иймд зөрчил зайлшгүй болох тухай, зөрчлийг хүчээр шийдвэрлэхгүй байх тухай, зөрчлөөс зайлсхийхгүй байх тухай заахдаа оролцогчдод тунгаан бодох хугацаа өгч, энэ талаар хатуу үзэл бодолтой хүмүүсийн ойлголт, үзэл бодлыг шууд няцаахгүйгээр уян хатан хандах нь зүйтэй.
- Зөрчилд хандах хувь хүний хандлагыг тодорхойлох тестийн үр дүнг нийт оролцогчдын өмнө асуух нь зохимжгүй. Иймд тестийн үр дүнг зөвхөн тухайн оролцогч өөрөө харах, анализ хийх боломжтой байлгах үүднээс тестийн үр дүнгийн тайлбарыг танилцуулж, өөрөө өөртөө анализ хийх боломж олгоорой.
- Багшийн зүгээс нийгэмд зөрчил зайлшгүй учраас зөрчлийг энх тайвнаар шийдвэрлэх чадвар чухал болохыг оролцогчдод ойлгуулж, зөрчлийн

үед өөрийн ба бусдын байр суурийг сонсож, ойлгож хүлээн авч, харилцан зөвшилцөж, дундын шийдлийг олох нь зүйтэй гэсэн хандлагыг төлөвшүүлэхэд анхаарна.



УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛ, НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

Зөрчил бол хүний амьдралын салшгүй нэг хэсэг юм. Энэ утгаараа зөрчил хаа сайгүй байдаг. Нийгэм хөгжихийн хирээр хүмүүс хоорондын харилцаанд зөрчил улам бүр нэмэгдэх хандлага ажиглагдах болсон. Энэ нь хүмүүс хоорондын ялгаатай байдал нэмэгдэж байгаатай зарим талаар холбоотой. Иймд зөрчлийг ойлгож, түүнийг хүчирхийлэлгүйгээр, үр дүнтэй шийдвэрлэх чадвар хүмүүс бидэнд чухал болж байна.

Росс Стингер (1967)-ийн тодорхойлсноор зөрчил нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн үзэл бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм. Хүмүүс хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг.

- Нөхцөл байдал:
 - зөрчилдөгч талууд бие биенийгээ дундын ашиг сонирхолтой гэж харахаас илүү өрсөлдөгч байр сууринд авч үзэх
- Хандлага:
 - Үзэн ядах, айх хандлагатай байх
- Зан үйл:
 - Заналхийлэх, эсэргүүцэх, дайрах, амиа хичээх зан үйл гаргах

Зөрчлийн шалтгаан. Зөрчил нь юуны өмнө нөөц боломжийн хомсдлоос гадна, зөрчилдөж буй талуудын хэрэгцээ хангагдаагүй байх, эсвэл талуудын ялгаатай байдлаас үүсэн бий болдог гэж үздэг.


- Зөрчил нь юуны өмнө хүмүүсийн дундын нөөц боломж хомс байдгаас зөрчил үүсдэг. Жишээ нь ангид хорин хүүхэд байхад дунд нь 10 зүсэм торт авчирлаа гэж бодье. Хүүхэд бүхэн тортноос идэхийг хүсэх ч торт хүүхэд бүрт хангалтгүй тул хүүхдүүд өрсөлдсөний улмаас зөрчил үүсч болно. Нөөц боломж хомс, хязгаарлагдмал байдаг. Жишээ нь цаг хугацаа, мөнгө, эд хөрөнгө зэрэг жишээ дурдаж болно.
- Зөрчил үүсгэдэг дараагийн шалтгаан нь хүний хэрэгцээ хангагдахгүй байх явдал юм. Хүн бүрт үндсэн хэрэгцээ бий. Жишээ нь бид бүгд эрүүл саруул байх, эрх чөлөөтэй байх хэрэгцээтэй. Гэвч хүний үндсэн хэрэгцээ хангагдахгүй, эсвэл бид үндсэн хэрэгцээгээ хангах боломжгүй байх үед хүмүүс зөрчилддөг.

- Зөрчил үүсгэдэг гурав дахь шалтгаан бол бид бүхэн өөр өөр бодолтой, өөр хүсэл сонирхолтой байдаг явдал юм. Бидний зарим нь газар зүйн хичээлд дуртай байхад зарим нь биеийн тамирын хичээлд дуртай байдаг. Хүмүүс өөр өөр ёс уламжлалтай байж болно. Зарим нь гараараа хоолоо барьж иддэг байхад зарим нь заавал халбага сэрээгээр иддэг гэх мэт. Хүмүүс хоорондын ялгаатай байдлын улмаас харилцах үед тэдгээрийн үзэл бодол, шашин шүтлэг, соёл мөргөлдсөнөөс болж хүмүүс хоорондоо зөрчилддөг. Хүмүүс бид аливаа юмсыг өөр өөрөөр хардаг талаар тайлбарлахад хэрэглэх нэмэлт материал харна уу

Зөрчлийн зарим шалтгаан	Хязгаарлагдмал нөөц	Цаг хугацаа Хөрөнгө мөнгө Эд баялаг
	Хангагдаагүй хэрэгцээ	Харьяалагдах хэрэгцээ Эрх мэдэлтэй байх Эрх чөлөөтэй байх Чөлөөт цагаа өнгөрөөх
	Хүмүүс хоорондын ялгаатай байдал	Хүсэл сонирхол Зан заншил Үнэт зүйл Итгэл үнэмшил

Зөрчлийн гүнзгийрэл. Хүмүүс хооронд үүссэн аливаа зөрчлийг шийдвэрлэхгүй бол улам гүнзгийрдэг. Зөрчил яагаад гүнзгийрдэг талаар эргэцүүлье.

- Хүмүүст зөрчлийг эхэн үед нь шийдвэрлэх ур чадвар дутагдсанаас зөрчил нь улам бүр гүнзгийрч хүндэрдэг. Харин зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэснээр өөртөө итгэх итгэл нэмэгдэж, харилцаа холбоо сайжирч, өсөлт хөгжил бий болдог.
- Зөрчлийн үед үүсдэг мэдрэмж хүнийг тавгүй байдалд оруулдаг. Үүнтэй холбоотой зарим хүмүүс зөрчилдөхөөс зайлсхийх улмаар аль болох зөрчилдөхгүйг хичээх хандлагатай болдог. Зөрчил гүнзгийрэх нь айдас түгшүүр, эргэлзээ тээнэгэлзэл, гомдол, үзэн ядалт зэрэг сөрөг сэтгэл хөдлөлд хөтөлдөг. Гэхдээ хүн зөрчилтэй нөхцөлд тухайн үүссэн асуудалд сэтгэл хөдлөлөөр хандахаас илүү саруул ухаанаар хандаж бэрхшээл гэхээсээ түүнийг сорилт гэж ойлгон эерэг талаас харж сурах хэрэгтэй.
- Зөрчилтэй тулгарах үед хүмүүсийн гаргадаг түгээмэл хандлага бол аль болох нөгөө талаа ялан дийлэхийг хичээх явдал байдаг. Ингэснээр нөгөө талын хүн ч гэсэн ялан дийлэхийг хичээсэн арга барилыг хэрэглэдэг. Зөрчлийг шийдвэрлэхэд улам бэрх болгодог хүмүүс бидний үг яриа, хандлагын зарим жишээг зөрчлийн шат зургаас харна уу.



Зөрчлийн үед хүмүүсийн гаргадаг хариу үйлдлийг зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэргээр сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайвны арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сэргөлдөгч талууд бие биенийнхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох арга замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.

Зөөлөн хариу үйлдэл	Аль болох зөрчилдөхгүйг хичээх Зөрчлөөс зайлсхийх Зөрчил байгааг үгүйсгэх Зөрчилд бууж өгөх
Хатуу хариу үйлдэл	Хэл амаар доромжлох Бие махбодын хүчирхийлэл (Түлхэх, нудрах, цохих)
Энх тайванч хариу үйлдэл	Тодруулах: • Анхааралтай сонсох • Ойлгох Хүндэтгэх • Өөр үзэл бодолтой байгааг нь хүлээн зөвшөөрөх Шийдвэрлэх • Дундын шийдлийг олох Бүтээх, санаачлах • Шинэ арга замыг хайж олох, нээх илрүүлэх Хүчирхийлэл үл хэрэглэн өөрийн байр сууриндаа бат зогсох

Хүснэгт 1. Зөрчилд хариу үйлдэл үзүүлэх арга замууд (эх сурвалж: Richard J.Bodine, Donna K.Crawford, Fred Schrumph, *Creating the Peaceful school*, Research Press, Illinois, 1994, р34)

Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг арга барил

Хүмүүс зөрчлийн үед тодорхой арга барилыг хэрэглэж хэвшсэн байдаг. Нэгэнт хэвшин тогтсон учир өөрсдийгөө тухайн арга барилыг хэрэглэдэг гэдгээ тэр бүр мэддэггүйгээс болж өөрийгөө зөвтгөх, бусдыг буруутгах хандлагатай байдаг байна. Иймд зөрчлийг шийдвэрлэхэд чухал нэг алхам нь хүмүүс өөрсдийн байнга хэрэглэдэг арга барилаа танин мэдэж, зөрчлийн үед тухайн арга барилыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэх талаар тунгаан бодох явдал юм. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг түгээмэл арга барилуудыг дараах таван амьтнаар төлөөлүүлэн тайлбарласан байдаг.

1. Яст мэлхий: Зөрчлийн үед өөрийн байр суурийг илэрхийлж, бусдын байр суурийг сонсох замаар зөрчлийг шийдвэрлэх гэж хичээхээс илүү зөрчлийг үл хайхарч, зөрчилт байдалд орохоос зугатан зайлахыг эрмэлздэг. (Зайлсхийх арга барил)
2. Баавгай: Зөрчлийн үед үүссэн асуудлыг шийдвэрлэхээс илүү харилцаагаа хадгалахыг эрмэлздэг. Зөрчилт нөхцөл байдлыг орхиж, аяндаа шийдэгдэхээр үлдээдэг. (Зохицох арга барил)
3. Үнэг: Зөрчлийг аль болох зохицуулахыг эрмэлздэг. Зөрчил гэдэг нь харилцан хоёр тал байр сууриа өөрчлөх замаар буюу өгч, авах замаар шийдвэрлэх боломжтой зүйл гэж үздэг. (Зохицуулах арга барил)
4. Шар шувуу: Дундын шийдлийг олохыг эрмэлздэг. Зөрчлийг

шийдвэрлэхийн тулд цаг зав, хүчин чармайлт гаргадаг. Харилцаанд ач холбогдол өгөхийн хамт зөрчилтэй асуудлыг шийдвэрлэхийг хичээдэг.

5. Аварга загас/Арслан: Зөрчилтэй шууд нүүр тулдаг. Өөрийн байр сууриа хүчтэй илэрхийлж, өөрийнхөө зүтгэж дайрах замаар зөрчлийн үед ялахыг эрмэлздэг. (Өрсөлдөх арга барил)



Зөрчлийг шийдвэрлэх боломжит дөрвөн шийдэл байдаг. Зөрчилдөж буй хоёр талыг А ба Б тал гэж нэрлэвэл тэдний дунд үүссэн зөрчил нь дараах дөрвөн хувилбарын аль нэгээр шийдэгдэж болно.

	<u>А</u>	<u>Б</u>
1.	Хожил	Хожигдол
2.	Хожигдол	Хожил
3.	Хожигдол	Хожигдол
4.	Хожил	Хожил

Дээрх хувилбараас харахад 1 ба 2 дугаар хувилбарт хоёр талын аль нэг нь нөгөөгөө ялан дийлж байгаа нь харагдаж байна. Харин 3 дугаар хувилбарт зөрчилдөж буй хоёр тал хоёулаа хожигдож байна. Хоёр хүүхэд хоорондоо хэрэлдэж муудснаас болж тэд багш, эцэг эх, асран хамгаалагчдаа зэмлүүлж байгаа тохиолдол нь гурав дахь хувилбар юм. Эдгээр шийдвэрээс 4 дэх хувилбар нь зөрчлийг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй, оновчтой хувилбарт тооцогддог. Хоёр тал хоёулаа хожихийн тулд бие биенээ сонсож, өөр өөрсдийн хатуу байр сууринаас ухарч дундын шийдэлд хүрэх ёстой гэж үздэг.

Үр дүн	Ойрын үр дагавар	Урт хугацааны үр дагавар
Хожигдол- Хожигдол	Асуудал шийдвэрлэгдэхгүй үлдэнэ. Бие биетэйгээ ярихаа болино. Уур бухимдал хуримтлагдана. Бие биенээ буруутгасаар байна.	Гомдол бухимдал хуримтлагдана. Өөрийгөө өмөөрөх, хамгаалах байр сууринд шилжинэ. Эсрэг тэсрэг байр суурьтай болно. Уур бухимдлаа барьж дийлэхгүй тэсэрнэ. Өшөө хорсол, өшөө авалт, хүчирхийлэл, тулаанд хүрнэ.
Хожил – хожигдол	Хожсон тал хүч чадлаа мэдэрч, үеийнхэнтэйгээ баяр хөөрөө хуваалцана. Хожигдсон тал суларч, доройтож, өөртөө итгэлгүй болж үеийнхэндээ гадуурхагдана. Өрсөлдөөнт уур амьсгал бүрэлдэнэ.	Цаашид өөрийн хувийн сонирхлоо хангахад эрх мэдлийг ашигладаг болно. Дарамт шахалт, шударга бус байдал улам нэмэгдэнэ. Харилцан дайсагнал нь хүчирхийллийг өдөөж, үймээн самуун бий болно.
Хожил-хожил	Аль аль талын үндсэн хэрэгцээ хангагдана. Хоёр талын нөөц бололцоогоо хуваалцана.	Харилцан ойлголцол, хамтын ажиллагаа нэмэгдэнэ. Бие биенээ хүндэтгэсэн уур амьсгал бүрэлдэн тогтоно. Илүү сайн сайхан санаа, шийдэл гарна. Шударга ёсыг эрхэмлэсэн, энх тайванч уур амьсгал бүрэлдэн тогтоно.

Зөрчлийг бүтээлчээр, үр дүнтэй шийдвэрлэхийн тулд дараах зүйлийг анхаарах нь чухал:

- Сөрөг сэтгэл хөдлөлөө хянах
- Идэвхтэй сонсох
- Тодорхой ярих
- Бусдын хэрэгцээ, асуудал, бэрхшээл, хариу үйлдлийг ойлгохыг хичээх
- Бэрхшээлтэй шууд тулах
- Хувь хүн рүү дайрахгүй байх
- Асуудал шийдвэрлэх арга барилаар ажиллах
- Ойлгож байгаагаа илэрхийлэх
- Бодит баримт нотолгоо, үндэслэлтэй үед байр сууриа өөрчлөхөд бэлэн байх
- Та болон харилцаж буй нөгөө талд аль алинд нийцсэн өөр хувилбар гаргах
- Тууштай байх

СУРГАЛТЫН АГУУЛГА, АРГА ЗҮЙ ТХ-ИЙН ЗОРИЛГУУДАЙ УЯЛДУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Энэхүү сургалтын модульд санал болгосон сэдэв, агуулга, арга зүй нь ТХБ-ын тодорхой нэг хэсгийг хөндсөн тул сургагч багш та хичээлийн арга зүйн санааг ТХ-ийн дараах зорилгуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүйгээр баяжуулан хөгжүүлэх бүрэн боломжтой болохыг санал болгож байна.



Ядуу эмзэг байдалд байдалд байгаа хүмүүсийн уян хатан байдлыг бэхжүүлэх, аюулд өртөх эмзэг байдлыг бууруулах



Эмэгтэйчүүд, уугуул ард иргэд, өндөр настны хоол тэжээлийн асуудлыг шийдэх



Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчнийг дайчлах



Тогтвортой хөгжлийг түргэсгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх нөхцөлийг хангах
Бүх хүмүүс аюулгүй, хүчирхийлэлгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчинг хангах



Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, мөлжлөгийг устгах
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах




Усны бохирдлыг багасгах, бохир хаягдал цутгахыг зогсоох, химийн хорт бодис болон материал цутгахыг бууруулах



Аюулгүй, байнгын, хариуцлагатай цагаачлал болон хүн амын шилжилт хөдөлгөөнийг хэрэгжүүлэх



Олон талт оролцогчдын түншлэлийг дэмжих



СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ



БАГШИД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН БҮТЭЦ



ЗОРИЛГО



ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД



ХИЧЭЭЛИЙН БЭЛТГЭЛ



ХИЧЭЭЛИЙН ЯВЦ



Багшийн чиглүүлэг, дүгнэлт



Нөөц хэрэглэгдэхүүн



Холбоос (линк)

Хичээл 1. Энх тайван гэж юу вэ? (Садако Сасаки охин ба мянган тогорууны түүх)



ЗОРИЛГО

Суралцагчдад энх тайвны тухай ойлголтыг гүнзгийрүүлэн эзэмшүүлж, дайн тулааны сөрөг үр дагавар, аюулын тухай хэлэлцэх замаар энх тайвныг эрхэмлэх хандлага төлөвшүүлэх



ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

- **Энх тайван, хамрах хүрээ:** Дайн мөргөлдөөн, хүчирхийллийн бүхий л хэлбэр, аюул занал, нийгмийн доройтол, ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, ядуурал, шударга бус байдал зэргээс ангид байх нь энх тайван юм. Энх тайван нь хувь хүний дотоод амар амгалангаас гадна хүмүүс хоорондын, нийгэм, олон нийтийн, олон улсын, цаашлаад даян дэлхийн энх тайвныг хамрах өргөн хүрээний ойлголт юм.
- **Энх тайван:** Хүчирхийлэл, дарамтаас ангид байхаас гадна хүн аз жаргалтай, эрүүл аж төрөх, өөрийгөө илэрхийлэх, бүтээн туурвих эрх чөлөө, боломж хангагдсан нөхцөлд жинхэнэ буюу эерэг энх тайван цогцолно гэж үздэг. Энх тайвны үед хүмүүсийн дундах буруу тогтсон хандлагыг өөрчилж, ялгавар гадуурхалт, хүний эрхийн зөрчил, эдийн засгийн доройтол, шударга бус байдлыг арилгахын тулд хүмүүс идэвхтэй хүчин чармайлт гаргаж хамтран ажилладаг.
- **Хуурмаг энх тайван:** Хоёр тал хоорондоо дайтахгүй ч зөрчил тэмцэл нь байсаар байхыг хуурмаг энх тайван гэнэ.¹ Өөрөөр хэлбэл дарамт хүчирхийлэлгүй л болохоос хүний сайхан амьдрах бусад нөхцөл боломж бүрдээгүй байдлыг хэлнэ. Хүмүүст шууд ба шууд бусаар нөлөөлөх дарангуйллын дэглэм, хүчирхийлэл, дарамт байхгүй үед тайван байдалд оршин байж болох ч хүмүүсийн эрх, эрх чөлөө хязгаарлагдмал байдал нь алдагдана. Жишээ нь сөргөлдөгч талууд бие биенийхээ эсрэг гал нээхгүйгээр тохиролцох, тоглоомын талбай, эсвэл ангид зодолдохыг хориглох гэх мэт нь хүчирхийллийг хориглож буй хэдий ч далд зөрчил нь байсаар байхыг хэлнэ.

¹ Жон Галтунг



ХИЧЭЭЛИЙН БЭЛТГЭЛ

Багш дараах хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэсэн байна. Үүнд:

- Наадаг цаас (өнгө өнгийн)
- Өнгийн харандаа, бал
- Садако Сасаки охины түүх
- Цаасан тогоруу хийх заавар
- Цаасан шувуу дууны үг



ХИЧЭЭЛИЙН ЯВЦ


	Үйл ажиллагааны агуулга	Хичээлд хэрэглэх арга	Нөөц хэрэглэгдэхүүн	Нэмэлт даалгавар
1.	Энх тайвны бэлгэ тэмдэг	Дасгал Хэлэлцүүлэг	1.1. Энх тайвны бэлгэ тэмдэг	Цаасан тогоруу хийх даалгавар Цаасан шувуу дуу сурах Энх тайвны гэр, байшин бүтээх
2.	Энхтайван ба хуурмаг энх тайван	Дасгал Хэлэлцүүлэг	1.2. Энх тайвны эргэцүүлэл	
3.	Энх тайвны хамрах хүрээ	Дасгал Хэлэлцүүлэг	1.3. Энх тайвны хамрах хүрээ	
4.	Дайн тулааны аюул	Түүх судлах Хэлэлцүүлэг	1.4. Сасаки охины түүх	
5.	Энх тайвны баатрууд ба тэдний уриа	Хосоор ажиллах Хэлэлцүүлэг	1.5. Энх тайвны баатрууд, тэдний уриа 1.6. Энх тайван үгийн сүлжээ	

Үйл ажиллагаа 1. Энх тайвны бэлгэ тэмдгийг таних

- Багш хүүхдүүдэд хандан хичээлээр энх тайвны талаар хэлэлцэнэ гэдгийг хэлнэ.
- Самбарт “Энх тайван” гэсэн үгийг томоор бичих ба хүүхдүүдийг энэ талаар хэсэг хугацаанд эргэцүүлэн бодохыг хүснэ.

- Хүүхдүүдийг хэсэг хугацаанд бодуулсны дараа Энх тайван гэж юу вэ гэсэн асуултын хүрээнд хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ. Энэ үйл ажиллагааг дараах 2 хувилбараар явуулж болно.

Хувилбар 1. Оролцогч бүрд наадаг цаас 2-3 ширхгийг тараан өгч, “Энх тайван” гэдэгтэй холбогдох үг хэллэг, нэрийг бичихийг хүснэ.



Гарч болох хариулт:

- Энхийн цагаан тагтаа
- Хайр/Гэр бүл
- Нөхөрлөл
- Бие биедээ туслах
- Амар амгалан
- Дайн тулаангүй байх

Хувилбар 2. Оролцогч бүрд наадаг цаас 2-3 ширхгийг тараан өгч, “Энх тайван” гэсэн хэллэгийг зураг, дүрслэлээр илэрхийлж зурахыг хүснэ.



Зүрхний зураг

Найз нөхөд

Цэцгийн дэлбээ

Дуу хөгжим

Тагтаа

Нар, тэнгэр, үүл

- Багш хүүхдүүдийг өөрийн бичсэн үг хэллэг эсвэл зураг, дүрсийг дэлгэц цаас эсвэл самбарт байршуулахыг хүснэ.
- Бүх хүүхдийг өөрсдийн цаасаа бүрэн байршуулсны дараа ижил төстэй байдлаар нь ангилж хэлэлцүүлэг өрнүүлнэ. Үүний тулд багш зарим оролцогчдоос өөрийн бичсэн үг, өгүүлбэр, зургийг тайлбарлахыг хүсэж болно.

Хэлэлцүүлгийн явцад хүүхдүүд энх тайвны талаар ямар ойлголт, төсөөлөлтэй байгаа нь тодорхой болох бөгөөд хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн “Энх тайван”-д юу багтдаг талаар оролцогчдоос гарсан санааг багш нэгтгэн дүгнэнэ.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Багш дараах байдлаар энх тайвны тухай нэгтгэн дүгнэж болно.

- Энх тайван гэдэг бол аав, ээжийн, үр хүүхдийн, найз нөхдийн, багш, сурагчийн бие биенээ гэсэн хайр юм
- Хүмүүс бие биеэ хүндэтгэдэг газар энх тайван оршдог
- Энх тайван хүндлэлээс эхэлнэ
- Хүн өөрийн хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлдэг байх нь энх тайвны үндэс юм.
- Энх тайван зүрх сэтгэлээс урган гардаг
- Энх тайван байгаа газар хүн эрүүл саруул байдаг
- Хүүхдүүд дуулж, бүжиглэж, хөгжимдөж байвал тэнд энх тайван байна
- Найз нөхөд, эцэг эх, үр хүүхдийн холбоо, багш шавийн холбоо, харилцан хүндлэл нь энх тайвны үндэс юм.

Хэлэлцүүлгийн дараа багш нөөц хэрэглэгдэхүүн 1.1-д өгөгдсөн энх тайвны бэлгэ тэмдгийг судлах нь сэдэвт дасгал ажлын хуудсыг хүүхэд бүрт тараан өгч зургуудыг өгүүлбэртэй холбон тохируулахыг хүснэ. Улмаар зарим хүүхдүүдээс өгүүлбэрүүдийг зурагнуудтай хэрхэн тохируулан холбосноо бусад хүүхдэд танилцуулахыг хүснэ.

Дасгалын үр дүнд үндэслэн энх тайвныг цагаан тагтаа, олив жимсний мөчир зуусан цагаан тагтаа, цэцэг, долоовор дунд хуруугаа гозойлгосон дүрс, бясалгаж буй хүн, хүүхэд, инээмсэглэл, солонго зэрэг дүрсүүдээр бэлэгддэг тухай хэлнэ.




Уншиж судлах материал





Нөөц хэрэглэгдэхүүн 1.1. Энх тайвны бэлгэ тэмдэг

1. Энх тайвны модыг цэцэглүүлэх үрийг тарьцгаая.
2. Бусдыг сонсож ойлгох нь энх тайвны нэг үндэс юм.
3. Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх нь энх тайвны үндэс суурь юм.
4. Энх тайвны төлөө гараа өргөцгөөе.
5. Энх тайван тогтсон газар аз жаргал дэлбээлдэг.
6. Энх тайван инээмсэглэлээс эхэлдэг.
7. Нэг хүний амар амгалан нэлээд хүний энх тайвныг цогцлооно.
8. Энхийн цагаан тагтаа нь энх тайвны бэлгэ тэмдэг юм.



Хариулт

1-а

3-е

5-в

7-ё

2-г

4-д

6-з

8 - б



Бие даан ажиллах дасгал даалгавар



Үйл ажиллагаа 2. Энхтайван ба хуурмаг энх тайвныг ялган таних

Хүүхдүүдийг тойрог болгон суулгана. Багшийн зүгээс энх тайван нь заримдаа хуурмаг байдаг тухай хэлээд үүнтэй холбоотой дасгал ажиллана гэдгийг хэлнэ.

Багш дараах түүхийг ярьж өгнө.

“Нэгэн улс байжээ. Тэр улсад дайн дажин байхгүй. Гудамж, сургууль гээд бараг бүх байгууллагын ханан дээр “Зодолдохыг хориглоно, тэгвэл шийтгэнэ” гэсэн санамж бичиг хадаастай байдаг ба энд тэндгүй цэрэг, цагдаа эргүүл хийдэг байв. Тэр улсын хүмүүс нь баян, ядуугаараа ялгаран тус тусдаа амьдардаг ба баян хүмүүс нь ядуу хүмүүсээсээ айдаг, ядуу хүмүүс нь баян хүмүүстээ атаархдаг байлаа.”

Дээрх түүхийг уншиж өгсний дараа багш дараах асуултыг асууна.

- Энэ улсад дайн дажин өрнөж байгаа юу?
 - Хүүхдүүдийн хариулт – Үгүй
- Тэгвэл энэ улсад энх тайван байгаа юу?
 - Хүүхдүүдийн хариулт – Зарим нь тийм, зарим нь үгүй гэж хариулж болно.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Дээрх хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн багш хуурмаг энх тайвны тухай дараах байдлаар тайлбарлана.

Хэдийгээр дээрх улсад дайн дажин байхгүй ч гэсэн энх тайван байж чадахгүй байна. Учир нь хүмүүс нийгмийн өөр өөр бүлгүүдэд хуваагдаж, бие биенээсээ айж, эсвэл атаархаж амьдардаг. Хэдийгээр ил тод зөрчил байхгүй ч цэрэг цагдаа аюулгүй байдлыг хангадаг, энд тэндгүй хориглосон дүрэм байдаг зэрэг нь хуурмаг энх тайвныг илэрхийлж байна.

Нөөц хэрэглэгдэхүүн 1.2–д өгөгдсөн өгүүлэмжүүдийг хүүхэд бүрт нэг нэгээр нь тараан өгч, өөрт оногдсон өгүүлэмжийг уншиж, өгүүлэмжийн утгатай санал нийлж буй эсэхээ эргэцүүлэн тунгаахыг хүснэ. Улмаар хүүхдүүд өөрт оногдсон өгүүлэмжээ бусдадаа чангаар уншиж өгөн “тийм” эсвэл “үгүй” гэсэн хариултыг хэлэхийг хүснэ. Ийм маягаар бүх өгүүлэмжийг дуусгана.

Дараах хүснэгтийн эхний баганад өгүүлэмжид тохирох хариултыг бичсэн. Багшийн зүгээс өгүүлэмжийг уншсан хүүхдүүд өөр хариулт өгсөн тохиолдолд зөв хариулт гаргуулах үүднээс нэмэлт асуулт асууж, зөв хариултад чиглүүлнэ.

Үгүй	Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхгүй бол энх тайван байж чадах уу?
Үгүй	Хүмүүс бие биенээ сонсохгүй бол энх тайван байж чадах уу?
Үгүй	Хүүхдүүдийн гэрээс сургууль явдаг зам харанхуй, бартаа ихтэй байвал хүүхдүүд энх тайван байж чадах уу?
Үгүй	Хүмүүс архи уугаад байвал энх тайван байж чадах уу?
Үгүй	Хүүхдүүд нэг нэгнээ дээрэлхээд байвал энх тайван байж чадах уу?
Үгүй	Хүн бүр амиа хичээвэл энх тайван тогтох уу?
Тийм	Хүн бүр бие биенээ сонсдог бол энх тайван тогтох уу?
Тийм	Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг бол энх тайван тогтох уу?
Үгүй	Зөвхөн миний аав ээж, гэр бүлийнхэн л сайн сайхан амьдарч байвал энх тайван мөн үү?
Үгүй	Зөвхөн эх орон минь дайн дажингүй байвал бусад улс орны хямрал бидэнд хамаагүй гэж бодвол энх тайван мөн үү?
Тийм	Эх дэлхийгээ хайрлах нь энх тайвны нэг хэсэг мөн үү?
Тийм	Ан амьтныг хайрлах нь энх тайвны нэг хэсэг мөн үү?
Тийм	Нэг хүний амар амгалан байдал энх тайванд хувь нэмэр оруулах уу?
Үгүй	Ахмад үеэ хүндлэхгүй бол энх тайван тогтох уу?
Үгүй	Хүүхдүүдийг хайрлахгүй бол энх тайван тогтох уу?
Үгүй	Айдас түгшүүртэй хүн энх тайван байж чадах уу?

Дасгалын үр дүнд үндэслэн хуурмаг энхтайвны тухай дараах агуулгыг тайлбарлана.

- Зөвхөн дайн мөргөлдөөн гэлтгүй хүчирхийллийн бүхий л хэлбэр, аюул занал, нийгмийн доройтол, ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, ядуурал, шударга бус байдал зэргээс ангид байх нь энх тайван юм.
- Хүмүүст шууд ба шууд бусаар нөлөөлөх дарангуйллын дэглэм, хүчирхийлэл, дарамт байхгүй үед тайван байдал оршин байж болох ч хүмүүсийн эрх, эрх чөлөө хязгаарлагдмал байвал энэ нь хуурмаг энх тайван юм.



Уншиж судлах материал





Нөөц хэрэглэгдэхүүн 1.2. Энх тайвны эргэцүүлэл

Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхгүй бол энх тайван байж чадах уу?	Тийм	Үгүй
Хүмүүс бие биенээ сонсохгүй бол энх тайван байж чадах уу?		
Хүүхдүүдийн гэрээс сургууль явдаг зам харанхуй, бартаа ихтэй байвал хүүхдүүд энх тайван байж чадах уу?		
Хүмүүс архи уугаад байвал энх тайван байж чадах уу?		
Хүүхдүүд нэг нэгнээ дээрэлхээд байвал энх тайван байж чадах уу?		
Хүн бүр амиа хичээвэл энх тайван тогтох уу?		
Хүн бүр бие биенээ сонсдог бол энх тайван тогтох уу?		
Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг бол энх тайван тогтох уу?		
Зөвхөн миний аав ээж, гэр бүлийнхэн л сайн сайхан амьдарч байвал энх тайван мөн үү?		
Зөвхөн эх орон минь дайн дажингүй байвал бусад улс орны хямрал бидэнд хамаагүй гэж бодвол энх тайван мөн үү?		
Эх дэлхийгээ хайрлах нь энх тайвны нэг хэсэг мөн үү?		
Ан амьтныг хайрлах нь энх тайвны нэг хэсэг мөн үү?		
Нэг хүний амар амгалан байдал энх тайванд хувь нэмэр оруулах уу?		
Ахмад үеэ хүндлэхгүй бол энх тайван тогтох уу?		
Хүүхдүүдийг хайрлахгүй бол энх тайван тогтох уу?		
Айдас түгшүүртэй хүн энх тайван байж чадах уу?		



Бие даан ажиллах дасгал даалгавар



Үйл ажиллагаа 3. Энх тайвны хамрах хүрээг тодорхойлох

Багш хүүхдүүдэд нөөц хэрэглэгдэхүүн 1.3-д өгөгдсөн дасгал ажлын хуудсыг тараан өгч тус тусад нь ажиллуулна. Хүүхдүүд дасгал ажлын хуудсыг ажилласнаар энх тайвантай холбоотой өгүүлэмжүүдийг хувь хүн, нийгэм, байгаль орчин гэсэн гурван түвшний алинд хамаарахыг тодорхойлох юм. Бүх хүүхдүүд дасгалыг ажиллаж дууссаны дараа багш дараах гурван багана бүхий хүснэгтийг дэлгэц цаас, эсвэл самбарт зурж, өгүүлэмж бүр аль баганад хамаарахыг хүүхдүүдээс асууж тохирох баганад бичнэ.

Нийгэм	Хувь хүн	Байгаль орчин
- Дайн мөргөлдөөнгүй байх - Өөр өөр арьсны өнгө, соёл, шашин шүтлэг, үзэл бодолтой хүмүүс бие биендээ дасан зохицож эв нэгдэлтэй амьдрах - Бусдын санал нийлэхгүй байгааг хүндэтгэн үзэх - Өөрийн санаа бодол, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх - Цэрэг армиас илүү боловсрол эрүүл мэндэд хөрөнгө зарцуулах, оруулах - Хүмүүс нь ялгаатай олон төрөл хэдий ч хуулийн өмнө бүх хүн эрх тэгш байдаг нийгэмд амьдрах - Бусад хүмүүсийн хийсэн буруу үг, үйлдлийг уучлах	- Оюун санаа, сэтгэл зүйн амар амгалан байдал - Хүнийг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх - Стрессээс ангижрах, түгшүүргүй байх	- Байгаль эх дэлхийдээ зохицож амьдрах - Гэр орон, гудамж талбайн цэвэр - цэмцгэр, тохилог байдалд хувь нэмэр оруулах
- Ядарч зүдэрсэн хүмүүст сайн дураараа үйлчлэх, туслах - Дэлхий даяар ардчиллыг түгээн дэлгэрүүлэх - Цөмийн зэвсэгийн аюул заналгүй амьдрах - Айл хөршүүдтэйгээ нээлттэй, эелдэг сайн харилцаатай байх - Шударга ёс хэрэгждэг нийгэмд амьдрах	- Гүн бясалгал хийсний дараах мэдрэмж, амар амгалан байдал - Айдас, түгшүүргүй байх	- Өөрийгөө, бусдыг, ан амьтныг, байгаль дэлхийг хайрлах



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Өгүүлэмжүүдийг хүснэгтийн тохирох баганад байрлуулж дууссаны дараа хүүхдүүдээс асуулт, эсвэл санал байгаа эсэхийг асууж энх тайван нь хувь хүнээс гадна нийгэм, байгаль орчныг хамардаг тухай нэгтгэн дүгнэнэ.

Энх тайван нь хувь хүний дотоод амар амгалангаас гадна хүмүүс хоорондын, нийгэм, олон нийтийн, олон улсын, цаашлаад даян дэлхийн энх тайвныг хамрах өргөн хүрээний ойлголт юм.

- Дотоод энх тайванд хувь хүний өөрийнхөөрөө байх, дотоод зөрчилгүй, баяр хөөртэй, эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн сэтгэл зүйн амар амгалан байдлыг ойлгоно.
- Хүмүүс хоорондын энх тайванд хүмүүсийн харилцан ойлголцол, хүндэтгэлд суурилсан, бие биеийнхээ ялгаатай байдал, онцлогийг хүлээн зөвшөөрсөн, харилцаа, хамтын ажиллагааны хэлбэрийг ойлгоно.
- Нийгмийн энх тайванд улс орны ардчилал, хүний эрх, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн, хууль ёсыг чанд сахисан нийгмийн амар амгалан байдлыг ойлгоно.
- Олон улсын энх тайванд улс орнууд бусад улс орны хил хязгаар, эрх ашигт хүндэтгэлтэй хандаж, шударга ёсыг сахин бүс нутаг, олон улсын хэмжээнд эв найрамдалтай, дипломат ёсны хэм хэмжээг сахин харилцаж хамтран ажиллахыг ойлгоно.
- Даян дэлхийн энх тайванд хүн төрөлхтний хүрээлэн буй орчин, ан амьтан, ургамал, байгаль дэлхийтэйгээ зохицон тогтвортой амьдарч, аж төрөх арга хэлбэрийг багтаан ойлгоно.



Нөөц хэрэглэгдэхүүн 1.3. Энх тайвны хамрах хүрээ

Дараах хүснэгтийн арын баганад энх тайвантай холбоотой өгүүлэмжүүдийг бичсэн. Эдгээр өгүүлэмж нь энх тайвны хувь хүн, нийгэм ба байгаль орчин гэсэн ч түвшний алинд хамаарахыг өгүүлэмж бүрийн эхний баганад бичнэ үү.

ЭНХ ТАЙВАН ГЭДЭГ НЬ ...

	1. Дайн мөргөлдөөнгүй байх
	2. Оюун санаа, сэтгэл зүйн амар амгалан байдал
	3. Өөр өөр арьсны өнгө, соёл, шашин шүтлэг, үзэл бодолтой хүмүүс бие биендээ дасан зохицож эв нэгдэлтэй амьдрах
	4. Хүнийг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх

	5. Стрессээс ангижрах, түгшүүргүй байх
	6. Бусдын санал нийлэхгүй байгааг хүндэтгэн үзэх
	7. Өөрийн санаа бодол, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх
	8. Цэрэг армиас илүү боловсрол эрүүл мэндэд хөрөнгө зарцуулах, оруулах
	9. Гэр орон, гудамж талбайн цэвэр цэмцгэр, тохилог байдалд хувь нэмэр оруулах
	10. Айдас, түгшүүргүй байх
	11. Хүмүүс нь ялгаатай олон төрөл хэдий ч хуулийн өмнө бүх хүн эрх тэгш байдаг нийгэмд амьдрах
	12. Бусад хүний хийсэн буруу үг, үйлдлийг уучлах
	13. Ядарч зүдэрсэн хүмүүст сайн дураараа үйлчлэх, туслах
	14. Дэлхий даяар ардчиллыг түгээн дэлгэрүүлэх
	15. Байгаль эх дэлхийдээ зохицож амьдрах
	16. Цөмийн зэвсэгийн аюул заналгүй амьдрах
	17. Айл хөршүүдтэйгээ нээлттэй, эелдэг сайн харилцаатай байх
	18. Шударга ёс хэрэгждэг нийгэмд амьдрах
	19. Өөрийгөө, бусдыг, ан амьтныг, байгаль дэлхийг хайрлах
	20. Гүн бясалгал хийсний дараах мэдрэмж, амар амгалан байдал
Зөв хариулт	
1.Нийгэм 2.Хувь хүн 3.Нийгэм 4.Хувь хүн 5.Хувь хүн 6.Нийгэм 7.Хувь хүн 8.Нийгэм 9.Байгаль орчин 10.Хувь хүн/нийгэм	11.Нийгэм 12.Нийгэм 13.Нийгэм 14.Нийгэм 15.Байгаль орчин 16.Хувь хүн/нийгэм/байгаль орчин 17.Нийгэм 18.Нийгэм 19.Хувь хүн/нийгэм/байгаль орчин 20.Хувь хүн



Үйл ажиллагаа 4. Дайн тулааны аюул заналхийллийг хэлэлцэх

Багшийн зүгээс хүүхдүүдэд хандан нэгэн охины түүхийг өгүүлэх талаар хэлнэ. Нөөц хэрэглэгдэхүүн 1.4-д өгөгдсөн охины түүхийг чангаар уншиж өгнө. Эсвэл ангийн ямар нэг хүүхдээр уншуулж болно. Түүхийг уншиж өгсний дараа хүүхдүүдийн дунд дараах асуултыг асуух замаар хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Хэлэлцүүлгийн асуултууд

- Цөмийн бөмбөг, түүний аюул заналын тухай сонсож байсан уу?
- Японы Хирошима, Нагасаки хотуудад цөмийн бөмбөг дэлбэлсэн түүхийн талаар сонсож байсан уу? Ямар аюул дагуулсан бэ?
- Садако Сасаки охинд юу тохиолдсон бэ? Садако Сасаки охины аав түүнд юу гэж хэлсэн бэ?
- Садако Сасаки охины чин хүсэл юу байсан бэ? Тэр хүслээ биелүүлж чадсан уу?
- Садако Сасаки охины түүх чамд ямар мэдрэмж төрүүлж байна вэ?
- Өнөөдөр дэлхий дахинд дайн тулаан өрнөж байна уу? Тухайлбал: Украин улсад болж буй дайны талаар та нар сонссон уу?
- Украинд болж буй дайн тулаанд хүүхдүүд, хүмүүс өртөж байгаа болов уу? Хүүхдүүд дайныг хүссэн үү?
- Дайн тулааныг хүсэх, дэмжих нь зөв зүйл мөн үү? Садако Сасаки охинд тохиолдсон зүйл бидэнд юуг сэрэмжлүүлж байна вэ?
- Хүүхдүүд бид томчуудад энх тайвныг уриалах хэрэгтэй юу?



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Хэлэлцүүлгийн явцад багш дараах мэдээллийг нэмж тайлбарлана.

- Энэ түүх маш гунигтай ч гэсэн дэлхийн маш олон хүмүүст дайнаас зайлсхийж энх тайвныг эрхэмлэхэд уриалснаараа бахархам түүх юм. Энэхүү өр өвтгөм явдал хүн төрөлхтөний чихэнд хүрч дэлхийн өнцөг булан бүрээс хүүхдүүд Садако Сасакигийн хийж амжаагүй цаасан шувууг гүйцээж мянга болгохын тулд Хирошима хот руу өөрсдийн хийсэн шувуугаа илгээсэн байдаг. Охиныг өнгөрсний дараа тус хотод орон орны хүүхдүүдийн илгээсэн зуун мянга гаруй цаасан тогоруу цугларсан гэдэг. Түүний гунигт хувь тавилан өнөөдөр ч гэсэн дайн байлдаантай байгаа бүс нутагт амьдарч буй хүүхдүүдэд тохиолдож буй хамгийн эмгэнэлтэй хэрэг юм.
- Хүүхдүүдийн энэ нэгдэл улс орнуудын тухайн үеийн удирдагчдад нөлөөлж цөмийн зэвсгийн асуудалд нарийн хандаж, дахиж ийм эмгэнэлтэй явдлыг давтаж болохгүйг сануулсан юм.



Нөөц хэрэглэгдэхүүн 1.4. Садако Сасаки охины түүх



1945 оны 8 сарын 6 -ны өдөр Японы Хирошима хотод атомын бөмбөг хаяхад Садако Сасаки охин 2 настай байлаа. Атомын бөмбөг дэлбэрэх үед тэрээр гэртээ байсан ба цонхыг хагалан орж ирэх хүчтэй дэлбэрэлтийн улмаас тэр арагшаагаа шидэгдэж түүний хувцас нь түлэгдсэн ч эсэн мэнд үлджээ.

Тэр цагаас хойш 11 нас хүртлээ Садако Сасаки бусад хүүхдийн адил хэвийн амьдарч байлаа. Гэвч нэг өдөр түүний бие тавгүйрхэн эмчид үзүүлэхэд эмч нар түүнийг цусны хорт хавдартай болсныг дуулгасан байна. 2 настай байхад нь болсон аймшигт дэлбэрэлтийн дараах цацраг идэвх бодисын хордлогод

өртсөн нь түүний цус хорт хавдартай болсон шалтгаан байжээ. Садако Сасаки охины аав ээж маш их гуниглаж, охиноо алдана гэхээс айж байлаа. Тэд охиндоо чэрри жимсний зурагтай кимоно авч өгөн охиныхоо сэтгэл санааг өргөхийг хичээж байлаа. Гэвч Садако Сасакигийн бие өдрөөс өдөрт муудсаар байв. Охиндоо итгэл найдвар бэлэглэхийг хүссэн аав нь түүнд япончуудын ярилцдаг мянган цаасан тогоруу хийвэл өвчин шаналал, гай түйтгэрээс ангижирдаг тухай домгийг ярьж өгөв. Садако Сасаки охин домогт итгэж энэ мөчөөс эхлэн уусан эмийнхээ цаасаар тогоруу хийж эхэлжээ. Харамсалтай нь охины бие өдөр ирэх бүр муудсаар өөд болж, мянган шувуугаа хийж амжаагүй юм. Түүний орны дэргэд байсан цаасан хайрцагт 644 цагаан тогоруу байлаа.

Үйл ажиллагаа 5. Энх тайвны баатрууд, тэдний уриатай танилцах

Багш нөөц хэрэглэгдэхүүн 1.5-д өгөгдсөн энх тайвны тухай алдартнуудын эшлэлийг дэлгэцээр үзүүлж, өөрт хамгийн таалагдсан 3 эшлэлийг сонгож, хажууд сууж буй хүүхэдтэйгээ яагаад тухайн эшлэл таалагдсан тухай харилцан ярилцаж санал бодлоо солилцохыг хүснэ.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Үүний дараа дараах асуултыг асууж хичээлийн хүрээнд үзсэн ойлголтыг нэгтгэн дүгнэнэ.

Хэлэлцүүлгийн асуултууд

1. Энх тайвны талаар өмнө нь мэдэхгүй зүйлээ мэдэж авсан уу? Тийм бол ямар зүйлийн тухай мэдэж авсан бэ?
2. Энх тайвныг бий болгоход хүүхдүүд бид нар юу хийж чадах вэ? Юу хийх хэрэгтэй гэж бодсон бэ?
3. Дайн тулаан, мөргөлдөөн ба энх тайвны аль нь чухал вэ? Бид яагаад энх тайвныг дэмжих ёстой вэ?

Хүүхдүүдийн хариултад үндэслэн дараах агуулгыг нэгтгэн дүгнэхэд анхаарна.

- Энх тайван нь заримдаа хуурмаг хэлбэртэй байдаг. Хэдийгээр дайн тулаан, хүчирхийллийн шууд аюул занал байхгүй ч хүмүүс амар тайван амьдарч чадахгүй, түгшүүртэй байх нь хуурмаг энх тайван юм. Хүмүүс бид энх тайвныг цогцлоох учиртай.
- Энх тайван бий болгоход хүн бүрийн оролцоо хэрэгтэй. Хүүхдүүд ч бас эргэн тойрондоо энх тайвныг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Энх тайван нь хувь хүнд, гэр бүлд, орон нутагт, улс оронд, олон улсад, дэлхий дахинд хамаатай түгээмэл ойлголт юм.
- Гэр бүлийн энх тайван хувь хүнээс, орон нутгийн энх тайван гэр бүлээс, улс орны энх тайван орон нутгаас гэх мэт энх тайван нь бүх түвшинд уялдаатай.
- Энх тайванд хамгийн их аюул занал учруулдаг зүйл нь үл хүндлэл, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дайн тулаан юм. Хүмүүс бид хүчирхийлэл, дайн тулаанаас ямагт зайлсхийж энх тайвныг бий болгохын төлөө хичээх ёстой.
- Дайн тулаан, мөргөлдөөн бол энх тайванд хамгийн их аюул занал учруулдаг зүйл юм. Тиймд манай улсад тохиолдохгүй байгаа ч гэсэн өөр улс оронд болж буй дайн тулааныг зогсоохын төлөө дэлхийн бүх хүмүүс шаардах, тэмцэх ёстой.

Багш хичээлийг нэгтгэн дүгнэх үүднээс нөөц хэрэглэгдэхүүн 1.6-д өгөгдсөн үгийн сүлжээг хүүхэд бүрд тараан өгч 5 минутын хугацаанд бөглүүлнэ. Үгийн сүлжээнд 5 үг багтсан ба багш үг бүрийг нэг бүрчлэн асууж үгийн сүлжээг зөв бөглөсөн эсэхээ хамтдаа шалгана. Үүний дараа үгийн сүлжээнд дурдагдсан үг ойлголтуудын талаар товч хэлэлцүүлэг өрнүүлж хүүхдийн ойлголтыг бататгаж, нэгтгэн дүгнэнэ.




Бие даан ажиллах дасгал даалгавар





Нөөц хэрэглэгдэхүүн 1.5. Энх тайвны баатрууд, тэдний уриа



“ Энх тайван таны дотоод оршихуйгаа урган гарна. Дотроо амгалан оршихуй үгүйгээр энх тайвныг хайх хэрэггүй. ”

Будда

“ Хэрэв бидэнд энх тайван байхгүй байгаа бол энэ нь бид бие биедээ хамаардгийг мартснаас улбаатай. ”

Тереза эх




“ Дайныг биш энх тайвныг сонго. Энх тайванд хүрэхийн тулд зөвшилцлийг сонго. ”

Голда Мейер



“ Энх тайвныг хүчээр тогтоож чадахгүй. Гагцхүү харилцан ойлголцлын үр дүнд л түүнд хүрэх боломжтой. ”

Алберт Эйнштейн



“ Дэлхий нийтийн энх тайван дотоод энх тайвнаас эхлэх учиртай. Энх тайван гэдэг нь зөвхөн дайн дажингүй байх биш хүний сайхан сэтгэл цэцэглэн хөгжих явдал юм. Дотоод энх тайвангүйгээр дэлхийн энх тайван байх боломжгүй юм. ”

Далай лам



“ Хүн төрөлхтөн бид зөрчлийг уур бухимдал, түрэмгийлэл, өшөө хорслоор биш хайр энэрэл, харилцан ойлголцлоор шийдэх ёстой. ”

Мартин Лютер Кинг




“ Хэрвээ та бүхэн дайн байлдааныг зогсоохыг хүсч байвал буу зэвсэг өгөхийн оронд ном өг, танк илгээхийн оронд үзэг бал илгээ, цэрэг илгээхийн оронд багш нарыг илгээ. ”

Малала охин




“ Хором мөч бүр дэлхий дээр энх тайвныг тогтоох, аз жаргалыг хүн бүрт хүртээх боломж юм. ”

Тич Нх Хан





Нөөц хэрэглэгдэхүүн 1.6. Үгийн сүлжээ




Босоогоор

1. Хүнд төрдөг дотоод сэтгэл хөдлөл
2. Энх тайвныг төлөөлүүлдэг амьтан, жигүүртэн
3. Хүн төрөлхтөн, ан амьтан, ургамал ногоо амьдрах орчин
4. Үл хүчирхийллийн үзэл санааны төлөөлөгч
5. Охидын боловсролын төлөө тэмцэгч, энх тайвны шагналтан Пакистан охин

Хөндлөнгөөр

1. Хүний харьяалагдах бүлэг, нийгмийн анхдагч нэгж
2. Хүчирхийлэл, аюул занал, нийгмийн доройтол, ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, ядуурал, шударга бус байдал зэргээс ангид байх нөхцөл байдал



Бие даан ажиллах дасгал даалгавар



Хичээл 2. Зөрчлийг энх тайвнаар шийдвэрлэх нь



ЗОРИЛГО:

Суралцагчдад зөрчил, түүний мөн чанар, гүнзгийрлийн тухай хэлэлцүүлэх замаар зөрчлийг шийдвэрлэх энх тайванч, үл хүчирхийлэл бүхий хожил шийдлийг эрхэмлэх, эвлэрэх хандлага төлөвшүүлэх



ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

- **Зөрчил:** Росс Стингер (1967)-ийн тодорхойлсноор зөрчил нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн үзэл бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм. Хүмүүс хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг.
- **Зөрчлийн шалтгаан:** Зөрчил нь нөөц боломжийн хомсдлоос гадна, зөрчилдөж буй талуудын хэрэгцээ хангагдаагүй байх, эсвэл талуудын ялгаатай байдлаас үүсэн бий болдог гэж үздэг.
- **Зөрчлийн гүнзгийрэл:** Хүмүүс хооронд үүссэн аливаа зөрчлийг шийдвэрлэхгүй бол улам гүнзгийрдэг. Хүмүүст зөрчлийг эхэн үед нь шийдвэрлэх ур чадвар дутагдснаас зөрчил нь улам бүр гүнзгийрч хүндэрдэг. Харин зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэснээр өөртөө итгэх итгэл нэмэгдэж, харилцаа холбоо сайжирч, өсөлт хөгжил бий болдог.
- **Зөрчлийн үед хүмүүсийн гаргадаг хариу үйлдэл:** Зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэргээр сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайвны арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сөргөлдөгч талууд бие биенийнхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох арга замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.

- **Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг арга барил:** Хүмүүс зөрчлийн үед тодорхой арга барилыг хэрэглэж хэвшсэн байдаг. Нэгэнт хэвшин тогтсон учир өөрсдийгөө тухайн арга барилыг хэрэглэдэг гэдгээ тэр бүр мэддэггүйгээс болж өөрийгөө зөвтгөх, бусдыг буруутгах хандлагатай байдаг байна. Иймд зөрчлийг шийдвэрлэхэд чухал нэг алхам нь хүмүүс өөрсдийн байнга хэрэглэдэг арга барилаа танин мэдэж, зөрчлийн үед тухайн арга барилыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэх талаар тунгаан бодох явдал юм. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг түгээмэл арга барилуудыг дараах таван амьтнаар төлөөлүүлэн тайлбарласан байдаг.
 1. Яст мэлхий: Зөрчлийн үед өөрийн байр суурийг илэрхийлж, бусдын байр суурийг сонсох замаар зөрчлийг шийдвэрлэх гэж хичээхээс илүү зөрчлийг үл хайхарч, зөрчилт байдалд орохоос зугатан зайлахыг эрмэлздэг. (Зайлсхийх арга барил)
 2. Баавгай: Зөрчлийн үед үүссэн асуудлыг шийдвэрлэхээс илүү харилцаагаа хадгалахыг эрмэлздэг. Зөрчилт нөхцөл байдлыг орхиж, аяндаа шийдэгдэхээр үлдээдэг. (Зохицох арга барил)
 3. Үнэг: Зөрчлийг аль болох зохицуулахыг эрмэлздэг. Зөрчил гэдэг нь харилцан хоёр тал байр сууриа өөрчлөх замаар буюу өгч, авах замаар шийдвэрлэх боломжтой зүйл гэж үздэг. (Зохицуулах арга барил)
 4. Шар шувуу: Дундын шийдлийг олохыг эрмэлздэг. Зөрчлийг шийдвэрлэхийн тулд цаг зав, хүчин чармайлт гаргадаг. Харилцаанд ач холбогдол өгөхийн хамт зөрчилтэй асуудлыг шийдвэрлэхийг хичээдэг.
 5. Аварга загас/Арслан: Зөрчилтэй шууд нүүр тулдаг. Өөрийн байр сууриа хүчтэй илэрхийлж, өөрийнхөө зүтгэж дайрах замаар зөрчлийн үед ялахыг эрмэлздэг. (Өрсөлдөх арга барил)
- Зөрчлийг шийдвэрлэх боломжит дөрвөн шийдэл байдаг. Зөрчилдөж буй хоёр талыг А ба Б тал гэж нэрлэвэл тэдний дунд үүссэн зөрчил нь дараах дөрвөн хувилбарын аль нэгээр шийдэгдэж болно.

	<u>А</u>	<u>Б</u>
1.	Хожил	Хожигдол
2.	Хожигдол	Хожил
3.	Хожигдол	Хожигдол
4.	Хожил	Хожил



ХИЧЭЭЛИЙН БЭЛТГЭЛ

Багш дараах хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэсэн байна.

- Самбар, эсвэл дэлгэц цаас, самбарын маркер эсвэл шохой
- Нөөц хэрэглэгдэхүүн – 16 ширхэг



ХИЧЭЭЛИЙН ЯВЦ

	Үйл ажиллагааны агуулга	Арга зүй	Нөөц хэрэглэгдэхүүн	Нэмэлт даалгавар
1.	Зөрчил түүний шалтгаан	- Дасгал ажиллах - Асуулт хариултын аргаар хэлэлцүүлэг хийх - Тайлбарлах, нэгтгэн дүгнэх	1.1. Зөрчлийн хэлбэрүүд	- Зөрчлийн мөн чанарын тухай найзтайгаа, ээж аавтайгаа ярилцах, санал солилцох - Зөрчлийн үед би ямар зарчим баримталдаг вэ сэдвээр зохион бичлэг бичих - Муудсан найзтайгаа эвлэрэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх
2.	Зөрчлийн үеийн арга барил (Таван амьтан)		2.1. Зөрчил ба амьтад 2.2. Зөрчил ба амьтдын арга барил 2.3. Зөрчлийн тухай өгүүлэмж	
3.	Зөрчлийн мөн чанар (Хэдэн дөрвөлжин байна вэ?)		3.1. Хэдэн дөрвөлжин байна вэ? 3.2. Дөрвөлжин тоолох аргууд 3.3. Зөрчлийн мөн чанарыг тайлбарлах дүрслэл	
4.	Зөрчлийн гүнзгийрэл (Урсдаг шат)		4.1. Зөрчлийн шат 4.2. Зөрчлийн гүнзгийрэл	
5.	Зөрчлийн шийдэл (2 морь дасгал)		5.1. Морины дүрс 5.2. Хоёр морь түүхийн дүрслэл	
6.	Эвлэрэх төлөвлөгөө		6.1. Муудалцсан хүүхэдтэй эвлэрэх нь хэр хэцүү болохыг үнэлэх дүрс 6.2. Уур бухимдлын хэмжилтийн шугам 6.3. Эвлэрэх аргын карт 6.4. Эвлэрэх аргыг хэмжих шугам 6.5. Надад таалагдсан арга	

Үйл ажиллагаа 1. Зөрчил ба түүний шалтгааныг тодруулах

Багш сурагчдаас “Зөрчил” гэж юу вэ гэсэн асуултыг асууна. Сурагчид зөрчил гэдэг нь маргаан, муудалцах, зөрчилдөх, зодоон, дайн тулаан зэрэг хариултыг хэлж болно. Сурагчдын хариултад үндэслэн зөрчлийн тухай тайлбарлана. Багш дараах тайлбарыг өгч болно.

Зөрчил гэдэг нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн үзэл бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм. Хүмүүс хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг. Нөхцөл байдал гэдэгт хоорондоо өрсөлдөгч хоёр баг ямар нэг зүйлээс болж зөрчилд орж болно. Эсвэл зөрчилдөж буй талуудын хандлага нь бие биедээ дайсагнасан байвал зөрчил хурцдаг болно. Зөрчилдөж буй талаад зан үйлийн хувьд дээрэлхэх, хүч хэрэглэх зэрэг зан үйл гаргавал мөн зөрчил хурцдаг.

Зөрчлийн тухай тайлбарлахдаа нөөц хэрэглэгдэхүүнд өгөгдсөн зургийг үзүүлж зөрчил нь хүүхэд хүүхдийн хооронд, хүүхэд, эцэг эхийн хооронд, эцэг эхийн хооронд зэрэг хувь хүмүүсийн дунд болохоос гадна бүлгүүдийн дунд, цаашлаад улс орны дунд өрнөж болно гэдгийг тайлбарлана.

Улмаар зөрчил юунаас үүсдэг вэ буюу Зөрчлийн шалтгаан юу вэ гэсэн асуултыг хүүхдүүдээс асууна. Хүүхдүүдээс гарч ирэх хариултыг самбарт бичиж болох энэ талаар дэлгэрүүлэн тайлбарлахдаа хүүхдүүдийн хариулттай уялдуулан тайлбарлана.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Багш зөрчлийн шалтгаан нь хязгаарлагдмал нөөц, хангагдаагүй хэрэгцээ, хүмүүс хоорондын ялгаатай байдалтай холбоотой үүсдэг тухай тайлбарлана.



Уншиж судлах материал



Нөөц хэрэглэгдэхүүн 2.1. Зөрчлийн хэлбэрүүд



Багш дараах зургийг үзүүлэн зөрчил нь ээж аав, хүүхдийн хооронд, хүүхэд, хүүхдийн хооронд, багш, хүүхдийн хооронд, гэх мэт нийгмийн амьдралын бүхий л хүрээнд ямар ч хүмүүсийн дунд тохиолдож болох нийгмийн үзэгдэл юм гэдгийг хэлнэ.




Үйл ажиллагаа 2. Зөрчлийн үеийн арга барилыг тайлбарлах

Багш нөөц хэрэглэгдэхүүн 2.2-д өгөгдсөн амьтдын дүрсийг хүүхэд бүрт нэг амьтан оногдохоор тарааж өгнө. Хүүхэд бүр үнэг, аварга загас, баавгай, яст мэлхий ба шар шувууны аль нэг нь болох ба багшийн зүгээс тухайн амьтны зан чанар, араншингийн тухай тайлбарлана.




Үүний дараа нөөц хэрэглэгдэхүүн 2.4-т өгөгдсөн зөрчлийн тухай гурван өгүүлэмжийг ангийн бүх хүүхдэд харагдахуйц газар байрлуулна. Хүүхдүүд өөрсдийгөө оногдсон амьтнаа гэж бодвол эдгээр гурван өгүүлэмжийн алинтай нь санал нийлэх тухай 1 минут орчим тунгаан бодоод хариулахыг хүснэ.

1.	 Зөрчил огт байх ёсгүй. Аль болох зөрчилдөхгүй байх хэрэгтэй.
2.	 Зөрчил байж болно. Гол нь зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэх ёстой.

3.	
----	---

Үүний дараа багш амьтдын нэрийг дуудан (жишээлбэл аварга загаснууд босоорой) гэж хэлээд аварга загас болсон хүүхдүүдээс аварга загас байсан бол зөрчлийн тухай гурван өгүүлэмжийн алинтай нь илүү санал нийлэх байсан тухай асууна. Хүүхдүүд 3-р хувилбарыг хэлэх магадлалтай. Ийм маягаар амьтад тус бүрээр гурван зөрчлийн өгүүлэмжтэй санал нийлж буй байдлаар нь ангилна.

Багш дараах байдлаар ангиллыг үүсгэж болно.

Үүний дараа зөрчлийн тухай амьтдын санал бодол, байр суурь ялгаатай байгаа шиг хүмүүс болон хүүхдүүд бид ч зөрчлийн тухай өөр өөр бодолтой байдаг болохыг нэгтгэн дүгнээд зөрчлийн тухай амьтдын байр суурь дээр үндэслээд зөрчлийг шийдвэрлэх таван хандлага байдаг тухай хэлнэ.

Зөрчлийг шийдвэрлэх таван тактик болох өрсөлдөх, зохицох, зохицуулах, зөвшилцөх ба зайлсхийх тактикийн алиныг эдгээр амьтад хэрэглэж буйг хэлэлцэж дараах хүснэгтэд тохируулан бичнэ.

Амьтад ба тэдний арга барил		Зөрчлийг шийдвэрлэх тактик
	Өөрийн санаа, үзэл бодол, байр суурийг бусдад тулгадаг. Бусдыг өөртэйгээ адил байхыг шаарддаг. Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо хамгаалахын төлөө тууштай байдаг. Өөрийн зөв гэдгийг бусдад ойлгуулах, итгүүлэхийг хичээдэг.	Өрсөлдөх
	Бүх асуудлыг ил тод ярилцах дуртай. Нээлттэй харилцахыг эрмэлздэг. Үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг.	Зөвшилцөх
	Шийдэл хайж олохыг эрмэлздэг. Шударга байдал бол хамгийн чухал зүйл юм. Буулт хийх ба хуваалцах нь гол түлхүүр гэж үздэг. Аль аль талыг харгалзан үзэх ёстой.	Зохицуулах
	Хүмүүсийг байлдан дагуулдаг. Эелдэг, найрсаг байснаар хүмүүст нөлөөлнө гэж үздэг. Харилцаагаа эхэлж сайжруул. Шийдэл аяндаа олдоно гэдэг дүрэмтэй.	Зохицох
	Халз тулсан нөхцөл байдлаас зайлсхийдэг. Маргалдаж мэтгэлцэх дургүй бөгөөд цаг барсан дэмий зүйл гэж үздэг. Бусдыг хүссэн зүйлээ авахыг зөвшөөрөх хандлагатай.	Зайлсхийх

Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Дасгалын дараа багш дараах асуултыг асуух замаар хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ.

- Зөрчлийн үед хүмүүс бүгд нэгэн ижил маягаар ханддаг уу?
- Зөрчлийн үед зарим хүмүүс зайлсхийх, зарим хүмүүс түрэмгий хандлагатай байдаг нь юутай холбоотой вэ?
- Зөрчлийн үед өөрийн хэрэглэдэг арга барилаа танин мэдэх хэрэгтэй юу? Зөрчлийн үед өөрийн хэрэглэдэг арга барилаа танин мэдэх нь ямар ач холбогдолтой вэ?

- Зөрчлийн үед өөрийнхөө буюу өөрийн байнга хэрэглэдэг арга барилдаа найдах нь хэр үр дүнтэй вэ?


Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн зөрчлийн үеийн арга барилын тухай дараах байдлаар нэгтгэн дүгнэнэ.

- Зөрчлийн үед хүмүүс өөрийн хувийн онцлог, зан чанараас үүдэн харилцан адилгүй хандлага, зан байдал гаргадаг ба үүнийг зөрчлийн үеийн тактик буюу арга барил гэж нэрлэх нь бий. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэж буй тактикийг бидний дасгалаар авч үзсэн 5 үндсэн ангилалд хуваан авч үздэг.
- Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг зарим тактик, жишээ нь өрсөлдөх, зайлсхийх зэрэг тактикууд төдий л үр дүнтэй биш бөгөөд заримдаа зөрчлийг хурцатгаж, эсвэл гүнзгийрүүлж байдаг. Харин зөвшилцөх, зохицох, зохицуулах зэрэг тактикууд нь аль болох зөрчлийг харилцан хэлэлцэж шийдвэрлэхийг зорьдог гэдэг утгаараа өмнөх хоёр тактикаа бодвол үр дүнтэй байдаг.
- Аливаа хүн зөрчлийн үед өөрийн хэрэглэдэг тактикаа мэддэг байх хэрэгтэй ба хэрвээ төдий л үр дүнтэй тактик хэрэглэдэггүй бол бусад тактикуудаас суралцах, эзэмшихийг хичээх хэрэгтэй юм.
- Зөрчлийн үед хүмүүсийн гаргадаг хариу үйлдлийг зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэргээр сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайвны арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сөргөлдөгч талууд бие биенийнхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох арга замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.



Нөөц хэрэглэгдэхүүн 2.2. Зөрчил ба амьтад





Нөөц хэрэглэгдэхүүн 2.3. Зөрчил ба амьтдын арга барил

Амьтад ба тэдний арга барил



- Өөрийн санаа, үзэл бодол, байр суурийг бусдад тулгадаг
- Бусдыг өөртэйгээ адил байхыг шаарддаг.
- Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо хамгаалдаг
- Өөрийн зөв гэдгийг бусдад ойлгуулах, итгүүлэхийг хичээдэг.



- Бүх асуудлыг ил тод ярилцах дуртай.
- Нээлттэй харилцахыг эрмэлздэг.
- Үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг.



- Шийдэл хайж олохыг эрмэлздэг.
- Шударга байдал бол хамгийн чухал зүйл юм.
- Буулт хийх ба хуваалцах нь гол түлхүүр гэж үздэг.
- Аль аль талыг харгалзан үзэх ёстой.






- Хүмүүсийг байлдан дагуулдаг.
- Эелдэг, найрсаг байснаар хүмүүст нөлөөлнө гэж үздэг.
- Харилцаагаа эхэлж сайжруул. Шийдэл аяндаа олдоно гэдэг дүрэмтэй.



- Халз тулсан нөхцөл байдлаас зайлсхийдэг.
- Маргалдаж мэтгэлцэх дургүй бөгөөд цаг барсан дэмий зүйл гэж үздэг.
- Бусдыг хүссэн зүйлээ авахыг зөвшөөрөх хандлагатай.



Нөөц хэрэглэгдэхүүн 2.4. Зөрчлийн тухай өгүүлэмж



Бие даан ажиллах дасгал даалгавар




Үйл ажиллагаа 3. Зөрчлийн мөн чанар (Хэдэн дөрвөлжин байна вэ?)


Нөөц хэрэглэгдэхүүн 2.5-д өгөгдсөн зургийг хүүхэд бүрт тараан өгч, зурагт хэдэн дөрвөлжин байгааг тоолж дөрвөлжингийн тоог гаргахыг хүснэ. Хүүхдүүд өгөгдсөн дүрсэн дээр дөрвөлжинг тоолохын тулд зурж, хүрээлж болно. Хүүхдүүдэд 5 минутын хугацаа өгч бие даан ажиллуулна.

Зургаас хэдэн дөрвөлжин харснаа бусдадаа хэлэхийг хүснэ. Хүүхдүүдийн тоолсон дөрвөлжингийн тоо хоорондоо зөрж болох ба тооны зөрүү яагаад гарсан тухай асууна. Дараах гурван хувилбараар дөрвөлжинг тоолсон байж болно.


1-р хувилбар: Энэ хувилбараар тоолоход 16 дөрвөлжин байна.



2-р хувилбар: Энэ хувилбараар тоолоход 4 дунд зэргийн дөрвөлжин эсвэл 16 жижиг дээр 4 том дөрвөлжин нийлээд 20 дөрвөлжин болж болно.



3-р хувилбар: 1 том дөрвөлжин эсвэл 16 жижиг дээр 4 дунд зэрэг нэмээд 1 том гээд нийт 21 дөрвөлжин тоолж болно.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Хэлэлцүүлгийн явцад дараах хариулт гарч ирэхэд чиглүүлнэ. Хэлэлцүүлэгт зориулж дараах зургуудыг дэлгэцэнд үзүүлж болно.

- Хүмүүс нэг зүйлийг өөр өөрөөр хардаг. Миний зөв, чиний буруу гэж хэлэх нь учир дутагдалтай. Зарим хүн асуудлыг маш жижиг хүрээнд хардаг бол зарим хүн өргөн хүрээнд хардаг.
- Харилцан бие биенийхээ ялгаатай бодлыг сонсож хэлэлцснээр шинэ ойлголт, санааг төрөх боломжтой.
- Хүмүүсийн ялгаатай үзэл бодол, байр суурь, хандлагаас болж зөрчил үүсдэг. Ялгаатай байдлаа ойлгосноор харилцан ойлголт бий болж дундын шийдвэрт хүрч чадна.
- Иймд хүмүүс аливаа асуудлаар өөр өөр үзэл бодол, байр суурьтай байдаг учраас нийгэмд зөрчил үүсэх нь зайлшгүй юм. Харин зөрчил огт байж болохгүй гэж үзэх нь түүний мөн чанарыг үгүйсгэж байгаа тул учир дутагдалтай. Зөрчил зайлшгүй гэж үзэх нь зөрчлийг шийдвэрлэж болохгүй эсвэл зөнд нь орхи гэсэн үг бас биш юм.




Уншиж судлах материал







Нөөц хэрэглэгдэхүүн 2.5 . Хэдэн дөрвөлжин байна вэ?
дасгалын хуудас



Нөөц хэрэглэгдэхүүн 2.6. Дөрвөлжин тоолох ялгаатай арга



Нөөц хэрэглэгдэхүүн 2.7. Зөрчлийн мөн буюу зөрчил зайлшгүй зүйл болох тухай тайлбарлах зурагт хуудас



Үйл ажиллагаа 4. Зөрчлийн гүнзгийрэл буюу урсдаг шат дүрд тоглох

Багш зөрчлийн гүнзгийрлийг дараах байдлаар тайлбарлана.

Хүмүүс хоорондоо зөрчилдөж байгаа гэдгээ сайн мэддэг ч зөрчил хэрхэн гүнзгийрч, улам хурцдаж байгааг төдийлөн анзаардаггүй. Нэг л мэдэхэд хүмүүс хоорондын зөрчил гүнзгийрсээр бие биенийгээ хохироох хэмжээнд хүрдэг. Энэ утгаар нь зөрчлийн гүнзгийрлийг урсдаг цахилгаан шаттай зүйрлэж болох юм.

Урсдаг шатны аль нэг гишгүүр дээр зогсож байхад аяндаа хүнийг дээш нь эсвэл доош нь зөөдөг шиг зөрчил нь нэг мэдэхэд хурцадсан байдаг. Хүмүүс зөрчилдөөнд орж, маргалдах үедээ бие биедээ хэлсэн буруу үг хэллэг нь хүнд хэцүү мэдрэмж төрүүлж зөрчлийг гүнзгийрүүлдэг. Гүнзгийрч буй зөрчлийг зогсооход маш хэцүү байдаг.

Багш 2 хүүхдийг сайн дураараа гарч ирэхийг хүснэ. Гарч ирсэн 2 хүүхдэд Нөөц хэрэглэгдэхүүн 2.9-д өгөгдсөн зөрчлийн шатны картуудыг өнгөөр ялгаж өгнө. Хоёр хүүхэд өөрт оногдсон картан дээрх өгүүлбэрийг харилцан бие биедээ хэлж дүрд тоглоно.

Дүрд тоглохын өмнө дараах нөхцлийг уншиж өгнө.

“Болд ба Батаа хоёр ширээний найзууд. Тэд нэг ширээнд хамт суугаад удаж байна. Болд нэг удаа ширээн дээрээ суугаад зургийн хичээлийн даалгавраа хийж байв. Энэ үед Батаа хүрч ирэн ширээн дээр суухдаа ширээг хөдөлгөхийн хамт цамцны халааснаас бал нь унахдаа Болдын зурж байсан зургийг баллаж орхив.”

Хоёр хүүхдийг картан дээрх үгнүүдийг харилцан бие биедээ хэлж дүрд тоглож байх явцад багш нөөц хэрэглэгдэхүүн 2.8-ийн шатанд тайлбарыг байрлуулна.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Дүрд тоглож дууссаны дараа дараах асуултыг асууж нийт хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ.


- Болд Батаа хоёрын зөрчил хэр хурцадсан бэ? Хүүхдүүдийн дунд, хүмүүсийн дунд иймэрхүү зөрчилд орох явдал тохиолддог уу?
- Зөрчил хурцдахад юу нөлөөлсөн бэ?
- Зөрчил хурцадсанаар Болд Батаа хоёрын цаашдын харилцаа ямар болох вэ?
- Хүмүүс зөрчлийг хурцатгахгүйн тулд юу хийх ёстой вэ?

Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн дараах агуулгыг нэгтгэн дүгнэнэ.

- Хүмүүс хоорондын зөрчил үүсэх нь зайлшгүй шинж чанартай хэдий ч зөрчлийг гүнзгийрүүлэхгүйгээр шийдвэрлэх нь чухал юм. Гэтэл хүмүүсийн дунд зөрчлийг гүнзгийрүүлж хурцадмал байдалд хүргэх тохиолдол их байдаг.
- Зөрчлийн гүнзгийрэлд зөрчилдөж буй талуудын зүгээс илэрхийлж буй зохисгүй үг хэллэг, үйлдэл сөргөөр нөлөөлдөг. Зөрчилдөж буй хүмүүс хэтрүүлэх, өмнө болж байсан зүйлийг сөхөх, өөрийгөө өмөөрөх, заналхийлэх, хувь хүн рүү дайрах, сөрөг дүгнэлт хийх зэрэг буруу арга зам хэрэглэх нь зөрчлийг гүнзгийрүүлдэг.
- Иймд зөрчлийн үед гүнзгийрэхэд хүргэдэг буруу арга замаас сэргийлэх ёстой.



Нөөц хэрэглэгдэхүүн 2.8. Зөрчлийн шат





Нөөц хэрэглэгдэхүүн 2.9. Зөрчил гүнзгийрэхэд нөлөөлдөг хүмүүс хоорондын харилцааны зарим жишээ

<i>Хэн нэг нь сэтгэл дундуур байгаагаас үүдсэн санал зөрөлдөөн</i> “Чи юу хийснээ хар даа” “Би ингээгүй шүү дээ”	<i>Хэтрүүлэх</i> “Чи дандаа анхаарал болгоомжгүй байх юм аа” “Чи/Та намайг байнга л буруутгадаг”
<i>Өмнө нь болж байсан зүйлийг сөхөх</i> “Чи урьд нь бас миний ажлыг баллаж байсан” “Өнгөрсөн 7 хоногт чи ямар ч шалтгаангүй бас ингээд байсан биз дээ”	<i>Өөрийгөө яагаад ийм зүйл хийж байгаа учир шалтгаанаа тайлбарлах</i> “Миний ажил чинийхээс чухал учраас чи атаархаж байна” “Чи өөрийгөө бүхнээс дээгүүр/мундаг гэж боддог.”
Заналхийлэх “Хэрвээ чи дахиад ингэвэл би чиний юмыг сүйтгэх болно.” “Би чамаас илүү дээр найзтай болох хэрэгтэй юм байна.”	Хувь хүн рүү дайрах “Чи бол ухаан муутай амьтан ш дээ” “Чи бол амиа бодсон амьтан ш дээ”
Бусад хүмүүсийн хэлсэн/хийсэн зүйлийг хэлэх “Хүмүүс чамайг ухаан муутай гээд байдаг. Үнэн юм байна.” “Хүмүүс даанч чамайг ийм ааштай гээд байсан юм аа”	Сөрөг дүгнэлт хийх “Би чамайг үзэн ядаж байна.” “Би цаашид чамтай найзлахаа болилоо”



Бие даан ажиллах дасгал даалгавар



Үйл ажиллагаа 5. Зөрчлийн шийдэл: Хоёр морь дасгал ажиллах

Багшийн зүгээс 2 хүүхдийг сайн дураар гарч ирэхийг хүснэ. Гарч ирсэн хоёр хүүхдэд тус бүр морины дүрс өгч, тэднийг морины дүрд тоглоно гэдгийг хэлнэ. Улмаар оролцогч тус бүрд олсны нэг үзүүрийг бариулан дасгал ажлын явцад үзүүрийг алдахгүй гартаа барьж байх ёстойг хэлнэ. Хоёр оролцогчийг олсны үзүүрээ барин бие биенээсээ олсны хэмжээтэй хол зогсоогоод тэдний хажууд цаасан хайрцгийг байрлуулна. Хоёр оролцогчийг уншиж өгөх түүхийг сонсох явцдаа түүхэнд дүрслэгдэж буй үйл явцыг дүрслэн үзүүлж жүжиглэхийг хүснэ.

Багш дараах түүхийг уншиж өгнө.

Эрт урьдын цагт 2 морь байжээ. Тэднийг нэг удаа саравчинд хооронд нь уяатай байлгаж байлаа. Тэд маш их өлссөн байв. Нэг удаа малчин тэдэнд зориулан саравчинд хоёр хэсэг газар өвс тавьж өгөв. Эхний хэсэг өвсийг нэг моринд нөгөө хэсэг өвсийг хоёр дахь моринд ойрхон газар тавьжээ. Хоёр морь хоёулаа өөр өөрсдөд нь тавьж өгсөн өвсийг идэх гэсэн боловч хоорондоо уяатай тул өөр өөрсдийн өвсөнд хүрч чадсангүй гэнэ. Хоёр тийшээ тэмүүлсээр хамаг чадлаа барж, нүдэнд нь харагдаж буй өвсөндөө хүрч чадахгүй болохоор бүр их өлсөж, уур нь хүрцгээж гэнэ. Ингээд хоёр морь хоёулаа өлсөж, тэдэнд тус бүрд нь идэх өвс байсан ч өвсөндөө хүрч чадахгүй байдалд орлоо.

Багш хүүхдүүдээс хоёр морь ийм нөхцөлд юу хийж болохыг асууна. Эхлээд нэг өвсөө дараа нь нөгөө өвсөө идэх хэрэгтэй гэсэн санаа гарч ирэхийг хүлээнэ.

Хүүхдүүдийн хариултад үндэслэн хоёр морь өвсөө хамтарч идэх шийдэлд хүрсэн тухай хэлнэ.

Түүхийн үргэлжлэл: Тэд хамтдаа эхлээд нэг талын өвсөө идэв. Тэднийг хооронд нь холбосон уяа идэхэд нь огт саад болсонгүй. Эхний өвсөө идэж дууссаны дараа нөгөө талын өвсийг эв найрамдалтайгаар идэв. Хоёр морины өлсгөлөн гэдэс цадаж аз жаргалтай болов гэнэ. Хоёр морь ийнхүү харилцан ашигтай “хожил-хожил” шийдэлд хүрчээ.



Багшийн чиглүүлэг, дүгнэлт

“Хожил -хожил” шийдэл хоёр морийг гэдэс цатгалан болгож зөрчил гүнзгийрэхээс сэргийлсэн. Гэхдээ энэ түүх өөрөөр төгсөж болох байлаа. Хоёр морь хоёулаа эсвэл аль нэг нь гэдэс цатгалан биш аз жаргалгүй үлдэж болох

төгсгөл байж болох уу? гэж оролцогчдоос асуун саналыг сонсоно. Хүүхдүүдээс дараах хариулт гарч ирж болно.

- Хоёр морь хоолныхоо төлөө тулалдаж, хоёулаа хоолгүй хоцрох “хожигдол-хожигдол”
- Аль хүчтэй нэг морь нь өвсөндөө хүрч нөгөө морио идүүлэхгүй байх “хожил-хожигдол”
- Тэд хоёул өөрсдийн өвсөнд хүрэх гэж 2 тийшээ тэмүүлсээр хоёулаа ядарч аль нь ч өвсөндөө хүрч чадахгүй үлдэх “хожигдол-хожигдол”

Хоёр морь хоёулаа өвсөө идэж гэдэс цатгалан, аз жаргалтай байхад хүргэсэн гол нөхцөл юу байсан бэ? гэж хүүхдүүдээс асууна. Хүүхдүүд хожил хожил шийдэл байсан гэсэн санаа гарах хүртэл хэлэлцүүлгийг өрнүүлнэ.

Зөрчил, үл ойлголцол бол хүний амьдралын нэг хэсэг бөгөөд бүх цаг үед тохиолдох болно гэдгийг тайлбарлана. Хамгийн чухал нь зөрчил маргааныг хэрхэн зохицуулахад оршдог. Энэ түүхэнд гарсан хоёр морь шиг өөр өөрсдийнхөө зөрүүдлэн зүтгэвэл зөрчилдөж маргалдаж буй хоёр тал хоёулаа хохирдог. Үүний оронд тэд хоорондоо ярилцаж харилцан ашигтай тэр шийдлийг хайж олох ёстой.

Зөрчилд маргаанд орсон хүмүүс ихэвчлэн нөгөө тал нь хожиж, өөрөө хожигдож үлдэх вий гэсэн айдастай байдаг. Тийм учир зөвхөн хожихийг эрмэлзэж өөрийн шийдвэрт бат хатуу зогсож нөгөө талынхаа байр суурийг огтхон ч анхаарч үздэггүй. Энэ нь бидний түүхийн эзэн хоёр морь өөр өөрсдийн өвсөнд хүрэх гэж хоёр тийшээ маш хүчтэй тэмүүлж байснаас харагдана. Гэхдээ зөрчил маргаанд өөрийнхөө зүтгэсээр ялан дийлж болох ч энэ нь нөгөө талаа хохироосноороо эргээд ялагч талд ч гэсэн сэтгэл өвтгөх мэдрэмж төрүүлдэг. Улмаар дахин хэзээ ч нийлэхгүй дайсан болж болцгооно.


Иймд өөр өөрсдийн чиглэлд улайран зүтгэхээс илүү зогсож нөхцөл байдлаа тунгаан бодож, хамтран ажиллах арга замыг хайж бие биенээ сонсож дундын шийдэлд хүрэх хэрэгтэй.

Оролцогчдоос хоёр морь хожил хожил шийдэлд хүрэхийн тулд юу хийсэн бэ? гэж асууна. Дараах хариулт гарч ирэхийг анхааралтай сонсож самбарт тэмдэглэнэ. Үүнд: маргахаа зогсоох, эргэцүүлэн бодож эхлэх, хамтран ажиллах, нэг нь нөгөөгөө сонсох, бие биенийхээ хэрэгцээг ойлгох ...

- Сөрөг сэтгэл хөдлөлөө хянах
- Идэвхтэй сонсох
- Тодорхой ярих
- Бусдын хэрэгцээ, асуудал, бэрхшээл, хариу үйлдлийг ойлгохыг хичээх
- Бэрхшээлтэй шууд тулах
- Хувь хүн рүү дайрахгүй байх
- Асуудал шийдвэрлэх арга барилаар ажиллах
- Ойлгож байгаагаа илэрхийлэх
- Бодит баримт нотолгоо, үндэслэлтэй үед байр сууриа өөрчлөхөд бэлэн байх
- Та болон харилцаж буй нөгөө талд аль алинд нийцсэн өөр хувилбар гаргах
- Тууштай байх



Нөөц хэрэглэгдэхүүн 2.10. Морины дүрс



Нөөц хэрэглэгдэхүүн 2.11. Хоёр морины үлгэр



Зураг 1. Хоёр морь дасгалын постер зураг



Үйл ажиллагаа 6. Эвлэрэх төлөвлөгөө: Муудалцсан бол эвлэрье

Багш дараах асуултыг хүүхдүүдийн дунд асууж богино хугацаанд хэлэлцүүлэг өрнүүлнэ.

- Та нар ойрд хэн нэгэнтэй муудалцсан уу? Хүүхдүүдийн дунд хоорондоо маргалдах муудалцах үе байдаг уу?
- Түүнтэй эвлэрсэн үү? Хүүхдүүд муудалцсныхаа дараа эвлэрдэг үү?
- Хэрвээ эвлэрээгүй бол эвлэрэх талаар бодож үзсэн үү?

Багш хүүхдүүдэд дараах дугуй дүрсийг (нөөц хэрэглэгдэхүүн 2.12) тараан өгч, дугуй дүрсний гадуурх тасархай зураас бүхий хэсгийг будахдаа муудалцсан талаар бодож түүнтэй эвлэрэх нь маш хэцүү бол УЛААН, ер нь л хэцүү ч гэсэн эвлэрэх хэрэгтэй гэж үзэж байвал УЛБАР ШАР, харин заавал эвлэрэх хэрэгтэй гэж үзэж байвал НОГООН өнгөөр будахыг хүснэ. Хүүхдүүд дугуй дүрсийг будсаны дараа хэмжилтийн шугам (нөөц хэрэглэгдэхүүн 2.13)-д дугуй дүрсээ тохирох байрлалд байрлуулж наахыг хүснэ.

Багш хүүхдүүдэд хандан дээрх хэмжилтийн шугам дээр өнгөөр будсан дүрсээ нааснаар өөрсдийн уур бухимдлаа үнэлж байгаа хэрэг гэдгийг хэлж дараах асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ.

- Хоорондоо муудалцсан бол муудалцсан хэвээрээ л байх ёстой юу? Энэ нь зөв үү буруу юу?
- Муудалцсан хэвээрээ байгаад байвал ямар сөрөг үр дагавартай вэ?
- Муудалцсан хүүхдүүд хоорондоо эвлэрдэг үү? Хүүхдүүд муудалцсны дараа хэрхэн, яаж эвлэрдэг вэ? гэх мэт

Багш дээрх хэлэлцүүлэгт үндэслэн хүүхдүүд хоорондоо муудалцаж маргалдсны дараа эвлэрэх нь зүйтэй болохыг хэлээд муудалцсан хоёр хүүхдийн хэн нэг нь энийг санаачлах хэрэгтэй байдаг талаар ойлгуулан эвлэрэх төлөвлөгөө боловсруулах чиглэл өгнө. Хүүхэд бүрд 5 хүртэл эвлэрэх карт (нөөц хэрэглэгдэхүүн 2.14) тараан өгч карт тус бүрд маргалдсан хүүхэдтэй эвлэрэхийн тулд хийж болох нэг нэг аргыг тус тусад нь бичихийг хүснэ. Хүүхдүүд карт тус бүр дээр аргаа бичсэний дараа картуудаа эвлэрэх аргыг хэмжих шугам (Нөөц хэрэглэгдэхүүн 2.15)-ын тохирох зайнд байрлуулахыг хүснэ.

- Төлөвлөгөөнд бичсэн аргуудыг бичсэн цаасаа хайчлан дараах хэмжилтийн шугамын аль хэсэг тохирохыг тунгаан бодож байрлуулна уу?

Хүүхдүүдээс өөрийн бичсэн эвлэрэх аргуудаа хэлж, шугамын аль хэсэгт байрлуулснаа ангийнхандаа тайлбарлахыг хүснэ. Хүүхдүүд эвлэрэх аргаа ээлжлэн танилцуулж байх хооронд хамгийн таалагдсан аргыг (нөөц хэрэглэгдэхүүн 2.16) тэмдэглэж авахыг сануулна.




Багшийн чиглүүлэг, дүгнэлт

Бүх хүүхэд эвлэрэх аргаа танилцуулж дууссаны дараа хүүхдүүдийг муудалцсан хүүхэдтэйгээ эвлэрэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд ямар аргыг хэрэглэх гэж байгаа талаар асууж зарим хүүхдүүдийн саналыг сонсоно.


Гэрийн даалгаварт муудалцсан хүүхэдтэйгээ эвлэрэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх даалгавар өгнө.



Нөөц хэрэглэгдэхүүн 2.12. Муудалцсан хүүхэдтэйгээ эвлэрэх нь хэр хэцүү болохыг үнэлэх дугуй дүрс



Нөөц хэрэглэгдэхүүн 2.13 Уур бухимдлын хэмжилтийн шугам






Нөөц хэрэглэгдэхүүн 2.14. Эвлэрэх арга карт

Түүнд захидал, мессэж бичих	Түүнтэй ярилцах	Түүнийг төрсөн өдөр, бусад арга хэмжээнд урих	Түүнд ном бэлэглэх	



Нөөц хэрэглэгдэхүүн 2.15. Эвлэрэх аргын хэмжих шугам



Нөөц хэрэглэгдэхүүн 2.16. Надад таалагдсан арга

СУЛ ДОРОЙ ХҮН УУЧИЛЖ ЧАДДАГҮЙ. УУЧЛАХ НЬ ХҮЧТЭЙ ХҮНИЙ ШИНЖ ЮМ.

БИД ДҮҮ НАРТАА УУР БУХИМДЛАА ГАРГАХ БҮРДЭЭ ТЭДЭНД ХЭРХЭН УУРТАЙ БАЙХЫГ ЗААЖ БАЙДАГ

САЙН САЙХАН ҮГ ТАНААС ЯМАР Ч ЗАРДАЛ ГАРГАХГҮЙ ХЭРНЭЭ ТАНД АСАР ИХ ҮР АШГИЙГ АВЧИРЧ БАЙДАГ.

УУЧЛАХ НЬ ӨНГӨРСНИЙГ ӨӨРЧЛӨХГҮЙ Ч ИРЭЭДҮЙГ ӨӨРЧИЛНӨ.



СЭДЭВ: ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ



ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧИЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН БҮТЭЦ



ЗОРИЛГО



ТҮЛХҮҮР ҮГ, ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД



ДААЛГАВАР



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ, СОРИЛ



НЭМЭЛТЭЭР УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛ

Сэдэв 1. Энх тайван ба үл хүчирхийллийг эрхэмлэх нь



ЗОРИЛГО

Суралцагчдад энх тайван, үл хүчирхийллийн тухай ойлголт өгч, энх тайвныг эрхэмлэх хандлага төлөвшүүлэх



ТҮЛХҮҮР ҮГ, ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

- **Энх тайван, хамрах хүрээ:** Дайн мөргөлдөөнөөс гадна хүчирхийллийн бүхий л хэлбэр, аюул занал, нийгмийн доройтол, ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, ядуурал, шударга бус байдал зэргээс ангид байх нь энх тайван юм. Энх тайван нь хувь хүний дотоод амар амгалангаас гадна хүмүүс хоорондын, нийгэм, олон нийтийн, олон улсын, цаашлаад даян дэлхийн энх тайвныг хамрах өргөн хүрээний ойлголт юм.
- **Энх тайван:** Хүчирхийлэл, дарамтаас ангид байхаас гадна хүн аз жаргалтай, эрүүл аж төрөх, өөрийгөө илэрхийлэх, бүтээн туурвих эрх чөлөө, боломж хангагдсан нөхцөлд эерэг энх тайван цогцолно. Энх тайвны үед хүмүүсийн дундах буруу тогтсон хандлагыг өөрчилж, ялгавар гадуурхалт, хүний эрхийн зөрчил, эдийн засгийн доройтол, шударга бус байдлыг арилгахын тулд хүмүүс идэвхтэй хүчин чармайлт гаргаж хамтран ажилладаг.
- **Хуурмаг энх тайван:** Хоорондоо сөргөлддөг хоёр тал хоорондоо шууд дайн, мөргөлдөөн байхгүй ч зөрчил тэмцэл нь далд байсаар байхыг хуурмаг энх тайван гэнэ.¹ Дарамт хүчирхийлэлгүй л болохоос хүний сайхан амьдрах бусад нөхцөл боломж бүрдээгүй байвал хуурмаг энх тайван юм.
- **Үл хүчирхийлэл:** Хувь хүн ба бүлэг хүн нийгэм дэх зөрчлийг шийдвэрлэх, шударга бус явдлын эсрэг тэмцэхдээ бусад хүн, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүйгээр шийдвэрлэхийн тулд хүчирхийлэл хэрэглэхгүйгээр тууштай хүчин чармайлт гаргах үйл явц юм.
- **Зөрчил:** Энэ нь хүний амьдралын салшгүй нэг хэсэг юм. Энэ утгаараа зөрчил хаа сайгүй байдаг. Зөрчил нь хоёр ба түүнээс дээш хүний хооронд үүссэн үзэл бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм (Росс Стингер, 1967). Хүмүүс

¹ Жон Галтунг

хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг.

- **Зөрчлийн шалтгаан:** Зөрчил нь юуны өмнө нөөц боломжийн хомсдлоос гадна, зөрчилдөж буй талуудын хэрэгцээ хангагдаагүй байх, эсвэл талуудын ялгаатай байдлаас үүсэн бий болдог гэж үздэг.
- **Зөрчлийн гүнзгийрэл:** Хүмүүс хооронд үүссэн аливаа зөрчлийг шийдвэрлэхгүй бол улам гүнзгийрдэг. Хүмүүст зөрчлийг эхэн үед нь шийдвэрлэх ур чадвар дутагдснаас зөрчил нь улам бүр гүнзгийрч хүндэрдэг. Харин зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэснээр өөртөө итгэх итгэл нэмэгдэж, харилцаа холбоо сайжирч, өсөлт хөгжил бий болдог. Зөрчлийн үед үүсдэг мэдрэмж хүнийг тавгүй байдалд оруулдаг. Үүнтэй холбоотой зарим хүмүүс зөрчилдөхөөс зайлсхийх улмаар аль болох зөрчилдөхгүйг хичээх хандлагатай болдог. Зөрчил гүнзгийрэх нь айдас түгшүүр, эргэлзээ тээнэгэлзэл, гомдол, үзэн ядалт зэрэг сөрөг сэтгэл хөдлөлд хөтөлдөг. Гэхдээ хүн зөрчилтэй нөхцөлд тухайн үүссэн асуудалд сэтгэл хөдлөлөөр хандахаас илүү саруул ухаанаар хандаж бэрхшээл гэхээсээ түүнийг сорилт гэж бодон эерэг талаас харж сурах хэрэгтэй. Зөрчилтэй тулгарах үед хүмүүсийн гаргадаг түгээмэл хандлага бол аль болох нөгөө талаа ялан дийлэхийг хичээх явдал байдаг. Ингэснээр нөгөө талын хүн ч гэсэн ялан дийлэхийг хичээсэн арга барилыг хэрэглэдэг.
- **Зөрчлийн үед** хүмүүсийн гаргадаг хариу үйлдлийг зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэргээр сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайвны арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сөргөлдөгч талууд бие биенийхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох арга замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.
- **Зөрчлийн үеийн арга барил:** Хүмүүс зөрчлийн үед тодорхой арга барилыг хэрэглэж хэвшсэн байдаг. Нэгэнт хэвшин тогтсон учир өөрсдийгөө тухайн арга барилыг хэрэглэдэг гэдгээ тэр бүр мэддэггүйгээс болж өөрийгөө зөвтгөх, бусдыг буруутгах хандлагатай байдаг байна. Иймд зөрчлийг шийдвэрлэхэд чухал нэг алхам нь хүмүүс өөрийн байнга хэрэглэдэг арга барилаа танин мэдэж, зөрчлийн үед тухайн арга барилыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэх талаар тунгаан бодох явдал юм. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг түгээмэл арга барилуудыг өрсөлдөх, зайлсхийх, зохицох, зөвшилцөх, хамтрах гэсэн ангилалд хувааж тодорхой таван амьтнаар төлөөлүүлэн үздэг.



ДААЛГАВАР 1.1.



Ажиллах заавар

Энх тайвны бэлгэ тэмдгүүд

Хүүхдүүд ээ Энх тайвны бэлгэ тэмдгүүдийг мэдэхийг хүсч байна уу. Тэгвэл өгөгдсөн өгүүлбэрүүдийг уншаад аль дүрстэй тохирч байгааг сонгож холбоорой. Хооронд нь зөв холбосон эсэхээ мэдэхийн тулд найзынхтайгаа харьцуулж үзээд багшдаа, эсвэл гэрийнхэндээ үзүүлээрэй. Тэдэнтэй эдгээр дүрс яагаад энх тайвныг төлөөлж байгаа талаар үзэл бодлоо хуваалцаарай.

Даалгавар


1. Энх тайвны модыг цэцэглүүлэх үрийг тарьцгаая.
2. Бусдыг сонсож ойлгох нь энх тайвны нэг үндэс юм.
3. Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх нь энх тайвны үндэс суурь юм.
4. Энх тайвны төлөө гараа өргөцгөө.
5. Энх тайван тогтсон газар аз жаргал дэлбээлдэг.
6. Энх тайван инээмсэглэлээс эхэлдэг.
7. Нэг хүний амар амгалан нэлээд хүний энх тайвныг цогцлооно.
8. Энхийн цагаан тагтаа нь энх тайвны бэлгэ тэмдэг юм.
9. Хүүхдүүд бид нэгэн дуугаар үүний эсрэг үгүй гэж хэлж байна.




а.



б.




в.



г.



д.



е.



ё.



ж.



з.

Хэрэглэгдэхүүн 1. Энх тайвны бэлгэ тэмдэгтэй танилцах



ДААЛГАВАР 1.2.



Ажиллах заавар:

Энх тайвны тухай ярилцъя.

Энэ дасгалыг хоёр хүүхэд нэг баг болон гүйцэтгэж болно. Үүний тулд өгөгдсөн өгүүлэмжүүдийг тус тусад нь хайчлан эвхээд хайрцагт хийнэ. Дараа нь нэг хүүхэд хайрцгаас эвхсэн цаасыг сугалан гаргаж, бичигдсэн өгүүлэмж буюу асуултыг нөгөө хүүхдээсээ асууж, хариултыг сонсоно. Хэрвээ нөгөө хүүхдийн хариулттай санаа нийлэхгүй бол өөрийн санаа бодлоо хуваалцаж болно.

Даалгавар

Асуулт	Тийм	Үгүй
1. Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхгүй бол энх тайван байж чадах уу?		
2. Хүмүүс бие биенээ сонсохгүй бол энх тайван байж чадах уу?		
3. Хүүхдүүдийн гэрээс сургууль явдаг зам харанхуй, бартаа ихтэй байвал хүүхдүүд энх тайван байж чадах уу?		
4. Хүмүүс гэр орондоо архи уугаад байвал энх тайван байж чадах уу?		
5. Хүүхдүүд нэг нэгнээ дээрэлхээд байвал энх тайван байж чадах уу?		
6. Хүн бүр амиа хичээвэл энх тайван тогтох уу?		

7. Хүн бүр бие биенээ сонсдог бол энх тайван тогтох уу?		
8. Хүмүүс бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг бол энх тайван тогтох уу?		
9. Зөвхөн миний аав ээж, гэр бүлийнхэн л сайн сайхан амьдарч байвал энх тайван мөн үү?		
10. Зөвхөн эх орон минь дайн дажингүй байвал бусад улс орны хямрал бидэнд хамаагүй гэж бодвол энх тайван мөн үү?		
11. Эх дэлхийгээ хайрлах нь энх тайвны нэг хэсэг мөн үү?		
12. Ан амьтныг хайрлах нь энх тайвны нэг хэсэг мөн үү?		
13. Нэг хүний амар амгалан байдал гэр бүлийн, сургуулийн, нийгмийн энх тайванд хувь нэмэр оруулах уу?		
14. Ахмад үеэ хүндлэхгүй бол энх тайван тогтох уу?		
15. Хүүхдүүдийг хайрлахгүй бол энх тайван тогтох уу?		
16. Айдас түгшүүртэй хүн энх тайван байж чадах уу?		

Бидний хариулт нэгдсэн асуултууд	Бидний хариулт нэгдээгүй асуултууд



ДААЛГАВАР 1.3.

Ажиллах заавар



Энх тайвны талаар таавар таацгаая тоглоом

Энх тайван байдал нь хувь хүн, нийгэм, байгаль орчинд хамаатай өргөн хүрээний ойлголт юм. Дараах хүснэгтэд энх тайванд хамаатай зүйлүүдийг жагсаан бичсэн бөгөөд хүүхдүүд та бүхэн өгүүлбэр бүрийг уншаад хувь хүн, нийгэм, байгаль орчин гэсэн гурван хүрээний алинд хамаарч буй талаар эргэцүүлэн бодоод хүснэгтэд тэмдэглээрэй.

Даалгавар

ЭНХ ТАЙВАН ГЭДЭГ НЬ ...

Дараах гурван хүрээний алинд хамаарахыг сонгож ✓ тэмдэг тавина уу.			Энх тайвны тухай
Хувь хүн	Нийгэм	Байгаль орчин	
☐	☐	☐	1. Дайн мөргөлдөөнгүй байх
☐	☐	☐	2. Оюун санаа, сэтгэл зүйн амар амгалан байдал
☐	☐	☐	3. Өөр өөр арьсны өнгө, соёл, шашин шүтлэг, үзэл бодолтой хүмүүс бие биендээ дасан зохицож эв нэгдэлтэй амьдрах
☐	☐	☐	4. Хүнийг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх
☐	☐	☐	5. Стрессээс ангижрах, түгшүүргүй байх
☐	☐	☐	6. Бусдын санал нийлэхгүй байгааг хүндэтгэн үзэх
☐	☐	☐	7. Өөрийн санаа бодол, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх
☐	☐	☐	8. Цэрэг армиас илүү боловсрол эрүүл мэндэд хөрөнгө зарцуулах, оруулах
☐	☐	☐	9. Гэр орон, гудамж талбайн цэвэр цэмцгэр, тохилог байдалд хувь нэмэр оруулах
☐	☐	☐	10. Айдас, түгшүүргүй байх
☐	☐	☐	11. Хүмүүс нь ялгаатай олон төрөл хэдий ч хуулийн өмнө бүх хүн эрх тэгш байдаг нийгэмд амьдрах
☐	☐	☐	12. Бусад хүний хийсэн буруу үг, үйлдлийг уучлах
☐	☐	☐	13. Ядарч зүдэрсэн хүмүүст сайн дураараа үйлчлэх, туслах
☐	☐	☐	14. Дэлхий даяар ардчиллыг түгээн дэлгэрүүлэх
☐	☐	☐	15. Байгаль эх дэлхийдээ зохицож амьдрах
☐	☐	☐	16. Цөмийн зэвсэгийн аюул заналгүй амьдрах
☐	☐	☐	17. Айл хөршүүдтэйгээ нээлттэй, эелдэг сайн харилцаатай байх
☐	☐	☐	18. Шударга ёс хэрэгждэг нийгэмд амьдрах

☐	☐	☐	19. Өөрийгөө, бусдыг, ан амьтныг, байгаль дэлхийг хайрлах
☐	☐	☐	20. Гүн бясалгал хийсний дараах мэдрэмж, амар амгалан байдал

Хэрэглэгдэхүүн 2. Энх тайвны хамрах хүрээг тогтоох нь



ДААЛГАВАР 1.4.



Ажиллах заавар

Энх тайвны сэнс бүтээх


Энх тайвны сэнс бүтээх аянд хамрагдах хүүхдүүдийн дунд дараах асуултыг асууж тэдний санаа бодлыг сонсоно уу.

- Хүүхдүүд бид томчуудад энх тайван байхыг уриалах боломжтой юу?
- Хүүхдүүд бид энх тайвны төлөөх дуу хоолойгоо томчуудад хэрхэн хүргэх вэ?
- Хүүхдүүд бид урлагаар дамжуулан энх тайвныг уриалж болох уу?
- Дэлхий дахинд хүүхдүүд энх тайван байдлыг уриалан зохион байгуулдаг “Энх тайвны сэнс” аянд хүүхдүүд бид нэгдэж болох уу?
- Хүүхдүүд бид энх тайвны төлөөх салхин сэнсэн дээр хэнд хандсан ямар үг, өгүүлбэр, уриаг дэвшүүлэн бичиж болох вэ?

Хүүхэд бүрд урьдчилан хэвлэж бэлтгэсэн сэнсний загварыг тараан өгч зааварчилгааны дагуу сэнсийг хайчилж, нааж, будаж бэлтгэхийг хүснэ.

“Энх тайвны сэнс” бүтээх аяны тухай товч мэдээллийг хүүхдүүдэд ярьж өгнө.

Даалгавар



Заавар

- Дээрх дүрсийг гадна талын зураасаар хайчилна.
- Тэгээд аль нэг тал дээр нь энх тайвны утга санааг илэрхийлсэн ямар нэг үг өгүүлбэр бичиж, зураг дүрс зурах, наах зэргээр цаасан сэнсээ чимэглэнэ.
- Дараа нь дөрвөн булангаас нь төв рүү чиглэсэн зураасын дагуу хайчлах ба цаасны голын хэсэг зайг хайчлахгүй үлдээнэ.
- Үүний дараа цаасны дөрвөн булангийн хайчлагдсан хэсгийн аль нэг талыг цаасны голд зөөлнөөр аваачиж наана. Нөгөө талын хайчилсан хэсгийг наахгүй үлдээнэ. Энэ маягаар дүрсний дөрвөн булангийн нэг нэг талыг цаасны голд нааснаар салхин сэнсний хэлбэр үүснэ.
- Үүний дараа салхин сэнсний арын хэсгийн голд урьдчилан бэлтгэсэн савхан мод эсвэл харандааг наана.
- Салхин сэнсний хэсгүүд хоорондоо сайтар наалдсан эсэхийг шалгаж үзээд салхин сэнсээ байрлуулахаар бэлтгэсэн газартаа өөр өөрсдийн салхин сэнсээ газар хатгаж байрлуулна.

Товч мэдээлэл: Энх тайвны сэнс хийх аяныг 2005 онд АНУ-ын Флорида мужийн ахлах сургуулийн хоёр багш Энн Эерс ба Эллен Макмилан нар эхлүүлснээс хойш

дэлхий даяар олон сургуульд хэрэгжиж байна. Энэ үйл ажиллагааг ихэвчлэн Энх тайвны өдөр болох 9 сарын 21-ныг тохиолдуулан зохион байгуулдаг уламжлал сургуулиудад тогтсон байдаг. Энэ арга хэмжээ нь сурагчдад дэлхий дахинд болж буй зөрчил мөргөлдөөн, дайн тулааны эсрэг өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж, энх тайвныг уриалах зорилготой.

1. Салхин сэнсийг бүтээхэд багахан хэмжээтэй цаас эвсэл биет материал, түүн дээр зураг зурж бичих өнгийн харандаа, бүтээлч сэтгэлгээ байхад хангалттай.



- Хүүхдүүд өөрсдийн салхин сэнсэн дээрээ энх тайвныг уриалсан үг өгүүлбэр бичиж, дүрс зургийг зурж бүтээснээр энх тайвны төлөөх өөрсдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж, салхин сэнсээ ямарваа нэг газарт байрлуулснаар өөрсдийн илгээлтээ салхиар дамжуулан нийт хүмүүст илгээж байна гэсэн утга санааг агуулдаг.

2. Бүх хүүхэд сэнсээ бүтээж дууссаны дараа сэнсээ байрлуулах газар руу хамтдаа явж, байрлуулна. Энх тайвны сэнс байрлуулах талбайг сонгохдоо сургуулийн өмнө, хажууд зэрэг сургуулийн эргэн тойронд олон хүн явдаг газрыг сонгоорой. Хүүхдүүдийн энх тайвны сэнсэн дээр бичиж зурсан энх тайвны



- илгээмжийг хажуугаар өнгөрч буй хүмүүс унших боломжтой байрлалд байрлуулахыг хичээгээрэй. Хүүхдүүд энх тайвны сэнсээ өөрсдийн гараар байрлуулах ба сэнсийг эргүүлэх салхины урсгалаар дамжин хүүхдүүдийн илгээмж зүг бүрт тархан олон хүнд хүрээсэй гэж хамтдаа хүсдэг

3. Энх тайвны сэнсээ 3 өдөр, эсвэл 7 өдөр гэх мэт тодорхой өдрүүдэд байрлуулсны дараа хүүхэд бүр өөрсдийн сэнсээ авч, гэрийнхэндээ үзүүлэн өөрийн бүтээлийн хавтсандаа хадгалахыг хүсээрэй.





ДААЛГАВАР 1.5.




Ажиллах заавар

Энх тайван ба үл хүчирхийлэл үгийн сүлжээ

1. Бүх хүүхдэд үгийн сүлжээг тараан өгч бөглүүлнэ.
2. Үгийн сүлжээг бөглөж дууссаны дараа хүүхдүүдийн хариултыг зөв хариулттай тулгаад, үгийн сүлжээнд дурдагдсан үгсийн талаар өөрсдийн мэддэг зүйлээ бусадтайгаа хуваалцахыг хүснэ.

Даалгавар



ДААЛГАВАР 1.6.



Ажиллах заавар

Энх тайвны төлөөх сайн үйлсэд нэгдэх

1. Дараах сайн үйлсийн жагсаалтыг бүх хүүхдэд тараан өгч 7 хоногийн хугацаанд жагсаалтын дагуу сайн үйлс хийх даалгавар өгнө.
2. Өгөгдсөн хугацаа өнгөрсний дараа хүүхдүүд бие биедээ өөрсдийн хийсэн сайн үйлсийн тухай танилцуулж ямар сэтгэгдэл, мэдрэмж төрсөн, ямар зэрэг өөрчлөлт гарсан талаар сэтгэгдлээ бусадтайгаа хувцалцахыг хүсч болно.

Даалгавар



Өдөр тутам үйлдэж болох сайн үйл

- ✓ Хэн нэг хүнд түүнд ямар их талархаж явдгаа хэлэх, илэрхийлэх
- ✓ Оройн хоол хийхэд туслах
- ✓ Шувууд ба амьтдыг хооллох
- ✓ Хэн нэг хүнийг баярлуулах сайхан үг, захидал, эсвэл ямар нэг юмыг бэлдээд түүний олох газар нуух
- ✓ Хэн нэгэн хүнд шинэ зүйл, шинэ чадвар зааж сургах
- ✓ Хүмүүс рүү инээж эелдэг найрсаг харьцах
- ✓ Хүмүүсийг баярлуулах захидал бичих
- ✓ Гэр орноо санаачилгаараа цэвэрлэх
- ✓ Хэн нэг хүнийг магтаж урамшуулах
- ✓ Амьдралдаа юунд талархаж явдгаа жагсаан бичих
- ✓ Гэрийнхнийхээ ор дэвсгэрийг хурааж туслах
- ✓ Гэр сургуулийнхаа эргэн тойронд хүмүүсийн хаясан хогийг цэвэрлэх
- ✓ Найздаа эсвэл ангийнхандаа аль нэг хүүхдэд гурван сайн зүйлийг нь хэлж өгөх
- ✓ Хөршдөө зориулж ямар нэг сайн зүйл хийх
- ✓ Өөрийгөө хайрлаж өдөрт сайн ус ууж, эрүүл тэжээллэг хоол идэж байх.
- ✓ Аль болох гомдол гаргахгүй байхыг хичээ. Эсвэл бага гомдоллохыг хичээх
- ✓ Эерэг хандлагын самбарыг өөртөө зориулан бүтээх.
- ✓ Аливаа эелдгээр хүсч, хариу талархснаа илэрхийлэх.
- ✓ Цахилгаан, эрчим хүчээ хэмнэж эх дэлхийгээ хайрлах.
- ✓ Өөрийн судалдаг амьтантай болж тухайн амьтнаа хамгаалахын төлөө ямар нэг зүйл хийх
- ✓ Найз нөхөд, гэрийнхэн, багшдаа зориулж зураг зурж бэлэглэх.



- ✓ Найз нартаа инээдтэй зүйл ярьж өгч сэргээхийг хичээх
- ✓ Цаас, даавуу, хүнсний уут зэрэг хог хаягдлыг дахин ашиглахыг эрмэлзэх.
- ✓ Өөртөө байгаа эд зүйлийг шинээр авахгүйгээр хуучнаа ариг гамтай хэрэглэх.
- ✓ Гэрийнхэндээ өглөөний мэнд дэвшүүлж, орой сайхан амраарай гэж хэлж занших
- ✓ Гэр дотроо хэн нэгнийг олоход зориулж жижигхэн талархлын захидал үлдээх
- ✓ Гэрийнхэндээ хэрэгтэй зүйлийг нь хийж өгч туслах
- ✓ Өөрийн дуртай зүйлээ аз жаргалтайгаар хийх



ДААЛГАВАР 1.7.



Ажиллах заавар

Энх тайвны төлөөх сайн үйлсэд нэгдэх

1. Сайн үйлсийн жагсаалтыг бүх хүүхдэд тараан өгч 7 хоногийн хугацаанд жагсаалтын дагуу сайн үйлс хийх даалгавар өгнө.
2. Өгөгдсөн хугацаа өнгөрсний дараа хүүхдүүд бие биедээ өөрсдийн хийсэн сайн үйлсийн тухай танилцуулж ямар сэтгэгдэл, мэдрэмж төрсөн, ямар зэрэг өөрчлөлт гарсан талаар сэтгэгдлээ бусадтайгаа хувцаалцахыг хүсч болно.

Даалгавар

1. Үүдэнд таарсан хүнд хаалга нээж өгөх, түүнийг хүлээн түрүүлж оруулах
2. Хэн нэгэн хүнд талархал илэрхийлэх
3. Секц, дугуйлан, клубээрээ нэгдэн сайн дураараа сургуулийн ажилд туслах
4. Анги танхим дах хогийг сайн дураараа түүж хогийн саванд хаях
5. Хүмүүст юм өргөхөд туслах
6. Ганцаараа байгаа нэгнийг тоглохыг урих, хамтдаа тоглох
7. Хошигнол ярьж бусдыг инээлгэх
8. Номын сангийн номны завсар дараагийн уншигчид зориулж гоё үгтэй захидал бичиж үлдээх
9. Сургуулийн коридорт хаягдсан хогийг авч хогийн саванд хийх
10. Багшдаа, жижүүрт, нийгмийн ажилтан, эмч гээд сургуулийн ажилтанд талархлаа илэрхийлэх
11. Сэтгэлээр унасан, уйтгартай байгаа нэгнийг баярлуулахыг хичээх
12. Дараалалд зогсож байхдаа шаардлагатай хүнийг урдуураа орохыг зөвшөөрөх
13. Сургуульд, ангид шинээр шилжин ирсэн хүүхэдтэй ярилцаж үзэх, түүнд мэдэхгүй зүйлийг нь хэлж өгөх
14. Хэн нэг хүнд тэр яагаад онцгой болох тухай хэлэх
15. Хэн нэг хүнд хүссэн номыг нь уншиж өгөх
16. Ангийнхандаа гэрийн даалгавар хийхэд нь туслах
17. Хамт суудаг хүүхдийнхээ харандаануудыг үзүүрлэж өгөх
18. Найздаа, ангийнхандаа номны хавчуурга хийж бэлэглэх
19. Хүн бүр рүү инээмсэглэл. Инээмсэглэл аяндаа дэлгэрнэ.





ДААЛГАВАР 1.8



Ажиллах заавар

1. Сайн үйлсийн жагсаалтыг бүх хүүхдэд тараан өгч 7 хоногийн хугацаанд жагсаалтын дагуу сайн үйлс хийх даалгавар өгнө.
2. Өгөгдсөн хугацаа өнгөрсний дараа хүүхдүүд бие биедээ өөрсдийн хийсэн сайн үйлсийн тухай танилцуулж ямар сэтгэгдэл, мэдрэмж төрсөн, ямар эерэг өөрчлөлт гарсан талаар сэтгэгдлээ бусадтайгаа хувцаалцахыг хүсч болно

Даалгавар



Хүмүүс рүү инээмсэглээд
баярлалаа гэж хэлэх



Найздаа гадуур хувцсаа
өмсөхөд нь туслах



Бусад хүүхэдтэй өөрийн
хайртай тоглоомоор хамт
тоглох



Чөлөөт цагаараа хайртай
хүндээ зориулж зураг
зурж өгөн бэлэглэх



Бусдад талархаж
байгаагаа илэрхийлэх



Бусдад сандал
ойртуулж өгөх



Бусдын ширээн дээрх
юмыг эмхэлж цэгцэлж
өгөх



Тоглоомын эсвэл спортын
талбайн тоглоом,
эд зүйлсийг хурааж
цуглуулж өгөх



Бусдын ном, дэвтрийг
хурааж өгөх, номын
тавиурыг цэгцлэх



Бусдад урам хайрлах,
магтах, дэмжих



Гэртээ цэвэрлэгээ хийхэд
туслах




Хиртэй хувцсаа угаалгын
машинд хийж угаах



Бусадтай харилцахдаа
тэгнэ үү, ингэнэ үү хэмээн
ээлдэг харьцаж талархлаа
илэрхийлж байх



Найздаа болон бусдад
түрүүлж хаалга онгойлгож
өгөх



Бусдад зориулж
талархлын үг, захидал
бичих



Гудамжинд байгаа хог
хаягдлыг цэвэрлэж хогийн
саванд хийх



Бусад хүүхдийн өдрийн
хоолны ойр орчмыг
эмхэлж цэгцлэхэд туслах



Гэрийнхэндээ оройн хоол
хийхэд туслах




Тоглоомуудаа хураах



Уйтгарласан урам
хугарсан найзыгаа аргадах,
тайтгаруулах, дэмжин
урамшуулах



Үнэхээр хэрэгцээ
шаардлагатай байгаа нэгнийг
урдуураа орохыг зөвшөөрөх



Буйдангийн бүтээлэг,
дэрийг цэгцлэх



Багшдаа ангийн хаалгыг
нээж өгөх



Ангийн хүүхдээ
хичээлийн хэрэглэлээ
цэгцлэхэд нь туслах



Амралтын өдрөөр
машинаа угаахад нь
гэрийнхэндээ туслах



Гэрийнхэндээ гадуур
өмссөн ба ажлын хувцсаа
эвхэхэд нь туслах



Тусламж хэрэгтэй
хүмүүсийн тухай бодох



Бусдад сайн санаа, сайхан
сэтгэлээр туслах



Бусдыг хувцасны тавиураа
эсвэл гэрийнхэндээ
үүдний тавиураа цэгцлэхэд
нь туслах




Чамд тусалсан хэн нэгэнд
талархснаа илэрхийлэх



Хүнтэй харилцан ярьж
байгаа бол түүнийг
сонсож байна гэдгийгээ
илэрхийлэх



Гэрийнхэндээ болон
хайртай хүмүүсдээ
зориулж мэндчилгээний
карт илгээж баярлуулах



Бусад хүнд байдаг сайн
зан чанарыг жагсааж
бичих



Хэн нэгэнд талархснаа
илэрхийлж тэврэх



Өөрийн авсан, хөдөлгөсөн
зүйлээ байранд нь буцааж
тавих



Эелдэг найрсаг
харилцаатай байх



Гэр орны ажлыг сайн
дураараа хийх



Тусламж хэрэгтэй байгаа
хэн нэгэнд чадлынхаа
хэрээр туслахыг хичээх



Хэн нэгнийг шог хошин
яриагаар инээлгэх



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ, СОРИЛ

1. Энх тайвныг юугаар бэлгэддэг вэ?
 1. Тагтаа /зөв хариулт/
 2. Туулай
 3. Морь
 4. Зөгий
2. Дараах хүмүүсийн аль нь гэр бүл, ажил, сургууль, нийгмийн орчинд энх тайван байхад хувь нэмэр оруулах вэ? 2 хариулт сонгоно уу.
 1. Бусдыг сонсдог хүн
 2. Өөрийнхөөрөө зүтгэдэг хүн
 3. Бусдын ялгаатай байдал, үзэл бодлыг хүндэтгэдэг хүн
 4. Өөрийн үзэл бодлоо хатуу бат хамгаалдаг хүн
 5. Юунд ч санаа зовдоггүй хүн
 6. Хэнэггүй хүн
3. Дараах хүмүүсийн аль нь энх тайвны элч төлөөлөгч вэ? 3 хүртэл зөв хариулт сонгоно уу.
 1. Альберт Эйнштэйн
 2. Малала охин
 3. Адолф Гилер
 4. Махатма Ганди
 5. Далай Лам
4. Хүн бүр өөрийн амьдарч буй гэр орон, анги хамт олон найз нөхөд, нийгмээ энх тайван байх уу эсвэл айдас түгшүүртэй байх уу гэдэгт хувь нэмэр оруулж байдаг. Иймд энх тайван байдал хүн бүрээс шалтгаалдаг.
 1. Тийм
 2. Үгүй
5. Би бусад хүмүүсийг ойлгож, тэдэнтэй хүндэтгэлтэй харьцаж байна гэдэг нь энх тайвныг бий болгоход өөрийн зүгээс хувь нэмрээ оруулж буй хэрэг юм.
 1. Тийм
 2. Үгүй
6. Ямарваа нэг улсад ил тод дайн тулаан өрнөхгүй байгаа ч хүмүүс нь айдас түгшүүртэй, бие биенээсээ айж, түгшиж, болгоомжилж амьдрах нь дараах хариултын алинд хамаарах вэ?
 1. Энх тайван
 2. Хуурмаг энх тайван
7. Энх тайван хэмээх ойлголт нь ямар хүрээг хамрах вэ?
 1. Хувь хүн

2. Нийгэм
3. Байгаль орчин
4. Дээрх бүгд

8. Нийгэм дэх шударга бус зүйлийн эсрэг тэмцэхдээ хүч хэрэглэх нь байхгүй.

1. Тийм
2. Үгүй



9. Хүмүүс бид шударга бус зүйлийн эсрэг тэмцэхдээ хүчирхийлэл хэрэглэхгүйгээр тэмцэх нь хамгийн зөв сонголт юм.

1. Тийм
2. Үгүй

10. Нийгэмд хэн хүч чадалтай нь ялан дийлдэг байгалийн хуулиар явах ёстой.

1. Тийм
2. Үгүй

11. Зөрчлийн үед зөрчилдөж буй хүмүүс бие биенээ сайтар сонсож, ярилцан дундын шийдлийг олох хэрэгтэй.

1. Тийм
2. Үгүй

12. Би амар амгалан байж, энх тайвныг эрхэмлэх нь миний гэр бүл, найз нөхөд, ангийн хамт олонд энх тайван байхад чухал юм.

1. Тийм
2. Үгүй



НЭМЭЛТЭЭР УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛ



ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ

Хүмүүс бидний сайн сайхан амьдралын үндэс суурь нь энх тайван байдал юм.

Энх тайвны талаар хүмүүсийн ойлголт бага зэрэг ялгаатай байдаг. Улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, нийгмийн ухааны хувьд энх тайвныг өөр өөрсдийн салбарын онцлогтой холбоотойгоор авч үзэн тайлбарладаг.

Эдийн засгийн хувьд	ядуурлаас ангид байх буюу хүмүүсийн эдийн засгийн сайн сайхан байдалд аж төрөх
Улс төрийн хувьд	Ардчилал, сайн засаглалын үр дүнд энх тайван оршин тогтноно.
Дайны эсрэг үзлээр	дайн мөргөлдөөнийг зогсоосон цагт энх тайван тогтоно.
Хууль, эрх зүйн хувьд	хуулийг сахин биелүүлж, дэг журамтай байх нь энх тайвныг бүрдүүлнэ.
Нийгмийн хувьд	ялгаатай бүлгүүдийн дундах зөрчлийг шийдвэрлэж, шударга ёсыг сахих замаар хүмүүс нэг нь нөгөөдөө зохицож амьдрах нь энх тайван юм.

Бодит байдал дээр энх тайвныг зөвхөн дайн байлдааныг зогсоосноор, хууль дэг журмыг хангаснаар, эсвэл ядуурлыг бууруулснаар бий болгож чадахгүй. Тэгэхээр энх тайван гэдэг нь бүх салбарыг хамарсан цогц (холистик) ойлголт юм.

Энх тайван ба хуурмаг энх тайван


Хүмүүс энх тайван гэдгийг “дайн дажингүй байх” гэж ойлгодог. Судлаач Галтунг энэ байдлыг хоёр тал хоорондоо дайтахгүй ч зөрчил тэмцэл нь байсаар байдаг учир хуурмаг энх тайван гэж нэрлэсэн байна.

Хүмүүст шууд ба шууд бусаар нөлөөлөх дарангуйллын дэглэм, хүчирхийлэл, дарамт байхгүй үед тайван байдал оршин байж болох ч хүмүүсийн эрх, эрх чөлөө хязгаарлагдмал байвал энэ нь хуурмаг энх тайван юм. Тодруулбал дарамт хүчирхийлэлгүй л болохоос хүний сайхан амьдрах бусад нөхцөл боломж бүрдээгүй байдлыг хэлнэ. Жишээ нь сөргөлдөгч талууд бие биенийхээ эсрэг гал нээхгүйгээр тохиролцох, тоглоомын талбай, эсвэл ангид зодолдохыг хориглох гэх мэт нь хүчирхийллийг хориглож буй хэдий ч далд зөрчил нь байсаар байхыг хэлнэ. Харин хүчирхийлэл, дарамтаас ангид байхаас гадна хүн аз жаргалтай, эрүүл аж төрөх, өөрийгөө илэрхийлэх, бүтээн туурвих эрх чөлөө, боломж

хангагдсан нөхцөлд жинхэнэ буюу эерэг энх тайван цогцолно гэж үздэг. Энх тайвны үед хүмүүсийн дундах буруу тогтсон хандлагыг өөрчилж, ялгавар гадуурхалт, хүний эрхийн зөрчил, эдийн засгийн доройтол, шударга бус байдлыг арилгахын тулд хүмүүс идэвхитэй хүчин чармайлт гаргаж хамтран ажилладаг.

Энх тайван нь хувь хүний дотоод амар амгалангаас гадна хүмүүс хоорондын, нийгэм, олон нийтийн, олон улсын, цаашлаад даян дэлхийн энх тайвныг хамрах өргөн хүрээний ойлголт юм.

- Дотоод энх тайванд хувь хүний өөрийнхөөрөө байх, дотоод зөрчилгүй, баяр хөөртэй, эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн сэтгэл зүйн амар амгалан байдлыг ойлгоно.
- Хүмүүс хоорондын энх тайванд хүмүүсийн харилцан ойлголцол, хүндэтгэлд суурилсан, бие биеийнхээ ялгаатай байдал, онцлогийг хүлээн зөвшөөрсөн, харилцаа, хамтын ажиллагааны хэлбэрийг ойлгоно.
- Нийгмийн энх тайванд улс орны ардчилал, хүний эрх, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн, хууль ёсыг чанд сахисан нийгмийн амар амгалан байдлыг ойлгоно.
- Олон улсын энх тайванд улс орнууд бусад улс орны хил хязгаар, эрх ашигт хүндэтгэлтэй хандаж, шударга ёсыг сахин бүс нутаг, олон улсын хэмжээнд эв найрамдалтай, дипломат ёсны хэм хэмжээг сахин харилцаж хамтран ажиллахыг ойлгоно.
- Даян дэлхийн энх тайванд хүн төрөлхтний хүрээлэн буй орчин, ан амьтан, ургамал, байгаль дэлхийтэйгээ зохицон тогтвортой амьдарч, аж төрөх арга хэлбэрийг багтаан ойлгоно.



Үл хүчирхийлэл

Үл хүчирхийлэл нь хоёр үгнээс тогтсон холбоо үг бөгөөд үл гэдэг нь үйл үгийн өмнө тохиолдож тухайн үйл үгээр илрэх утгыг үгүйсгэх (эх сурвалж: Монгол хэлний тайлбар толь) тул үл хүчирхийлэл гэдэг нь хүчирхийлэхгүй гэсэн утгыг агуулна. Үл хүчирхийлэл ийнхүү хүчирхийлэхгүй гэсэн санаа агуулагдаж байгаа ч холбогдох ном зохиолд бичсэн тайлбараас харахад хүчирхийлэхгүй гэдэг нь дарлал мөлжлөгийн үед түүнтэй эвлэрэн хүч хэрэглэхгүй зүгээр суух гэсэн идэвхгүй утгатай биш харин ч дарлал мөлжлөгийн эсрэг тууштай тэмцэхдээ хүчирхийллийг хэрэглэхгүйгээр тэмцэх гэсэн идэвхтэй үйл хөдлөлийг илэрхийлнэ гэж бичсэн байна. Үл хүчирхийллийн тухай тайлбарласан ном, материал, эх сурвалжийн агуулгад дүн шинжилгээ хийхэд дараах хоёр маягаар тодорхойлсон байна. Үүнд:

- *Үл хүчирхийлэл нь дарлалт, шударга бус байдлын эсрэг тэмцэх, эсэргүүцлээ илэрхийлэх арга хэлбэр болох нь.* Энэ утгаар үл хүчирхийлэл гэдэг нь хувь хүн ба бүлэг хүмүүс нийгэм дэх зөрчлийг шийдвэрлэх, шударга бус явдлын эсрэг тэмцэхдээ бусад хүн, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүйгээр шийдвэрлэхийн тулд хүчирхийлэл хэрэглэхгүйгээр тууштай хүчин чармайлт гаргах үйл явц юм. Үл хүчирхийллийн зорилго нь хүний эрх, шударга ёсыг шаардан, хүчирхийллийн бус арга зам, шахалт үзүүлэх замаар хүмүүсийг зүй бус дарлал, мөлжлөгийн тоглолцоо, сөрөг хандлагаас хамгаалахад чиглэдэг. Үл хүчирхийллийн тухай үзэл санааны томоохон төлөөлөгч нь Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний удирдагч Махатма Ганди юм.
- Үл хүчирхийллийг хүчирхийлэл хэрэглэхгүйгээр энх тайвны төлөө яриа хэлэлцээр хийх арга гэж үздэг. Хүмүүсийн бие махбод, сэтгэл зүйд гэм хор учруулахгүйгээр эсэргүүцлээ илэрхийлэх нэг арга зам нь үл хүчирхийлэл гэсэн үг юм. Нийгэм дэх хүчирхийлэл, дарлал, мөлжлөгийн эсрэг хүчирхийлэл хэрэглэх нь олон сөрөг үр дагавар дагуулдаг учир үүний эсрэг тэмцэх хамгийн үр дүнтэй, оновчтой, идэвхтэй арга зам нь үл хүчирхийлэл гэж дэлхий дахинаа үзэж байна.

Дарлал, мөлжлөг, шударга бус байдлын эсрэг тэмцэх үл хүчирхийллийн хэд хэдэн арга зам байдгаас заримыг нь дурдвал:

Хүснэгт 2. Үл хүчирхийллийн арга зам

Эсэргүүцлээ илэрхийлэх	<i>Жагсах</i> – хүмүүс олон нийтийн газар цугларч, тодорхой зүйл дээр ижил санаа бодолтой байгаа илэрхийлэх <i>Гарын үсэг зурах</i> – ямарваа бодлого, шийдвэрийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлж, шаардлагыг баталгаажуулж гарын үсгээ зурж нэгдэх
Хамтран ажиллахгүй байх	<i>Бойкот</i> – Үйлчилгээ, бүтээгдэхүүнд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахаас татгалзах <i>Ажил хаялт</i> – Ажлаа хийхээс татгалзах замаар эсэргүүцлээ илэрхийлж буй хэлбэр юм. Дэлхий дахинаа коммунист дэглэмийг нуран унах явцыг эхлүүлсэн Польш улс дах ажил хаялт нь үл хүчирхийллийн хөдөлгөөний эхлэл болсон түүхтэй. <i>Хамтрахаас татгалзах</i> – Дэлхийн 2-р дайны үед Норвегийн багш нар Нацистуудын боловсролын хөтөлбөрийн дагуу хичээл заахаас татгалзсан бөгөөд тэднийг үүнийх нь төлөө хорих ангид цагдан хорьсон ч багш нар өөрсдийн байр сууриндаа тууштай байсан учраас тэднийг буцаад сургуульд нь буцааж байжээ.
Интервенци хэрэгжүүлэх	<i>Суулт хийх</i> – Гудамж, зам талбай зэрэг олон нийтийн газар хүмүүс нэгдэн нийлж суулт хийх замаар эсэргүүцлээ илэрхийлэх хэлбэр <i>Урьдчилан сэргийлэх оролцоо</i> – Зөрчил, мөргөлдөөнтэй бүс нутагт байгаа жирийн иргэд, эмзэг хүмүүсийг хамгаалах зорилгоор сайн санааны элч төлөөлөгч тухайн газар нутагт байршиж ажиллахыг хэлнэ. Эдгээрийг голдуу гуравдагч тал, энхийг сахиулагч гэж нэрлэдэг ба эдгээр нь зөрчилдөгч талуудын аль нэгэнтэй холбоо хамааралгүй байдаг.


Үл хүчирхийлэл нь өдөр тутмын амьдралын нэг хэсэг буюу амьдралын хэв маяг болох нь. Дэлхий дахинаа олон хүмүүсийн хувьд үл хүчирхийлэл нь улс төрийн тавцанд өрнөдөг үйл явц бус харин тэдний өдөр тутмын амьдралын нэг хэсэг буюу амьдралын хэв маяг болсон байдаг. Үл хүчирхийлэл нь онцгой тохиолдолд болдог түр зуурын үйл явдал бус харин өдөр тутмын амьдралд баримтлах зарчим, хэм хэмжээ гэж тэдгээр хүмүүс үздэг байна.

Энх тайвны замаар дэлхийг донсолгосон Махатма Ганди²

Зөөлөн нь хатуугаа дийлдэг гэх Дорнын мэргэн үгийг дэлхий дахинд нотолсон энэхүү агуу хүн 1869 оны 10 дугаар сарын 2-нд мужийн ерөнхий сайд Карамчанд

² Нийслэл.мн сайтны Алдартны түүх булангийн нийтлэлийг товчлон авав. Хандсан холбоос: <http://www.niislel.mn/v/4562> 2022 оны 5 сарын 10-нд хандсан.

Гандигийн отгон хүү болон мэндэлжээ. 1891 онд Их Британиас өмгөөлөгчийн зэрэгтэй ирсний дараа түүнд Өмнөд Африкт нэг жил ажиллах санал тавихад дуртайяа зөвшөөрчээ. Очсон даруйдаа урт аялалд явах шаардлага гарсан бөгөөд гагцхүү энэ л аяллаар тэр Өмнөд Африкт бий болсон ялгаварлан гадуурхах үзлийг өөрийн биеэр мэдэрчээ.



Нэгдүгээр зэргийн билеттэй атал гуравдугаар зэрэглэл рүү хөөгдөж, Европ зорчигчид суудал тавьж өгөөгүйгээс болж сүйх тэрэгний жолоочид зодуулсан тэрээр удахгүй энэ нь ганц өөрт нь тохиолдсон хэрэг биш Өмнөд Африкийн өнгөт арьстан болгоны асуудал болохыг ойлгожээ. Энэ үед тэрээр Энэтхэг рүүгээ буцах, эсвэл үлдээд энэ шударга бус байдалтай тэмцэх гэсэн хоёр сонголттой тулгарсан юм.

Гандигийн өмнөд Африкт туулсан амьдралын хатуу хүтүү нь түүнийг ирээдүйд хийх үйлсэд нь хөтөлсөн бөгөөд чухамхүү энд л түүний улс төр, ёс суртахууны үзэл бодол, удирдагч зан чанар төлөвшжээ. Махатма Ганди хэлэхдээ “Дэлхий дээр өөрийнхөө хиймээр байгаа өөрчлөлт нь чи өөрөө байх ёстой” гэсэн байдаг. Тэрээр нийгмийн давхарга, шашны үзэл бодлоос үл хамаараад хүн тэгш эрхтэй байх ёстой гэсэн хатуу байр суурьтай байсан юм. 1906 онд Махатма Ганди түүний одоо хүртэл судлагдаж улам боловсронгуй болж буй Сатяграха, үгчилбэл “үнэний төлөө”, утгачилбал “энх тайван замаар тэмцэх” гэсэн ухагдахуунаа анх гаргаж ирж Өмнөд Африкт байсан энэтхэгчүүдийг бүртгэх гэсэн Трансваалын Засгийн газрын эсрэг хэрэглэсэн юм. Мартин Лютер Кинг, Нелсон Мандела зэрэг үе үеийн нэрт удирдагчид Махатма Гандигаас суралцаж түүний энх тайван замаар тэмцэх аргыг хэрэглэж байжээ.

Өмнөд Африкт жил болно гэж байсан тэрээр эрх нь зөрчигдсөн Өмнөд Африкийн энэтхэгчүүдийн төлөө тэмцэж 21 жил болсон бөгөөд 1915 онд эх нутгийн зүг жолоо залсан юм. Гандигийн Өмнөд Африкт байгуулсан гавьяа нь хэдийн дэлхийн сонорт хүрч, түүнийг Энэтхэгт үндэсний баатар хэмээн хүлээж авлаа. Энэтхэгчүүд нь Их Британы колончлолд элдэв хууль дүрэм, татварын дор хүнд хүчир амьдралыг туулж байв. Тэрээр ургацын оронд борлуулах ургац тариалах дүрмийн эсрэг /Чампаран/, гантай үеийн өндөр татварын эсрэг /хеда/, давсан үйлдвэрлэлийн хоригийн эсрэг /давсны сатяграха/, мөн Их Британий засаглалын эсрэг эсэргүүцлийн хөдөлгөөнийг энх тайвны замаар явуулсан бөгөөд эдгээр нь бүгд ганц Их Британы биш дэлхий нийтийн анхаарлыг татсанаар эцэст нь амжилт олж 1929 оны 12 сарын 31-нд тусгаар тогтнолоо зарлаж чадсан юм.

Тэрээр ганц бослого цуглаанаар биш өөрийн бүхий л үйлдлээрээ Их Британиас тусгаар тогтнохыг уриалж үлгэрлэн удирдаж байж Энэтхэгийг тусгаар тогтнолын замд нь хөтөлсөн юм. Энэтхэгчүүд түүхий эдээ Англи руу хямд үнээр экспортолж буцаагаад өндөр үнэтэй даавуу, хувцас болгон авдаг байсныг буруушааж Ганди

энэтхэгчүүдийг өөрсдөө хувцас даавуугаа нэхэхийг уриалсан юм. Тэрээр байнга ээрмэлийн машин авч явж хурал цуглааны үеэр ч даавуу ээрч суусаар өөрийн энэ санаагаа олонд таниулж чаджээ. Тиймдээ ч Энэтхэгийн тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг нь ээрмэлийн машины дугуй байдаг. Ганди энх тайвны бослого цуглаан санаачилсан улс төрийн удирдагчаас гадна Энэтхэгийн ард түмний оюун санааны удирдагч нь байсаар иржээ.

Малала Юсуфзай: Ганц хүн ч дэлхийг өөрчилж чадна³



Малала Юсуфзай бол хамгийн залуудаа буюу 17 насандаа Нобелийн шагнал хүртсэн Пакистан охин. Тэрээр 1997 онд Пакистаны Мингора хотод сургуулийн захирал, пакистаны хүүхдийн эрхийг хамгаалагчийн гэр бүлд төрсөн. 2009 онд “Би-Би-Си”-гийн сэтгүүлч пакистаны энэ хөндийн хотхонд очиж Малала охиныг өөрийнхөө болон

өөр шиг нь пакистан охины амьдралыг өгүүлсэн тусгай блог нээхийг санал болгожээ. Малала охин ч зөвшөөрч блог нээн пакистаны хүүхэд багачууд, охид эмэгтэйчүүдийн хүнд амьдралын талаар бичиж эхэлснээр тэр дорхноо л олны хүртээл болж алдаршсан байна. Блогийг англи хэл дээр орчуулан нийтэлснээр пакистан хүүхдүүдийн хүнд амьдрал, талибуудын байнгын дарамтад байдаг охид эмэгтэйчүүдийн амьдрал дэлхий нийтийн анхаарлын төвд оржээ. Эцэг нь ч охиндоо дэмжлэг үзүүлж байлаа. Малала “Гюль Макаи” нэрээр бичиж, тун удалгүй түүний оролцоотойгоор баримтаг кино хийсэн нь мусульман охид эмэгтэйчүүдийн сэтгэл эмзэглэмээр хувь заяаны нууцлаг түүх олны хүртээл болсон юм. Охин олны танил болон нэрд гарч, түүнийг дэмжин дагалддаг охид бүсгүйчүүдтэй болжээ.

Охид бүсгүйчүүдийн хүнд амьдрал, талибуудын хавчилт шахалтын тухай охины хурц бичлэгүүд талибын хэт даврагчдад таалагдсангүй. 2012 оны аравдугаар сард Малала охин хичээлээ тараад явж байхад түүний найзуудтайгаа суусан сургуулийн автобусыг “Талибан” бүлэглэлийн хүмүүс зогсоожээ. Буу агссан алан хядагч сургуулийн автобусанд дайран орж ирээд хэн чинь Малала вэ гэж асуухад охин “Би Малала байна” гэж хашгирчээ. Энэ үг түүний амьдралыг тасалж болох байсан ч охин хожим нь “Энэ өдөр миний айдас үхсэн юм” гэсэн байдаг. Энэ жижигхэн, турьхан охинд ямар их сэтгэлийн хат, эр зориг, хатуужил байгааг итгэхэд бэрх. Халдлагаас азаар амьд үлдэж комд орсон охиныг эмнэлэгт хүргэсэн байна. Охины амийг аврахын тулд Их Британийн хамгийн шилдэг эмнэлгийн нэгд хүргэж, хэд хэдэн мэс засал хийн, курс эмчилгээ хийжээ. Үүний дараа ч гэсэн Малала охиныг мусульман охид бүсгүйчүүдийн хүнд амьдрал, талибуудын шахалтын талаарх нийтлэл бичихээ болихыг нэг бус удаа шаардаж байсан ч охин

³ Энэ материалыг дараах эх сурвалжаас товчлон авав. Эх сурвалж: Х.Өлзийбаяр. Малала Юсуфзай: Ганц хүн ч дэлхийг өөрчилж чадна Ардчилал таймс, сонин холбоос <https://www.infomongol.mn/a/162186> хандсан 2022 оны 5 сарын 10.

дэлхий дахинаа танил болсон нэр хүндээ ашиглан өөрийн ард түмний гашуун амьдралын үнэнийг дэлхий дахинд хүргэх ажлаасаа татгалзсангүй.

Малала охин хүнд шархадсаны дараа эрүүл саруул болж хэвийн амьдралдаа шилжихэд бараг бүтэн жил шаардагдсан байна. 2013 оны долдугаар сарын 12-нд Малала Юсуфзай охин 16 нас хүрсэн өдрөө НҮБ-ын албан байранд зочилж пакистаны хүүхдүүдийн эрхийг хамгаалах асуудлаар олны сэтгэл хөдөлгөм үг хэлсэн юм. Түүний үг манай дэлхийн улс төрийн зүтгэлтнүүд, нэр нөлөө бүхий хүмүүсийн анхаарлыг татаж, өндөр үнэлсэн юм. Пакистан охины энэ түүх нэг хүн ч дэлхийг өөрчилж болно гэдгийг харуулж байна. Дунд сургуулийн сурагч жаахан охин жинхэнэ улс төрийн зүтгэлтэн шиг олон улсын арга хэмжээнд оролцож ярилцлага өгч, дугуй ширээний ярилцлагад үг хэлж, мусульман хүүхдүүдэд туслах сан байгуулж, хөтөлбөр боловсруулж, түүнийгээ удирдан зохион байгуулж байна.

Сэдэв 2. Зөрчлийг энх тайвнаар шийдвэрлэх нь



ЗОРИЛГО

Суралцагчдын дунд зөрчил, түүний мөн чанарын тухай хэлэлцүүлэх замаар зөрчлийг шийдвэрлэх энх тайванч, үл хүчирхийлэл бүхий “хожил-хожил шийдэл” ба эвлэрлийг эрхэмлэх хандлага төлөвшүүлэх



ТҮЛХҮҮР ҮГ, ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

- **Зөрчил:** Зөрчил нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн санал бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм (Росс Стингер, 1967). Хүмүүс хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг.
- **Зөрчлийн шалтгаан:** Зөрчил нь нөөц боломжийн хомдслоос гадна, зөрчилдөж буй талуудын хэрэгцээ хангагдаагүй байх, эсвэл хүмүүс хоорондын ялгаатай байдлаас үүсэн бий болдог гэж үздэг.
- **Зөрчлийн гүнзгийрэл:** Хүмүүс хооронд үүссэн аливаа зөрчлийг шийдвэрлэхгүй бол улам гүнзгийрдэг. Хүмүүст зөрчлийг эхэн үед нь шийдвэрлэх ур чадвар дутагдснаас зөрчил нь улам бүр гүнзгийрч хүндэрдэг. Харин зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэснээр харилцаа холбоо сайжирч, өсөлт хөгжил бий болдог.
- **Зөрчлийн үед хүмүүсийн гаргадаг хариу үйлдэл:** Зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэрэг сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайвны арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сэргэлдэгч талууд бие биенийхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.

- **Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг арга барил:** Хүмүүс зөрчлийн үед тодорхой арга барилыг хэрэглэж хэвшсэн байдаг. Нэгэнт хэвшин тогтсон учир өөрсдийгөө тухайн арга барилыг хэрэглэдэг гэдгээ тэр бүр мэддэггүйгээс болж өөрийгөө зөвтгөх, бусдыг буруутгах хандлагатай байдаг байна. Иймд зөрчлийг шийдвэрлэхэд чухал нэг алхам нь хүмүүс өөрсдийн байнга хэрэглэдэг арга барилаа танин мэдэж, зөрчлийн үед тухайн арга барилыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэх талаар тунгаан бодох явдал юм. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг түгээмэл арга барилуудыг дараах таван амьтнаар төлөөлүүлэн тайлбарласан байдаг.
 1. Яст мэлхий: Зөрчлийн үед өөрийн байр суурийг илэрхийлж, бусдын байр суурийг сонсох замаар зөрчлийг шийдвэрлэх гэж хичээхээс илүү зөрчлийг үл хайхарч, зөрчилт байдалд орохоос зугатан зайлахыг эрмэлздэг. (Зайлсхийх арга барил)
 2. Баавгай: Зөрчлийн үед үүссэн асуудлыг шийдвэрлэхээс илүү харилцаагаа хадгалахыг эрмэлздэг. Зөрчилт нөхцөл байдлыг орхиж, аяндаа шийдэгдэхээр үлдээдэг. (Зохицох арга барил)
 3. Үнэг: Зөрчлийг аль болох зохицуулахыг эрмэлздэг. Зөрчил гэдэг нь харилцан хоёр тал байр сууриа өөрчлөх замаар буюу өгч, авах замаар шийдвэрлэх боломжтой зүйл гэж үздэг. (Зохицуулах арга барил)
 4. Шар шувуу: Дундын шийдлийг олохыг эрмэлздэг. Зөрчлийг шийдвэрлэхийн тулд цаг зав, хүчин чармайлт гаргадаг. Харилцаанд ач холбогдол өгөхийн хамт зөрчилтэй асуудлыг шийдвэрлэхийг хичээдэг.
 5. Аварга загас/Арслан: Зөрчилтэй шууд нүүр тулдаг. Өөрийн байр сууриа хүчтэй илэрхийлж, өөрийнхөө зүтгэж дайрах байдлаар зөрчлийн үед ялахыг эрмэлздэг. (Өрсөлдөх арга барил)
- Зөрчлийг шийдвэрлэх боломжит дөрвөн шийдэл байдаг. Зөрчилдөж буй хоёр талыг А ба Б тал гэж нэрлэвэл тэдний дунд үүссэн зөрчил нь дараах дөрвөн хувилбарын аль нэгээр шийдэгдэж болно.

	<u>А</u>	<u>Б</u>
1.	Хожил	Хожигдол
2.	Хожигдол	Хожил
3.	Хожигдол	Хожигдол
4.	Хожил	Хожил



ДААЛГАВАР 2.1



Ажиллах заавар:

Хэрвээ би амьтан бол



1. Би ямар амьтантай төстэй вэ? хэрэглэгдэхүүнийг хүүхэд бүрт тараан өгч ажиллуулна.
 - Хэрэглэгдэхүүн 1. Хүүхэд тус бүр хэрэглэгдэхүүний эхний баганад өгөгдсөн амьтны зан араншин, арга барилын талаарх тайлбарыг уншаад арын гурван баганад өгөгдсөн хариултаас аль тохирохыг сонгон дугуйлахыг хүснэ. Бүх хүүхдүүд дасгалыг ажилласны дараа өөрийгөө ямар амьтантай төстэй гэдгээ, мөн ямар амьтантай огт төсгүй гэдгээ олж мэдсэн үү гэж асууна. Хүүхдүүд өөрсдийгөө нэг дор 2 ба 3 амьтантай төстэй гэж хэлсэн бол тэдгээр амьтдын араншингийн талаарх мэдээллийг сайтар уншиж байгаад дахин аль амьтантай өөрийгөө илүү төстэй гэж бодож буйгаа сонгохыг сануулна.
 - Хэрэглэгдэхүүн 2. Зөрчлийн үед амьтдын баримталдаг арга барил болох өрсөлдөх, зөвшилцөх, зайлсхийх, зохицох, зохицуулах арга барилын тухай тайлбарлаж өгнө.
 - Хэрэглэгдэхүүн 3. Өрсөлдөх арга барилыг түлхүү хэрэглэх хандлагатай өөрсдийгөө аварга загастай төстэй гэж үзсэн хүүхдүүд зөрчлийг шийдвэрлэхдээ дараах зөвлөмжийг дагаарай гэж хэлээд хүснэгтэд өгөгдсөн зөвлөмжийг танилцуулна.

Даалгавар

Хүүхэд бүрд хүснэгтийн арын гурван баганад өгөгдсөн хариултын аль тохирох нүдийг сонгож бөглөхийг хүснэ.

Хэрэглэгдэхүүн 1. Би ямар амьтантай төстэй вэ?

Амьтад ба тэдний арга барил		Хариулт		
		Би энэ амьтантай адилхан	Би зарим талаар энэ амьтантай адилхан	Би энэ амьтантай огт адилгүй
 Аварга загас	Өөрийн санаа, үзэл бодол, байр суурийг бусдад тулгадаг. Бусдыг өөртэйгээ адил байхыг шаарддаг. Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо хамгаалахын төлөө тууштай байдаг. Өөрийн зөв гэдгийг бусдад ойлгуулах, итгүүлэхийг хичээдэг.	☐	☐	☐

 Шар шувуу	Бүх асуудлыг ил тод ярилцах дуртай. Нээлттэй харилцахыг эрмэлздэг. Үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг.	☐	☐	☐
 Үнэг	Шударга байдал бол хамгийн чухал зүйл юм. Зөрчлийн үед харилцан буулт хийх нь чухал. Аль аль талыг харгалзан үзсэн шийдвэр гаргах ёстой.	☐	☐	☐
 Баавгай	Хүмүүсийг байлдан дагуулдаг. Эелдэг, найрсаг байснаар хүмүүст нөлөөлнө гэж үздэг. Харилцаагаа сайжруулах нь чухал, шийдэл аяндаа олдоно гэж үздэг.	☐	☐	☐
 Яст мэлхий	Хүмүүстэй халз тулж зөрчилдөхөөс зайлсхийдэг. Маргалдаж мэтгэлцэх дургүй. Бусдыг хүссэн зүйлээ гүйцэлдүүлэхийг зөвшөөрөх хандлагатай.	☐	☐	☐
		☐	☐	☐

Үе тэнгийн сургагч хүүхэд амьтан тус бүрийн арга барилын мэдээлэлд үндэслэн зөрчлийн үеийн таван арга барилыг тайлбарлана.

Хэрэглэгдэхүүн 2. Зөрчлийн үеийн арга барил

Амьтад ба тэдний арга барил		Зөрчлийг шийдвэрлэх тактик
	Өөрийн санаа, үзэл бодол, байр суурийг бусдад тулгадаг Бусдыг өөртэйгээ адил байхыг шаарддаг. Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо хамгаалахын төлөө тууштай байдаг. Өөрийн зөв гэдгийг бусдад ойлгуулах, итгүүлэхийг хичээдэг.	Өрсөлдөх
	Бүх асуудлыг ил тод ярилцах дуртай. Нээлттэй харилцахыг эрмэлздэг. Үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг.	Зөвшилцөх

	Шийдэл хайж олохыг эрмэлздэг. Шударга байдал бол хамгийн чухал зүйл юм. Буулт хийх ба хуваалцах нь гол түлхүүр гэж үздэг. Аль аль талыг харгалзан үзэх ёстой.	Зохицуулах
	Хүмүүсийг байлдан дагуулдаг. Эелдэг, найрсаг байснаар хүмүүст нөлөөлнө гэж үздэг. Харилцаагаа эхэлж сайжруул. Шийдэл аяндаа олдоно гэдэг дүрэмтэй.	Зохицох
	Халз тулсан нөхцөл байдлаас зайлсхийдэг. Маргалдаж мэтгэлцэх дургүй бөгөөд цаг барсан дэмий зүйл гэж үздэг. Бусдыг хүссэн зүйлээ авахыг зөвшөөрөх хандлагатай.	Зайлсхийх

Үе тэнгийн сургагч амьтан тус бүрийн арга барилын давуу ба сул талын тухай тайлбарлан, хэлэлцүүлэг өрнүүлсний даараа тухайн арга барилд тохирсон зөвлөмжийг хүүхдүүдэд тайлбарлаж өгнө.

Хэрэглэгдэхүүн 3. Зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэхэд зориулсан хүмүүсийн арга барилд хандсан зөвлөмж

Өрсөлдөх	- Зөрчилдөөний үед өөрийн санаа, үзэл бодол, байр суурийг бусдад тулгахаас илүү нөгөө талынхаа үзэл бодол, байр суурийг сонсож ойлгохыг хичээгээрэй. - Бусдыг өөртэйгээ адил байхыг шаардаж болохгүй юм. Хүн бүр өөрийн онцлогтой.
Зөвшилцөх	Бүх асуудлыг ил тод ярилцах дуртай чинь сайн байна. Нээлттэй харилцахыг эрмэлздэг. Үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг зан чанар чинь зөрчлийг шийдвэрлэхэд маш чухал юм.
Зохицуулах	- Шийдэл хайж олохыг эрмэлздэг нь зөрчилдөөнийг шийдвэрлэхэд хэрэгтэй зүйл юм. - Шударга байхыг ханддаг чинь сайн. Зөрчлийн үед буулт хийхээсээ өмнө буулт хийх үндэслэлтэй шалтгаан байгаа эсэхийг тунгаан бодоорой.
Зохицох	Заримдаа хэт найрсаг зан гаргаснаас болж өөрөө хохирч үлдэх гээд байдаг талтай тул өөрчлийн үед аль болох баримт нотолгоонд суурилж, өөрийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлэхийг хичээгээрэй.
Зайлсхийх	Зөрчлөөс дандаа зайлсхийж болохгүй. Зөрчлийг шийдвэрлэнэ гэдэг нь маргалдаж хэрэлдэнэ гэсэн үг биш бөгөөд энэ үед өөрийгөө зоригтой илэрхийлж байх хэрэгтэй. Бусдыг хүссэн зүйлээ авахыг зөвшөөрөх хандлагаа өөрчлөхийг хичээгээрэй.



ДАААЛГАВАР 2.2



Ажиллах заавар:

Зөрчлийн шийдэл үү гүнзгийрэл үү?

1. Үе тэнгийн сургагч хэрэглэгдэхүүн 4-д өгөгдсөн зөрчлийн хариу үйлдлийн картыг нэг нэгээр хүүхдүүдэд тараан өгнө.
2. Хүүхдүүдийн дунд дараах жишээг уншиж өгнө.
... Зургийн хичээл ороод хүүхдүүд дор бүрнээ тун завгүй зургаа зурж байлаа. Гэтэл ангийн нэг хүүхэд ширээн дундуур явахдаа санамсаргүйгээр өөр нэг хүүхдийн ширээн дээр байсан будагны усны савийг унагааж тэр хүүхдийн зурж байсан зургийг баллаж орхив.”
3. Үе тэнгийн сургагч хүүхдүүдийг өөрт оногдсон карт дээрх харилцан яриаг бусад хүүхдэд уншиж өгөн, тухайн харилцан ярианы агуулга, үг хэллэг нь зөрчлийг гүнзгийрүүлэх үү, эсвэл эерэгээр шийдвэрлэх үү гэдэг асуултын аль нэгэнд хариулахыг хүснэ. Ийм маягаар карт авсан хүүхэд бүр картын харилцан яриаг уншиж өгөн өөрийн хариултаа хэлэх маягаар ямар харилцан яриа, үг хэллэг зөрчлийг гүнзгийрүүлж, ямар харилцан яриа, үг хэллэг ашиглавал зөрчил үр дүнтэй шийдвэрлэгддэг талаар хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ.
 - Хэрэглэгдэхүүн 5. Зөрчлийн үед ярилцах дүрмийг хүүхдүүдэд тайлбарлан танилцуулна.
 - Хэрэглэгдэхүүн 6. “Ярианы шүүлтүүр”-ийн аргын тухай хүүхдүүдэд тайлбарлан өмнөх хэсэгт ажилласан зөрчлийн хариу үйлдлийн картуудын зарим харилцан яриаг “ярианы шүүлтүүр”-ийн аргаар засах даалгавар өгнө. Жишээ нь Чи дандаа анхаарал болгоомжгүй байх юмаа, Чи намайг дандаа буруутгадаг гэсэн үг хэллэгт “ярианы шүүлтүүр”-ийн аргаар дүн шинжилгээ хийж ярилцана.
4. Хүүхэд бүрд “ярианы шүүлтүүр”-ийн аргын тухай материалыг хэвлэн өгч, гэрийнхээ аль нэг хэсэгт нааж өөрийнхөө үг хэллэг, харилцаагаа засаж сайжруулахад ашиглаарай гэсэн зөвлөмжийг өгнө.

Даалгавар

Хэрэглэгдэхүүн 4. Зөрчлийн хариу үйлдлийн карт

Эелдгээр хэлэх “Яанаа намайг уучлаарай.” “Зүгээр дээ!”	Тохиролцох “Дараагийн удаа анхаарал болгоомжтой байгаарай” “Тэгье ээ. Дараагийн удаа анхаарал болгоомжтой байх болно”
☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ ☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.	☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ ☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.
Хэн нэг нь сэтгэл дундуур байгаагаас үүдсэн санал зөрөлдөөн “Чи юу хийснээ хар даа!” “Би ингээгүй шүү дээ!”	Хэтрүүлэх “Чи дандаа анхаарал болгоомжтой байх юм аа” “Чи/Та намайг байнга л буруутгадаг”
☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ ☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.	☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ ☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.
Өмнө нь болж байсан зүйлийг сөхөх “Чи урьд нь бас миний ажлыг баллаж байсан.” “Өнгөрсөн 7 хоногт чи ямар ч шалтгаангүй бас ингээд байсан биз дээ.”	Өөрийгөө яагаад ийм зүйл хийж байгаа учир шалтгаанаа тайлбарлах “Миний ажил чинийхээс чухал учраас чи атаархаж байна.” “Чи өөрийгөө бүхнээс дээгүүр/мундаг гэж боддог.”
☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ ☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.	☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ ☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

Заналхийлэх

“Хэрвээ чи дахиад ингэвэл би чиний юмыг сүйтгэх болно”

“Би чамаас илүү дээр найзтай болох хэрэгтэй юм байна.”

- ☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ
☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

Хувь хүн рүү дайрах

“Чи бол ухаан муутай амьтан ш дээ”

“Чи бол амиа бодсон амьтан ш дээ.”

- ☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ
☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

Бусад хүмүүсийн хэлсэн/хийсэн зүйлийг хэлэх

“Хүмүүс чамайг ухаан муутай гээд байдаг. Үнэн юм байна.”

“Хүмүүс даанч чамайг ийм ааштай гээд байсан юм аа.”

- ☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ
☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

Сөрөг дүгнэлт хийх

“Би чамайг үзэн ядаж байна.”

“Би чаашид чамтай найзлахаа болилоо.”

- ☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ
☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

Тунгаан ярилцах

“Миний ч бас буруу боллоо. Би ширээгээ цэгцлэх ёстой байж.”

Өөрийн алдааг хүлээн зөвшөөрөх

“Би бас анхаарал болгоомжгүйгээс болоод чиний юмыг баллачихлаа.”

- ☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ
☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

“Дахиад ийм байдалд орохгүйн тулд юмандаа эмх цэгцтэй байх ёстой юм байна.”

“Харин тийн. Би бас анхаарал болгоомжтой явах ёстой юм байна.”

- ☐ Зөрчлийг гүнзгийрүүлнэ
☐ Зөрчлийг шийдвэрлэнэ.

Хэрэглэгдэхүүн 5. Зөрчлийн үед ярилцах дүрэм: “Ярилцъя”

ХАМТДАА ЯРИЛЦЬЯ

Би ярих гэж байгаа хүн рүүгээ хандаж, тэр намайг анхаарч сонсох эсэхийг анзаарна.

Хэрвээ тэр намайг буруу ойлгосон гэж бодож байвал би түүнээс юу сонссоноо өөрийн үгээр хэлэхийг хүснэ.

Би түүн рүү дайрахгүй, Хэл амаар доромжлохгүй.


Би хариултаа хэлэхийн өмнө сонсоно.

Би өөрийн санаа бодлоо боловсон үг хэллэгээр илэрхийлнэ.

Би өөрийн хэлсэн үгэндээ хариуцлага хүлээнэ.

Хэрвээ би ярилцах явцдаа бусдыг гомдоосон бол уучлалт хүснэ.

Хэрэглэгдэхүүн 6. Ярианы шүүлтүүрийн арга





ДАААЛГАВАР 2.3.



Ажиллах заавар:

Зөрчлийн үеийн “Хожил-хожил шийдэл”

“Хоёр морины түүх сургамжит өгүүллэг”-Энэ түүхийг аудио хэлбэрээр хүүхдүүдийг сонсоход зориулж хүүрнэнэ.

Даалгавар (Хүүрнэл)

Эрт урьдын цагт 2 морь байжээ. Тэднийг нэг удаа саравчинд хооронд нь уяатай байлгаж байлаа. Эзэн нь өвс тавьж өгөөгүй, мөн уяатай учраас гадагшаа гарч бэлчээрлэх боломжгүй учир хоёр морь нэлээн өлсөж ундаасаж гэнэ.

Тэгж байтал малчин тэдэнд зориулан саравчинд хоёр хэсэг газар өвс тавьж өгөв. Эхний хэсэг өвсийг нэг моринд нөгөө хэсэг өвсийг хоёр дахь моринд ойрхон газар тавьжээ.

Хоёр морь хоёулаа өөр өөрсдөд нь тавьж өгсөн өвсийг идэх гэсэн боловч хоорондоо уяатай тул өөрсдийн өвсөнд хүрч чадсангүй гэнэ. Хоёр тийшээ тэмүүлсээр хамаг чадлаа барж, нүдэнд нь харагдаж буй өвсөндөө хүрч чадахгүй болохоор бүр их өлсөж, уур нь хүрцгээж гэнэ.

Ингээд хоёр морь тус бүрд нь идэх өвс байсан ч өвсөндөө хүрч чадахгүй байдалд орлоо.

Хоёр морь юу хийж чадах вэ? (Суралцагчдаас хоёр морь ийм нөхцөлд юу хийж болохыг асууна. Хоёр морь хамтран ажиллаж, эхлээд нэг нь өвсөө дараа нөгөө нь өвсөө идэх хэрэгтэй гэсэн санаа гарч ирэхийг хүлээнэ.)

Дараа нь хоёр морь ярилцаж, өвсөө хамтарч идэх шийдэлд хүрэв. Тэд хамтдаа эхлээд нэг талд тавьсан өвсөө идэв. Тэднийг хооронд нь холбосон уяа идэхэд нь огт саад болсонгүй. Эхний өвсөө идэж дууссаны дараа нөгөө талын өвсийг эв найрамдалтайгаар идэв. Хоёр морины өлсгөлөн гэдэс цадаж аз жаргалтай болов гэнэ. Хоёр морь ийнхүү харилцан ашигтай “хожил-хожил” шийдэлд хүрчээ.

Үлгэр өөрөөр төгсөж болох байсан уу? Тиймээ.

Энэ түүх өөрөөр төгсөж болох байлаа. Хоёр морь хоёулаа эсвэл аль нэг нь гэдэс хоосон өлсгөлөн үлдэж болох байлаа.

- Магадгүй хоёр морь хоолныхоо төлөө тулалдаж, хоёулаа хоолгүй хоцрох “хожигдол-хожигдол”
- Аль хүчтэй нэг морь нь өвсөндөө хүрч нөгөө морио идүүлэхгүй байх “хожил-хожигдол”

- Тэд хоёул өөрсдийн өвсөнд хүрэх гэж 2 тийшээ тэмүүлсээр хоёулаа ядарч аль нь ч өвсөндөө хүрч чадахгүй үлдэх “хожигдол-хожигдол” гэсэн гурван боломжит шийдэл байлаа. Гэхдээ энэ гурван шийдэл гурвуулаа үр дүнгүй шийдэл юм.

Хоёр морь хоёулаа өвсөө идэж аз жаргалтай байхад хүргэсэн гол нөхцөл юу байсан бэ гэхээр “хожил-хожил” шийдэл байлаа.

Энэ хоёр моринд тохиолдсон шиг зөрчил бол хүний амьдралын нэг хэсэг юм. Хамгийн чухал нь зөрчил маргааныг хэрхэн зохицуулахад оршдог. Энэ түүхэнд гарсан хоёр морь шиг өөр өөрсдийнхөөрөө зөрүүдлэн зүтгэвэл зөрчилдөж, маргалдаж буй хоёр тал хоёулаа хохирдог. Үүний оронд харилцан ашигтай шийдлийг хайж олох ёстой.

Хоёр морь “хожил-хожил” шийдэлд хүрэхийн тулд юу хийсэн бэ? гэж асууна.

Тэд бие биенээ ойлгож, хамтран ажилласны үр дүнд аль аль нь гэдэс цатгалан болсон байна. Энэ үед хоёр морь зөрчлийн үед “хожил-хожил” шийдэлд хүрчээ.





ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ, СОРИЛ



1. Хүмүүс хоорондын зөрчил үр дүнтэй шийдвэрлэгдэх эсвэл гүнзгийрч хурцдах эсэх нь хүмүүсийн хэрэглэдэг арга барил, хандлагаас их хамаардаг.
 1. Тийм
 2. Үгүй
2. Дараах хандлагуудын аль нь зөрчлийг шийдвэрлэхэд эерэгээр нөлөөлөх вэ?
 1. Өрсөлдөх
 2. Зөвшилцөх
 3. Зохицуулах
 4. Зохицох
 5. Зайлсхийх
3. Хүмүүсийн зөрчлийн үед аль болох зөрчилдөхгүйг хичээж, бууж өгөхийг урьтал болгох нь зөрчлийн үеийн ямар хариу үйлдэл вэ?
 1. Зөөлөн хариу үйлдэл
 2. Хатуу хариу үйлдэл
 3. Энх тайванч хариу үйлдэл
4. Зөрчилдөж буй талууд бие биенийхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх нь дараах арга замуудын аль нь вэ?
 1. Зөөлөн хариу үйлдэл
 2. Хатуу хариу үйлдэл
 3. Энх тайванч хариу үйлдэл
5. Зөрчлийн үед зөвхөн өөрийн байр сууриндаа бат хатуу зогсож, нөгөө талын байр суурь, үзэл бодлыг няцаах байдлаар эсэргүүцэх хандлага нь дараах арга замуудын аль нь вэ?
 1. Зөөлөн хариу үйлдэл
 2. Хатуу хариу үйлдэл
 3. Энх тайванч хариу үйлдэл
6. Зөрчлийн үед эрх мэдэл, хүч чадлаар давуу тал нь өөрийн үзэл бодлоо тулган хүлээлгэснээр зөрчлийг шийдвэрлэж байвал энэ нь дараах шийдлүүдийн алинд хамаарах вэ?
 1. Хожил – хожил
 2. Хожил – хожигдол
 3. Хожигдол-хожигдол
7. Зөрчлийн үед зөрчигдөгч талууд бие биенээ огт сонсохгүй байснаар олдсон боломжийг хоёулаа алдаж байвал энэ нь дараах шийдлүүдийн алинд хамаарах вэ?
 1. Хожил-хожил
 2. Хожил-хожигдол
 3. Хожигдол-хожигдол



НЭМЭЛТЭЭР УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛ



ЗӨРЧИЛ

Нийгэм хөгжихийн хэрээр хүмүүс хоорондын харилцаанд зөрчил улам бүр нэмэгдэх хандлага ажиглагдах болсон. Энэ нь хүмүүс хоорондын ялгаатай байдал нэмэгдэж байгаатай зарим талаар холбоотой. Иймд зөрчлийг ойлгож, түүнийг хүчирхийлэлгүйгээр, үр дүнтэй шийдвэрлэх чадвар хүмүүс бидэнд чухал болж байна.

Росс Стингер (1967)-ийн тодорхойлсноор зөрчил нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн санал бодол, байр суурийн зөрүүтэй байдал юм. Хүмүүс хоорондын зөрчилд тухайн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна хүмүүсийн хандлага, зан үйл нөлөөлдөг.

- Нөхцөл байдал:
 - зөрчилдөгч талууд бие биенийгээ дундын ашиг сонирхолтой гэж харахаас илүү өрсөлдөгч байр сууринд байх
- Хандлага:
 - Үзэн ядах, айх хандлагатай байх
- Зан үйл:
 - Заналхийлэх, эсэргүүцэх, дайрах, амиа хичээх зан үйл гаргах

Зөрчлийн шалтгаан. Зөрчил нь нөөц боломжийн хомдслоос гадна, зөрчилдөж буй талуудын хэрэгцээ хангагдаагүй байх, эсвэл талуудын ялгаатай байдлаас үүсэн бий болдог гэж үздэг.


- Зөрчил нь юуны өмнө хүмүүсийн дундын нөөц боломж хомс байдгаас зөрчил үүсдэг. Жишээ нь ангид хорин хүүхэд байхад дунд нь 10 зүсэм торт авчирлаа гэж бодье. Хүүхэд бүхэн тортноос идэхийг хүсэх ч торт хүүхэд бүрт хангалтгүй тул хүүхдүүд өрсөлдсний улмаас зөрчил үүсч болно. Нөөц боломж хомс, хязгаарлагдмал байдаг. Тухайлбал: цаг хугацаа, мөнгө, эд хөрөнгө зэрэг жишээ дурдаж болно.
- Зөрчил үүсгэдэг дараагийн шалтгаан нь хүний хэрэгцээ хангагдахгүй байх явдал юм. Хүн бүрд үндсэн хэрэгцээ бий. Тухайлбал: бид бүгд эрүүл саруул байх хэрэгтэй, эрх чөлөөтэй байх хэрэгцээтэй. Гэвч хүний үндсэн хэрэгцээ хангагдахгүй, эсвэл бид үндсэн хэрэгцээгээ хангах боломжгүй байх үед хүмүүс зөрчилддөг.
- Зөрчил үүсгэдэг гурав дахь шалтгаан бол бид бүхэн өөр өөр бодолтой, өөр хүсэл сонирхолтой байдаг явдал юм. Бидний зарим нь газар зүйн хичээлд дуртай байхад, зарим нь биеийн тамирын хичээлд дуртай байдаг. Хүмүүс өөр өөр ёс уламжлалтай байж болно. Зарим нь гараараа хоолоо

барьж иддэг байхад зарим нь заавал халбага сэрээгээр иддэг гэх мэт. Хүмүүс хоорондын ялгаатай байдлын улмаас харилцах үед тэдгээрийн үзэл бодол, шашин шүтлэг, соёл мөргөлдснөөс болж хүмүүс хоорондоо зөрчилддөг. Энд дарж хүмүүс бид аливаа юмсыг өөр өөрөөр хардаг талаар тайлбарлахад хэрэглэх нэмэлт материал харна уу

Зөрчлийн зарим шалтгаан	Хязгаарлагдмал нөөц	Цаг хугацаа Хөрөнгө мөнгө Эд баялаг
	Хангагдаагүй хэрэгцээ	Харьяалагдах хэрэгцээ Эрх мэдэлтэй байх Эрх чөлөөтэй байх Чөлөөт цагаа өнгөрөөх
	Хүмүүс хоорондын ялгаатай байдал	Хүсэл сонирхол Зан заншил Үнэт зүйл Итгэл үнэмшил

Зөрчлийн гүнзгийрэл. Хүмүүс хооронд үүссэн аливаа зөрчлийг шийдвэрлэхгүй бол улам гүнзгийрдэг. Зөрчил яагаад гүнзгийрдэг талаар эргэцүүлье.

- Хүмүүст зөрчлийг эхэн үед нь шийдвэрлэх ур чадвар дутагдснаас зөрчил нь улам бүр гүнзгийрч хүндэрдэг. Харин зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэснээр өөртөө итгэх итгэл нэмэгдэж, харилцаа холбоо сайжирч, өсөлт хөгжил бий болдог.
- Зөрчлийн үед үүсдэг мэдрэмж хүнийг тавгүй байдалд оруулдаг. Үүнтэй холбоотой зарим хүмүүс зөрчилдөхөөс зайлсхийх улмаар аль болох зөрчилдөхгүйг хичээх хандлагатай болдог. Зөрчил гүнзгийрэх нь айдас түгшүүр, эргэлзээ тээнэгэлзэл, гомдол, үзэн ядалт зэрэг сөрөг сэтгэл хөдлөлд хөтөлдөг. Гэхдээ хүн зөрчилтэй нөхцөлд тухайн үүссэн асуудалд сэтгэл хөдлөлөөр хандахаас илүү оюун ухаанаар хандаж бэрхшээл гэхээсээ түүнийг сорилт гэж харан сөрөг биш эерэг талаас харж сурах хэрэгтэй.
- Зөрчилтэй тулгарах үед хүмүүсийн гаргадаг түгээмэл хандлага бол аль болох нөгөө талаа ялан дийлэхийг хичээх явдал байдаг. Ингэснээр нөгөө талын хүн ч гэсэн ялан дийлэхийг хичээсэн арга барилыг хэрэглэдэг. Зөрчлийг шийдвэрлэхэд улам бэрх болгодог хүмүүс бидний үг яриа, хандлагын зарим жишээг энд (Нөөц хэрэглэгдэхүүн 8) дарж уншина уу.



Зөрчлийн үед хүмүүсийн гаргадаг хариу үйлдлийг зөөлөн, хатуу, энх тайванч гэж ангилсан байдаг. Зөөлөн хариу үйлдэл нь аль болох зөрчилдөхгүйг хичээж, зөрчилдсөн үед бууж өгөх, эсвэл үл ойшоох маягаар хандахыг хэлнэ. Харин зөрчлийн үед эсрэг хариу үйлдэл үзүүлж, үг яриа, үйл хөдлөлөөр эсэргүүцэхийг хатуу хариу үйлдэл гэнэ. Зөрчлийн үеийн зөөлөн ба хатуу хариу үйлдэл нь зөрчлийг шийдвэрлэхээсээ илүү хурцатгах, эсвэл гүнзгийрүүлэх зэргээр сөрөг үр дагавар ихтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор зөрчлийг энх тайван арга замаар шийдвэрлэх хариу үйлдэл чухал болж байна. Энэ нь сөргөлдөгч талууд бие биенийнхээ байр суурийг анхааралтай сонсох, ойлгох замаар тодруулах, хүндэтгэх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх, дундын шийдэл дээр хэлэлцэх, харилцан тохиролцох арга замаар зөрчлийг шийдвэрлэхийг хэлнэ.

Зөөлөн хариу үйлдэл	Аль болох зөрчилдөхгүйг хичээх Зөрчлөөс зайлсхийх Зөрчил байгааг үгүйсгэх Зөрчилд бууж өгөх
Хатуу хариу үйлдэл	Хэл амаар доромжлох Бие махбодын хүчирхийлэл (Түлхэх, нударх, цохих)


Энх тайванч хариу үйлдэл	Тодруулах: • Анхааралтай сонсох • Ойлгох Хүндэтгэх • Өөр үзэл бодолтой байгааг нь хүлээн зөвшөөрөх Шийдвэрлэх • Дундын шийдлийг олох Бүтээх, санаачлах • Шинэ арга замыг хайж олох, нээх илрүүлэх Хүчирхийлэл үл хэрэглэн өөрийн байр сууриндаа бат зогсох
--------------------------	--

Хүснэгт 1. Зөрчилд хариу үйлдэл үзүүлэх арга замууд (эх сурвалж: Richard J.Bodine, Donna K.Crawford, Fred Schrumph, *Creating the Peaceful school*, Research Press, Illinois, 1994, р34)

Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг арга барил

Хүмүүс зөрчлийн үед тодорхой арга барилыг хэрэглэж хэвшсэн байдаг. Нэгэнт хэвшин тогтсон учир өөрсдийгөө тухайн арга барилыг хэрэглэдэг гэдгээ тэр бүр мэддэггүйгээс болж өөрийгөө зөвтгөх, бусдыг буруутгах хандлагатай байдаг байна. Иймд зөрчлийг шийдвэрлэхэд чухал нэг алхам нь хүмүүс өөрсдийн байнга хэрэглэдэг арга барилаа танин мэдэж, зөрчлийн үед тухайн арга барилыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэх талаар тунгаан бодох явдал юм. Зөрчлийн үед хүмүүсийн хэрэглэдэг түгээмэл арга барилуудыг дараах таван амьтнаар төлөөлүүлэн тайлбарласан байдаг.

1. Яст мэлхий: Зөрчлийн үед өөрийн байр суурийг илэрхийлж, бусдын байр суурийг сонсох замаар зөрчлийг шийдвэрлэх гэж хичээхээс илүү зөрчлийг үл хайхарч, зөрчилт байдалд орохоос зугатан зайлахыг эрмэлздэг. (Зайлсхийх арга барил)
2. Баавгай: Зөрчлийн үед үүссэн асуудлыг шийдвэрлэхээс илүү харилцаагаа хадгалахыг эрмэлздэг. Зөрчилт нөхцөл байдлыг орхиж, аяндаа шийдэгдэхээр үлдээдэг. (Зохицох арга барил)
3. Үнэг: Зөрчлийг аль болох зохицуулахыг эрмэлздэг. Зөрчил гэдэг нь харилцан хоёр тал байр сууриа өөрчлөх замаар буюу өгч, авах замаар шийдвэрлэх боломжтой зүйл гэж үздэг. (Зохицуулах арга барил)
4. Шар шувуу: Дундын шийдлийг олохыг эрмэлздэг. Зөрчлийг шийдвэрлэхийн тулд цаг зав, хүчин чармайлт гаргадаг. Харилцаанд ач холбогдол өгөхийн хамт зөрчилтэй асуудлыг шийдвэрлэхийг хичээдэг.
5. Аварга загас/Арслан: Зөрчилтэй шууд нүүр тулдаг. Өөрийн байр сууриа хүчтэй илэрхийлж, өөрийнхөө зүтгэж дайрах замаар зөрчлийн үед ялахыг эрмэлздэг. (Өрсөлдөх арга барил)



Зөрчлийг шийдвэрлэх боломжит дөрвөн шийдэл байдаг. Зөрчилдөж буй хоёр талыг А ба Б тал гэж нэрлэвэл тэдний дунд үүссэн зөрчил нь дараах дөрвөн хувилбарын аль нэгээр шийдэгдэж болно.

	<u>А</u>	<u>Б</u>
1.	Хожил	Хожигдол
2.	Хожигдол	Хожил
3.	Хожигдол	Хожигдол
4.	Хожил	Хожил

Дээрх хувилбараас харахад 1 ба 2 дугаар хувилбарт хоёр талын аль нэг нь нөгөөгөө ялан дийлж байгаа нь харагдаж байна. Харин 3 дугаар хувилбарт зөрчилдөж буй хоёр тал хоёулаа хожигдож байна. Хоёр хүүхэд хоорондоо хэрэлдэж муудснаас болж тэд багш, эцэг эх, асран хамгаалагчдаа зэмлүүлж байгаа тохиолдол нь гурав дахь хувилбар юм. Эдгээр шийдвэрээс 4 дэх хувилбар нь зөрчлийг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй, оновчтой хувилбарт тооцогддог. Хоёр тал хоёулаа хожихийн тулд бие биенээ сонсож, өөр өөрсдийн хатуу байр сууринаас ухарч дундын шийдэлд хүрэх ёстой гэж үздэг.

Үр дүн	Ойрын үр дагавар	Урт хугацааны үр дагавар
Хожигдол- Хожигдол	Асуудал шийдвэрлэгдэхгүй үлдэнэ. Бие биетэйгээ ярихаа болино. Уур бухимдал хуримтлагдана. Бие биенээ буруутгасаар байна.	Гомдол бухимдал хуримтлагдана. Өөрийгөө өмөөрөх, хамгаалах байр сууринд шилжинэ. Эсрэг тэсрэг байр суурьтай болно. Уур бухимдлаа барьж дийлэхгүй тэсэрнэ. Өшөө хорсол, өшөө авалт, хүчирхийлэл, тулаанд хүрнэ.
Хожил – хожигдол	Хожсон тал хүч чадлаа мэдэрч, үеийнхэнтэйгээ баяр хөөрөө хуваалцана. Хожигдсон тал суларч, доройтож, өөртөө итгэлгүй болж үеийнхэндээ гадуурхагдана. Өрсөлдөөнт уур амьсгал бүрэлдэнэ.	Цаашид өөрийн хувийн сонирхлоо хангахад эрх мэдлийг ашигладаг болно. Дарамт шахалт, шударга бус байдал улам нэмэгдэнэ. Харилцан дайсагнал нь хүчирхийллийг өдөөж, үймээн самуун бий болно.
Хожил-хожил	Аль аль талын үндсэн хэрэгцээ хангагдана. Хоёр талын нөөц бололцоогоо хуваалцана.	Харилцан ойлголцол, хамтын ажиллагаа нэмэгдэнэ. Бие биенээ хүндэтгэсэн уур амьсгал бүрэлдэн тогтоно. Илүү сайн сайхан санаа, шийдэл гарна. Шударга ёсыг эрхэмлэсэн, энх тайванч уур амьсгал бүрэлдэн тогтоно.

Зөрчлийг бүтээлчээр, үр дүнтэй шийдвэрлэхийн тулд дараах зүйлийг анхаарах нь чухал:

- Сөрөг сэтгэл хөдлөлөө хянах
- Идэвхтэй сонсох
- Тодорхой ярих
- Бусдын хэрэгцээ, асуудал, бэрхшээл, хариу үйлдлийг ойлгохыг хичээх
- Бэрхшээлтэй шууд тулах
- Хүн рүү дайрахгүй байх
- Асуудал шийдвэрлэхийн төлөө ажиллах – Эхлээд учир шалтгааныг судлаад, шийдвэрлэх арга замуудаас боломжит арга барилыг сонгоно.
- Ойлгож байгаагаа илэрхийлэх
- Бодит баримт нотолгоо, үндэслэлтэй үед байр сууриа өөрчлөхөд бэлэн байх
- Та болон харилцаж буй нөгөө талд аль алинд нийцсэн өөр хувилбар гаргах
- Тууштай байх

Ашигласан материал

Монгол хэлээр

- БСШУСЯ. Боловсролын хүрээлэн. 2018. Дэлхийн иргэний боловсрол багшид зориулсан гарын авлага. Улаанбаатар.
- Энх тайвны замаар дэлхийг донсолгосон Махатма Ганди. 2017. Эх сурвалж: Нийслэл.мн сайтны Алдартны түүх булан. Хандсан холбоос: <http://www.niislel.mn/v/4562> 2022 оны 5 сарын 10-нд хандсан.
- Х.Өлзийбаяр. Малала Юсуфзай: Ганц хүн ч дэлхийг өөрчилж чадна Ардчилал таймс сонин. холбоос <https://www.infomongol.mn/a/162186> хандсан 2022 оны 5 сарын 10

Гадаад хэлээр

- A quiet transformation. <http://blog.sfusd.edu/2012/09/a-quiet-transformation.html>
- Mary Gavin. Simply peace: peaceful choices and activities for schools. https://www.peacefulschools.org.uk/download_file/view/91/206
- Cowan, Megan. Tips for teaching mindfulness to Kids. https://greatergood.berkeley.edu/article/item/tips_for_teaching_mindfulness_to_kids
- Center for wellness and Achievement in Education. <https://cwae.org/>
- Nonviolence & Conflict Management: An abridged training material with basic exercises. https://www.salto-youth.net/downloads/toolbox_tool_download-file-737/material
- Quakers in Britain. Teaching peace. <https://www.quaker.org.uk/resources/free-resources/teaching-resources-2>
- Peace education network. Teach peace pack. Updated edition. <https://www.peace-education.org.uk/teach-peace>
- Plant Love Grow. <https://www.plantlovegrow.com/>
- Romeral Ortiz Quintilla. 2018. Youth for peace. <https://www.coe.int/en/web/youth-peace-dialogue/programme-youth-peace-week-2020>
- Thich Nhat Hanh. 1992. Peace is every step: The Path of Mindfulness in Everyday Life
- UNESCO. 2001. Learning the way of Peace: A Teacher's guide to Peace Education. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000125228>
- Taylor O'Connor. Adolescents as a peacebuilder's toolkit for program planning and evaluation with the Peacebuilding

ГАРЧИГ

ЭНХ ТАЙВАН БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ

Сургагч багшид зориулсан сургалтын модуль	5
Багшид зориулсан сургалтын модуль	39
Үе тэнгийн сургагчийн сургалтын модуль	79



#ESDfor2030

